



Нэгдсэн Үндэстний Байгууллагын
Болдворол, шинжлэх ухаан,
совлын байгууллага



"Глоб Интернэшнл төв"
төрийн бус байгууллага

ХҮЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ: САЙН ТҮРШЛАГЫН ГАРЫН АВЛАГА

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын
Бээжин дэх Төлөөлөгчийн газраас 2013 онд эрхлэн гаргав.

Хаяг: Waijiaogongyu 5-15-3, Jianguomenwai Compound
Beijing, P.R.China

© UNESCO 2013

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан
All rights reserved


ISBN 978-92-3-001135-2

Community Media: A Good Practice Handbook
НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас 2011 онд эрхлэн гаргав.

Монгол хэлнээ
Хөрвүүлсэн: Т.Аюушжав Д.Мөнхбүрэн
Нягтлан шүүсэн: Х.Наранжаргал

“Глоб Интернэшнл” ТББ Монголын хүйн радиогийн холбоо
ЧД, 6 хороо, Дипломат 95 цогцолбор, 5 орц, 59 тоот

Гарын авлагыг хэвлүүлэхэд туслалцаа үзүүлсэн:



Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

Энэхүү гарын авлагын зохиомж, сонгосон материал нь ЮНЕСКО-гийн үзэл баримтлалыг илэрхийлэхгүй тул аливаа улс орон, газар нутаг, хот суурин, бүс нутаг, тэдгээрийн засаг захиргааны халдашгүй эрх болон хил хязгаарын дархан байдлыг хөндөх ямар нэгэн санаа агуулаагүй болно.

Энэхүү гарын авлагад оруулахаар сонгосон материал, жишээ баримт болон тэдгээрээр дамжуулан илэрхийлсэн санал, санаачлагын төлөө зохиогч хариуцлага хүлээнэ. Тиймээс зохиогчийн эдгээр материал, баримт, санал нь НҮБ-ын баримталж буй бодлого, зарчим болон ЮНЕСКО-гийн үзэл баримтлалтай нэг бүрчлэн дүйж байх шаардлагагүй болно.

График дизайн: Мазоер Аурелиа
Хавтасны дизайн: Мазоер Аурелиа

Фото болон бусад зургуудын зохиогчийн эрх:

x.13: © UNESCO
x.15: Logo Courtesy of Danish Agency for Libraries and Media
x.17: Courtesy of CORAPE
x.19: Courtesy of ARPAS
x.21: Logos Courtesy of CNRA and SNRL
x.23: Courtesy of CNRA
x.24: © UNESCO
x.25: Courtesy of MDDA
x.27: Courtesy of CPMR
x.29: Courtesy of Paula Castello
x.31: Logo Courtesy of Canstream
x.37: Courtesy of 3CR Community Radio
x.39: © UNESCO
x.41: Courtesy of Radio Tierra
x.43: Courtesy of Archivo Aredmag
x.45: Courtesy of Sangham Radio

x.47: Courtesy of AmmanNet
x.49: Courtesy of Radio La Primerhsima
x.51: Courtesy of Steve Buckley
x.53: Courtesy of Archive of Radio Student, Ljubljana, Slovenia
x.55: © UNESCO
x.61: © UNESCO
x.63: Courtesy of Franz G. Laime P.
x.65: Courtesy of One Plus One (Beijing) Disabled Persons' Cul-tural Development Centre
x.67: Courtesy of FemLINKPacific
x.69: Courtesy of COMBINE Resource Institution
x.71: Courtesy of Wadi
x.73: Courtesy of Earle McLeary
x.75: Courtesy of Junichi Hibino and Radio FMY
x.77: © UNESCO
x.79: Courtesy of Radio Rakambia

АГУУЛГА

АГУУЛГА	3
ТАЛАРХАЛ	4
ӨМНӨТГӨЛ	5
ТАНИЛЦУУЛГА	7

ХҮЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ НЬ 9

БЕНИН УЛС: Хэвлэл мэдээллийн зохицуулалтын Баруун Африкийн загвар	13
ДАНИ УЛС: Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн өргөтгөсөн бодлого	15
ЭКВАДОР УЛС: CORAPE - Хүйн радиогийн үндэсний нэгтгэл	17
ЭЛЬ САЛЬВАДОР УЛС: ARPAS - Сүлжээ байгуулах боломж олгосон долгион	19
ФРАНЦ УЛС: FSER - Арилжааны бус, нутгийн радиог дэмжих сан	21
НЕПАЛ УЛС: ACORAB - хүйн радиогийн салбарыг хамгаалж буй нь	23
ӨМНӨД АФРИК УЛС: MDDA - хэвлэл мэдээллийн санхүүжилт ба олон талт байдал	25
ТАЙЛАНД УЛС: CPMR - Хэвлэл мэдээллийн шинэтгэлийн төлөө иргэний нийгмийн аян	27
УРУГВАЙ УЛС: Хүйн өргөн нэвтрүүлгийн тэгш хүртээмж	29
НЭГДСЭН ВАНТ УЛС: Canstream - интернет өргөн нэвтрүүлэг хялбарчилсан нь	31

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ 33

АВСТРАЛИ УЛС: ZCR - ард түмний хүч	37
БУРУНДИ УЛС: Гихетагийн СМС - энх тайван, хөгжлийг хөхиүлэн дэмжих нь	39
ЧИЛИ УЛС: Тиепа (Radio Tierra) радио нь нийгмийн хөдөлгөөнд үндэслэгдсэн	41
КОЛУМБ УЛС: AREDMAG - зөрчилдөөний үед хэвлэл мэдээллийг хамгаалах нь	43
ЭНЭТХЭГ УЛС: Сангхам радио (Sangham Radio) нь гадуурхагдагсдын дуу хоолойг хүргэх нь	45
ЙОРДАН УЛС: Аль-Балад (Radio Al-Balad) - интернет - эхлэх цэг болох нь	47
НИКАРАГУА УЛС: Ла Примерисима (La Primerisima) бол ард түмэн эзэмшдэг мэдээний радио	49
СЕНЕГАЛ УЛС: Ндеф Ленг (Radio Ndef Leng) радио нь сонсогчдод ярих боломж олгодог	51
СЛОВЕНИ УЛС: Студент радио (Radio Student) - хараат бус бөгөөд конформист (аялдан дагах) бус	53
УГАНД УЛС: Апак радио (Radio Apac) - нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулахад тусалдаг	55

НИЙГМИЙН ҮР НӨЛӨӨГ БЭХЖҮҮЛЭХ НЬ 57

БЕЛИЗ УЛС: Хамалали Гаринагу радио (Radio Hamalali Garinagu) нь Гарифуна соёлыг хамгаалах нь	61
БОЛИВ УЛС: Винай Жата радио (Radio Winay Jatha) - аймара эмэгтэйчүүдийн дуу хоолой	53
ХЯТАД УЛС: Нэг дээр нэмэх нь нэг (One Plus One) - бидэнгүйгээр бидний тухай зүйл үгүй	65
ФИЖИ УЛС: ФемТОК (femTALK) - эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх хөдөлгөөнт радио	67
ИНДОНЕЗИ УЛС: ARNet - туйлдсан ард иргэдийг нөхөн сэргээх нь	69
ИРАК УЛС: Данге Нве радио (Radio Dange Nwe) - энх тайван, яриа хэлэлцээний дуу хоолой	71
ЯМАЙК: FREE FM (Чөлөөт FM) - шоронгийн ханан дотроос	73
ЯПОН УЛС: FMҮҮ радио хүн төрөлхтний янз бүрийн байдлыг онцлон тэмдэглэдэг	75
МОЗАМБИК УЛС: Хүйн радио ба сонгуулийн сурвалжлага	77
ТИМОР-ЛЕСТЕ УЛС: Ракамба радио (Radio Rakambia) - шинэ улсыг бүтээн босгож буй залуусын дуу хоолой	79

ТАЛАРХАЛ

Стив Баклигийн эмхэтгэж, хянан тохиолдуулсан энэхүү гарын авлага бол хамтын хүчин чармайлт юм. Гарын авлагад хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст бид талархал илэрхийлж байна. Ялангуяа, жишээнүүдийг олж судалсан Розамонд Браун (Белиз, Колумб, Эль Сальвадор, Никарагуа, Ямайка улс), Франклин Хуйзиес (Бурунди, Мозамбик, Өмнөд Африк, Уганд улс), Лумко Мтимдэ (Бенин, Непал улс), Ашиш Сэн (Хятад, Фижи, Энэтхэг, Индонез, Ирак, Япон, Йордан, Тимор-Лесте улс) нарт гүнээ талархаж байна. Ийнхүү дурьдсан дээр нэмэн, 2009 оны хоёр, есдүгээр сард тус тус зохион байгуулагдсан шинжээчдийн зөвлөлдөх уулзалтаар уг гарын авлагын хүрээг тогтоох, сайн туршлагын жишгийг тодорхойлоход хувь нэмрээ оруулсан Санжай Астана, Флоренцио Себалос, Брюс Жирард, Алфонсо Гумуцио Дагрон, Рагу Майнали, Иан Прингл, Салватор Скифо С.Сэнтилкумаран, Фатумата Соу, Лусио Н.Табин болон Жо Ан Такхи нарт талархаж байна.

ЮНЕСКО, Дэлхийн хүйн радио өргөн нэвтрүүлгийн холбоо (AMARC)-ноос хамтран 2009 оны 11-р сарын 11-ний өдөр Франц улс дахь ЮНЕСКО-гийн төв байранд зохион байгуулсан хүйн хэвлэл мэдээллийн олон улсын семинарын үр дүн гарын авлагад мөн хувь нэмэр болж, тусгалаа олсон билээ. “Хүйн хэвлэл мэдээллээр дамжуулан дуу хоолойгоо хүргэж, хүчирхэгжүүлэх нь: сайн туршлага, хөгжлийн стратеги” сэдвийн дор болсон энэ семинарт хүйн хэвлэл мэдээллийн 30 гаруй тэргүүлэх шинжээч, ажилтан, оролцогч талын төлөөлөл хүрэлцэн ирсэн юм.

Шинжээчдийн зөвлөлдөх уулзалт, гарын авлагыг бүтээх ажлыг Вижаянандагийн удирдамжийн дагуу Клаудиа Мангелсийн тусламжтайгаар Хара Пади удирдан зохион байгуулсан билээ.

Эцэст нь, бид энэ гарын авлагад өгүүлж буй урамтай сайхан ажлыг гүйцэтгэгч, сайн туршлагын эзэд болох хүйн хэвлэл мэдээллийн төслүүд, бусад байгууллагын удирдлага, ажилтан, сайн дурынханд халуун алга ташилтаар талархлаа илэрхийлье.

ӨМНӨТГӨЛ

Хүйн хэвлэл мэдээлэл нь олон ургальч хэвлэл мэдээллийн аливаа орчны гол бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ нь олон нийтийн болон арилжааны хэвлэл мэдээллээс ялгарах хэрэгслийн хувьд иргэдийн оролцоонд чухал орон зайг эзэлнэ. Дэлхий даяар чухамхүү хүйн хэвлэл мэдээлэл л иргэдийн оролцоог амьд болгодог гэдгийг энэ гарын авлагад багтсан жишээнүүд нотолно.

Хүйн хэвлэл мэдээлэл нийгэмд үр нөлөө үзүүлдэг нь эргэлзээгүй. Янз бүрийн санаачилгууд ард иргэдийг хөгжүүлэх, хүчирхэгжүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулж байгаа тухай жишээ энд олноор дурдагдсан байгаа. Фижи улсын “femLINK” радио эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлсний жишээ юм. Индонезийн AR-Net (Aceh Nias Reconstruction Radio Network) радио сүлжээ 2004 онд болсон Энэтхэгийн далайн цунамигийн хор хөнөөлийн туйлдсан ард иргэд хүй олны хүчээр хэрхэн сэргэн өндийсөн, сэргээн босголт хэрхэн хийгдсэний тодорхой жишээ болно.

Сенегалийн “NDe Leng” радио нь идэвхитэй харилцан яриа, хэлэлцүүлгийг шууд нэвтрүүлдэг нь өөрийнхөө нутаг оронд ийнхүү өөр хоорондоо харилцах нь цөөнхийн бүлгийг хэрхэн зоригжуулж, нутгийн болон үндэсний мэдрэмж хэрхэн төрүүлдгийн нэг жишээ юм.

Хүйн хэвлэл мэдээлэл нийгэмд үр нөлөө үзүүлдэг тухай эдгээр баримтыг өөр газрын адил төстэй жишээнүүдтэй нэгтгэн харваас харилцааны альтернатив хэлбэрийн ач холбогдол улам ч томруун харагдана.

Гэхдээ, энд өгүүлсэн жишээнүүд нь, ийм үр нөлөө бүхий хэрэгсэл цэцэглэн хөгжихөд хоёр

чухал нөхцөл шаардлагатай болохыг илтгэнэ. Нэгд, бодлогын орчин байх, хоёрт, түүний бие даасан, үр ашигтай байдлыг тасралтгүй ханган баталгаажуулах тогтвортой байдлын загвар байх ёстой. Энэ утгаар бол ашигтай сур-гамжийг олж харахад уг гарын авлага бидэнд тусална. Чухал дүгнэлт болгон хэлэхэд, бодлого, эрх зүй, зохицуулалтын сайн туршлага дэлхий даяар хангалттай байдаг ч гэсэн чухамхүү энэ нь хүйн хэвлэл мэдээллийг тогтвортой дэмжихэд тулгардаг цорын ганц, хамгийн бэрхшээлтэй саад тотгор хэвээр л байна.

Асуудал бэрхшээлийг цохон дурдахын зэрэгцээ тэдгээрийг шийдвэрлэх боломжийг санал болгож буй нь энэхүү номын үнэ цэнэ юм. Ардчилсан аливаа нийгэмд хүйн хэвлэл мэдээлэл хэрхэн яаж чөлөөт, хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийн тогтолцоон дахь бүр илүү үр ашиг бүхий бүрэлдэхүүн хэсэг болж буй нь цаг хугацаагаар шалгагдсан юм. Ийм шийдвэрүүдээс санаа аван, туршиж үзэх боломжийг энд толилуулж байна.

Энэ бүхнийг дурдахын сацуу уг ном нь хүйн хэвлэл мэдээллийн ажилтан, шийдвэр гаргагч, судлаач, ард олонд үйлчилдэг байгууллагууд, хэвлэл мэдээллийн хөгжлийг сонирхогч талуудад хэрэгтэй эх сурвалж болно гэдэгт бид итгэж байна.

Вижаянанда Жаявера

ЮНЕСКО-гийн Харилцаа холбооны
хөгжлийн албаны захирал
Парис хот

ТАНИЛЦУУЛГА

Энэ бол хүйн хэвлэл мэдээллийн сайн туршлагын жишээнүүдийн түүвэр бөгөөд хүйн хэвлэл мэдээллийн нөлөөллийн ажил хийж буй хүмүүст дэмжлэг үзүүлэх, зоригжуулах, бодлого боловсруулагч, бусад талуудад хүйн хэвлэл мэдээллийн тухай ойлголт өгөх, нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх зорилготой болно. Уг түүвэр нь радио, телевиз, интернет, гар утас зэрэг электрон хэвлэл мэдээлэлд анхаарлаа төвлөрүүлсэн билээ. Үүнд дэлхий нийтийг хамруулан 30 орны жишээг багтаасан боловч дийлэнх нь хөгжиж буй орны туршлага юм. Хөгжиж буй орнуудын хэвлэл мэдээллийн салбарт өнөөдөр радио давамгайлдаг, хөдөө орон нутаг, төв суурин газарт ч хүртээмжтэйгээс энэ нь үүдэлтэй.

Хүйн хэвлэл мэдээлэл нь хараат бус, нийгмийн ашиг тусын төлөө ашиг үл горилон үйл ажиллагаа явуулдаг, иргэний нийгэмд суурилдаг гэдэг нь энэхүү түүврээс ойлгогдоно. Эдгээр нь нийгмийн хөдөлгөөн, хүйн холбоо бүхий ард иргэдэд суурилсан байгууллагуудын хувьд тэдний өмнө тулгарсан асуудал, санаа зовниж буй зүйл, соёл, хэлний илэрхийлэл болон дэлхийн бүхий л бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг. Хүйн хэвлэл мэдээлэл нь, байнга засгийн газрын хяналтанд байдаг үндэсний, олон нийтийн өргөн нэвтрүүлэг, мөн хувийн, арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгсэл аль алинд нь альтернатив байхаар байгуулагддаг. Тэдгээр нь нутгийн ард иргэдийн дуу хоолой болж, тэдний мэдээлэлтэй байх бололцоог хүртээмжтэй болгож, хүй олны түвшинд хэлэлцүүлэг өрнүүлэх, мэдээлэл мэдлэгээ хуваалцаж, нийтэд хамаатай шийдвэр гаргахад хувь нэмэр оруулдаг.

Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн туйлын шаардлага нь улс төрийн өргөн хүрээний өөрчлөлт, ялангуяа ардчиллыг гүнзгийрүүлэх, иргэний нийгмийг бэхжүүлэхтэй байнга холбогдоно. Хүйн хэвлэл мэдээлэл нь ядуу, шоовдорлогдсон иргэдийн дуу хоолойг хүргэх, тэднийг хүчирхэгжүүлснээр хөгжлийн зорилгоо илүү үр дүнтэй биелүүлэхэд чухал хэрэгсэл болох нь хүлээн зөвшөөрөгдсөн юм. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй газруудад тэдгээр нь олон нийтийн оролцоог хөхиүлэн дэмжих, соёл, хэлний олон талт

байдлыг бэхжүүлэх, ядуу, эмзэг бусад бүлгүүдийн дуу хоолойг хүргэхэд онцгой хийгээд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.

Орчин үеийн хүйн хэвлэл мэдээллийн хөдөлгөөн анх 1940-өөд онд үүссэн түүхтэй. Тэгэхэд Боливи улс дахь цагаан тугалганы уурхайчдад зориулсан хүйн радио, Колумби улсын католик сүмийн боловсролын радио, АНУ-д арилжааны бус богино долгионы (FM) радио байгуулагджээ. Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд нутгийн иргэдэд зориулсан, алдартай, ардын радиогийн тоо Америк тив даяар асар ихээр нэмэгджээ. Эдгээрт, албан боловсролын бүтэц болон түүнд багтдаггүй боловсролын радио станцууд, нутгийн хэл, уламжлалд анхаарлаа төвлөрүүлдэг уугуул иргэдийн радио станцууд, нийгмийн хөдөлгөөний байгууллага, эмэгтэйчүүдийн бүлэг, сүм, үйлдвэрчний эвлэлийн ажиллуулдаг радио станцууд багтана.

Европ тивд хүйн хэвлэл мэдээлэл нь саяхнаас түлхүү хөгжих болжээ. Хүйн сонин хэвлэл нь урт түүхтэй, харин хамгийн анхны электрон хүйн хэвлэл мэдээллийг оюутны радио гэж болно. “Student” радио 1967 онд Словени улсад анх өргөн нэвтрүүлгээ цацаж эхэлжээ. 1977 онд Италид Дээд шүүх нь төрийн монополийг хууль бус гэж тогтоосны дараа агаарын долгион нээлттэй болсон байна. Дараа нь 1983 онд Франц улс үүнийг дагаснаар, Баруун Европын дийлэнх улс хүйн өргөн нэвтрүүлгийн нарийвчилсан зохицуулалттай болжээ. Зүүн Европод 1990-ээд онд улс төрийн өөрчлөлт гарсан хэдий ч иргэний нийгэм нь радио долгионыг жинтэй ашигладаг улс орны тоо цөөн хэвээр байгаа юм. Эхэн үедээ Европод хүйн өргөн нэвтрүүлгийн хөдөлгөөний үүсэл нь богино долгионы радио эрхлэхэд тусгай зөвшөөрөл эзэмших шаардлагагүй байсантай холбоотой бөгөөд зохицуулалтын хүрээ хожим нь бий болжээ. Өнөөдөр шинэ хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд интернет чухал талбар болж байна.

Африк тивд гэвэл 1990-ээд оны эхэн хүртэл колончлолын хэв маяг хадгалагдан, төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийн монополь байдал хэвийн хэвээр байхын зэрэгцээ сонин

хэвлэлийн тоо ширхэг хязгаарлагдмал, хотын боловсролтой элит бүлгүүдэд зориулагддаг байв. Дарангуйлагч олон засгийн газар эрх мэдэлтэй хэвээр, эдийн засгийн уналт үргэлжилж байсан хүйтэн дайны төгсгөл үеэр эрчимжиж эхэлсэн нийгмийн идэвх нь улс төрийн эрх чөлөөний төлөө шинэчлэгдсэн хүсэл зоригийг тээгч ардчиллын давалгаа болон өргөжиж, илүү олон ургальч, ардчилсан хэвлэл мэдээллийн салбар туйлын шаардлагатай болсон юм. Ийм хөгжлийн тэргүүлэгч нь Мали, Өмнөд Африк улс байлаа. Мали улсад өргөн нэвтрүүлэг 1991 оны хувьсгалын дараа нээлттэй болсон. Хүн бүр хүсэлт гаргаж, тусгай зөвшөөрөл эзэмших эрхтэй болов. Өнөөдөр тэнд олон нийтийн болон улс төрийн дэмжлэг бүхий хөдөөгийн 100 гаруй жижиг хүйн радио ажилладаг. Баруун Африкийн бусад орон ч энэ жишээг дагах болжээ. Арьс өнгөөр ялгаварлах үзэл гaarч байсан Өмнөд Африкт хүйн радиог, өмнө нь агаарын долгион ашиглаж чаддаггүй байсан дийлэнх олныг хүчирхэгжүүлэх арга хэрэгсэл гэж үзэж байлаа. Өмнөд Африкийн хүйн радио нь төрийн болон арилжааны радиогийн зэрэгцээ гуравдагч хэвлэл мэдээллийн тодорхой статустай ба 100 гаруй хүйн радио тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Австралид 1972 онд Аделей хотод 5UV радио байгуулагдсанаар хүйн өргөн нэвтрүүлэг эхэлсэн ба одоо тухайн улсын өргөн нэвтрүүлгийн бодлого, хууль тогтоомжид албан ёсоор тусгагдсан байна. Ази, Номхон далайн бусад бүс нутагт хүйн өргөн нэвтрүүлэг шинэвтэр бөгөөд анх 1991 онд Зүүн Өмнөд Ази, Филиппин улсад хэрэгжсэн Тамбули төслийн хүрээнд тосгонд суурилуулсан чанга яригч ашиглах санаачилгаар эхлэлээ тавьж, одоо Индонези, Тайланд улсад хэдэн зуун хүйн радио ажиллаж байна. Непал улсад 1997 онд Сагарматха радио байгуулагдсан нь Өмнөд Ази дахь анхны хараат бус хүйн өргөн нэвтрүүлэгч болсон бол Энэтхэг улсад хүйн радиогийн бодлого батлагдахыг 2006 он хүртэл хүлээж, хүчин төгөлдөр болсноос нь хойш төрийн бус байгууллагуудад өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгож эхэлснээр биелэлээ олсон юм.

Интернет нь хэвлэл мэдээллийн салбар дахь

талбар болсноороо хүйн хэвлэл мэдээллийн боломж, практикт жинтэй нөлөө үзүүлж, радио долгионы давтамж ашиглахгүйгээр хэвлэл мэдээллийн агуулга түгээх завшаан нэмэгдсэн юм. Интернетийн түгээлт нь Аль-Балад радио (өмнө нь AmmanNet Community Radio гэдэг байсан)-д 2000 онд Йордан улсад цахим хуудас, сансрын дамжуулалтад суурилан өргөн нэвтрүүлэг эхлэх боломж олгосон байна. Харин хожим нь хэвлэл мэдээлэл дэх шинэтгэлийн дараа л богино долгионы тусгай зөвшөөрөл авчээ. Тун саяхан, Хятадад “Нэг дээр нэмэх нь нэг” (One Plus One) хэмээх хараат бус төрийн бус байгууллага Бээжингийн Паралимпийн үеэр эрхтний бэрхшээлтэй иргэдэд зориулсан цахим хэвлэл мэдээллийн талбартай болсон ба зорилтот сонсогчдынхоо хэрэгцээ, сонирхолд нийцсэн, үнэ цэнэ бүхий үйлчилгээ үзүүлж байна.

Энэхүү түүвэрт янз бүрийн бүс нутаг, соёл, хэл, улс төрийн тогтолцоогоороо өөр өөр, жижиг, том улсууд, хот, хөдөөгийн жишээг хамруулсан нь геополитикийн утгаараа өргөн хүрээтэй болсон юм. Иргэдийн эзэмшил, оролцоо, мөн чанарын хувьд шинэлэг, эсвэл өвөрмөц, түүнчлэн эх сурвалж нотолгоотой, эсвэл итгэлтэй зэргээс үл хамааран, тохируулан хэрэглэж болохуйц байх, уялдаа холбоотой байх, тогтвортой байдал зэрэг нь сайн туршлагын жишээнүүдийг сонгох шалгуур үзүүлэлт болсон юм.

Түүвэр нь гурван хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр хэсэгт, хүйн хэвлэл мэдээллийн таатай орчин бүрдүүлэх, тухайлбал бодлого, эрх зүй, зохицуулалт, санхүүжилт болон хүйн хэвлэл мэдээлэл байгуулах, цэцэглэн хөгжих орчин бүрдүүлэхэд дэмжлэг болохуйц бүтцийг багтаан арван улсын сайн туршлагын жишээ оруулав. Хоёр дахь хэсэгт, хүйн хэвлэл мэдээллийн чанарын тогтвортой байдалд анхаарч, урт удаан хугацаанд оршин тогтнох, тууштай байх, зохицох чадвар гэх мэт онцлог шинжийг харуулсан арван жишээг дурдав. Гурав дахь хэсэгт, хүйн хэвлэл мэдээллийн нийгэмд үзүүлэх үр нөлөөний тухай авч үзсэн бөгөөд нийгмийн өөрчлөлт, амьдрал, амьжиргааг дээшлүүлсэн, зөрчилдөөний үе дэх нийгмийн уялдаа холбоо, хүмүүнлэгийн

хамгаалалт, засаглал, хариуцлагыг бэхжүүлсэн, ардчилал, хөгжилд оролцоог нэмэгдүүлсэн, ялгаварлан гадуурхалтыг багасгасан болон бусад ашиг тусын тухай өгүүлсэн арван жишээ орсон юм.

цуулгатай, дараагийн агуулгаа илэрхийлсэн товч тодорхойлолт, онцлог шинжүүдийг хураангуйлсан болно. Дэлгэрэнгүй мэдээлэл хүссэн хүмүүст зориулан эх сурвалж, цахим холбоосуудыг заасан байгаа.

Жишээ бүр сайн туршлагын тухай товч танил-



ХҮЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ НЬ

ХҮЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ НЬ

Дэлхий даяар хүйн өргөн нэвтрүүлгийг хүлээн зөвшөөрөх нь элбэг болсон хэдий ч өөрсдөө хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслээ эзэмших, ажиллуулах эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах хэрэгцээ шаардлага байсаар байна. Бодлого, эрх зүй, зохицуулалтын хүрээ нь өнөө хэр хүйн хэвлэл мэдээлэл байгуулахад тулгарч буй цорын ганц бэрхшээл хэвээр байна. Үүний тулд чухам ямар нөхцөл шаардлага хэрэгтэй байгааг харж болохуйц бодлого, эрх зүй, зохицуулалтын дэлхийн туршлага өнөөдөр бэлхнээ байна. Гэвч олон улс оронд хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулах, цэцэглэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц бодлого, эрх зүй, зохицуулалтыг бий болгох шаардлагатай байгаа юм.

Хүйн хэвлэл мэдээллийн орчинг бүрдүүлэх асуудлыг улс төрийн өргөн агуулгын хүрээнд авч үзэх ёстой. Ардчилал, хууль дээдлэх ёс сул, хүний эрх, ялангуяа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үл хүндэтгэдэг тийм нөхцөлд хүйн хэвлэл мэдээлэл нь онцгой сорил бэрхшээлтэй тулгардаг. Ардчиллыг гүнзгийрүүлэх, нийтийн ашиг сонирхлыг дээдлэх үүднээс чөлөөт, хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийг хөгжүүлэхийг хүлээн зөвшөөрсөн нөхцөлд л хүйн хэвлэл мэдээллийн орчин таатай болно. (Buckley et al.2008)¹ Дэлхийн хүйн радио өргөн нэвтрүүлгийн холбоо (AMARC)-ноос хүйн өргөн нэвтрүүлгийн ардчилсан хууль тогтоомжийн сайн туршлагын 14 зарчим (AMARC-ALC-2008) боловсруулан гаргасан юм. Энэ нь цаашдаа хууль тогтоогч, идэвхтэнүүдийг хууль тогтоомж боловсруулахад нь чиглүүлэх загвар юм.

Хүйн хэвлэл мэдээллийн хөгжлийн орчныг бүрдүүлж буй бодлого, эрх зүй, зохицуулалт нь түүнийг хүлээн зөвшөөрөх, хүртээмжтэй болгох, дэмжлэг үзүүлэх гэсэн үндсэн гурван шинж чанарыг агуулдаг. Эхнийх нь хүйн хэвлэл мэдээллийг өвөрмөц салбар гэж аливаа хоёрдмол утгагүйгээр тов тодоор

хүлээн зөвшөөрөх асуудал юм. Хүйн хэвлэл мэдээллийн үндсэн шинжийг нэгтгэн дүгнэвэл, ашгийн төлөө бус ажиллах хэдий ч хүй олны ашиг тусын төлөө байгаагаараа нийгэмд хожоотой, үйлчилгээгээ зориулж буй тэр хүмүүс нь эзэмшиж, хариуцлага хүлээдэг, агуулга туурвих, удирдахад нь оролцдог. Хоёрт, эрх зүй, зохицуулалтын тогтолцооны тухай асуудал бөгөөд энэ нь радио долгионы хүртээмжийн шууд, ил тод үйл явц, хүйн хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд шаардлагатай түгээлтийн арга хэрэгслээр хангахад оршино. Долгион болон бусад нөөцийн хуваарилалт хүй олонд суурилсан байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн байх ёстой. Энэ нь хүйн хэвлэл мэдээллийн үйлчилгээгээр хангах тэрхүү хүй олныг шаардлагагүй саад тоггороос чөлөөлөх, ангид байлгах, мөн үйл явцыг улс төрийн хөндлөнгийн нөлөөгүй этгээд удирддаг байх гэсэн үндсэн шинжүүдээр тодорхойлогдоно. Гуравт, хүйн хэвлэл мэдээллийн тогтвортой байдал, хөрөнгийн нөөцтэй холбоотой эрх зүй, зохицуулалтын асуудал юм. Долгионы хүртээмжийн хувьд гэвэл тусгай зөвшөөрлийн хураамжаас чөлөөлөх, эсвэл хураамж бэлэг тэмдэг төдий байх ёстой бөгөөд хүй олонд хэд хэдэн нөөц ашиглахыг хориглож үл болно. Орлогын эх үүсвэрт үндэслэлгүй хязгаарлалт тогтоож болохгүй. Хүйн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийг үйлчилгээгээ зориулж буй тэр иргэдээс эдийн засгийн дэмжлэг хүсэхийг дэмжихийн зэрэгцээ төсвийн санхүүжилтийг хараат бусаар захиран зарцуулах механизмын дагуу тусламж үзүүлнэ.

Эдгээр шинж чанар нь олон орны хүйн өргөн нэвтрүүлгийн эрх зүй, зохицуулалтын хүрээнд багтсан байдаг хэдий ч үр дүнтэй хэрэгжиж чадахгүй бол сайн бодлого, эрх зүй, зохицуулалт дангаараа хангалтгүйг тэмдэглэвэл зохино. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулах, хөгжүүлэхийг дэмждэг, хөхиүлдэг тийм орчин бүрдүүлэхэд дахиад өөр хоёр бүрэлдэхүүн хэсэг чухал болдог. Эхнийх нь, хүйн хэвлэл мэдээллийн хөгжлийг

¹ Buckley, S., K.Duer, T.Mendel and S. O'Siochru (2008) *Broadcasting, Voice and Accountability: A public interest approach to policies, laws and regulations*, Ann Arbor: University of Michigan Press

хөхиүлэн дэмждэг; бодлого, эрх зүй, зохицуулалтыг сайжруулах лобби хийдэг, нөөцийг хуваарилдаг, тогтвортой байдлыг хангах, нийгэмд үзүүлэх үр нөлөөг бий болгохын төлөө хүйн хэвлэл мэдээллийн салбарт тусламж, үйлчилгээ үзүүлдэг тийм иргэний нийгэмд суурилсан нөлөөллийн бүлэг, төлөөллийн эвлэл холбоод бий эсэх нь чухал. Хоёрт, сонгогдсон төлөөлөгчид, төрийн албан хаагч, зохицуулагч болон хэвлэл мэдээллийн зохистой бодлого, хууль тогтоомж, зохицуулалтыг боловсруулдаг, эсвэл хэрэгжүүлдэг бусад хүмүүсийн дэмжлэг чухал юм.

Гарын авлагын энэ хэсэгт хүйн хэвлэл мэдээллийн хөгжлийг дэмжиж, хөхиүлдэг зарим бодлого, эрх зүй, зохицуулалт, мөн олон нийтийн буюу төрийн санхүүжилтийн механизмын тухай тодотгон өгүүлэхээс гадна хэвлэл мэдээллийн бодлогын шинэтгэл, мөн хүйн хэвлэл мэдээллийн салбарыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан тус салбарын холбоод, бусад этгээдийн жишээг багтаав. Бенин, Уругвай улс нь хүйн радиогийн хөгжлийг дэмждэг хууль, зохицуулалттай. Бенин улс нь Африктаа хараат бус зохицуулалтын шилдэг загварын нэг болохыг тэмдэглүүштэй. Харин Уругвай бол хүйн, хувийн, олон нийтийн өргөн нэвтрүүлэгчдийн хооронд давтамжийг ил тодоор тэнцвэртэй хуваарилдаг цөөн орны нэг юм. Дани, Франц, Өмнөд Африкийн төрийн санхүүжилт олгодог механизмын жишээ энд мөн орсон. Дани улсад олон нийтийн өргөн нэвтрүүлгийн тогтолцоог дэмжихийн тулд айл өрхүүдээс авдаг тусгай зөвшөөрлийн хураамжийн нэг хэсгийг хүйн өргөн нэвтрүүлгийг дэмжихэд зориулдаг байна. Францад бол арилжааны

бус орон нутгийн радиогийн санхүүгийн дэмжлэг нь арилжааны өргөн нэвтрүүлгийн орлогод ногдуулсан татвараас бүрэлддэг ажээ. Өмнөд Африкт Хэвлэл мэдээллийн хөгжил, олон талт байдлын агентлаг нь холимог загвар ашигладаг бөгөөд тухайлбал, хувийн болон олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийн аль алиных нь хувь нэмрээс бүрддэг санд төвлөрүүлсэн хөрөнгөөр хүйн өргөн нэвтрүүлэг, бага хэмжээний арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дэмжлэг үзүүлдэг байна. Непал улсын Хүйн радио өргөн нэвтрүүлгийн холбоо (ACORAB) нь улс төрийн ихээхэн сорилт бэрхшээлтэй тулгаран байж, хүйн хэвлэл мэдээллийн салбарыг хамгаалахад голлох үүрэг гүйцэтгэжээ. Эквадор улсад нийтийн боловсролын² радиогийн зохицуулах хороо (CORAPE) нь бодлого, эрх зүйн хувьд уг салбарыг хүлээн зөвшөөрөх, мөн дэмжлэгийн үйлчилгээний хүрээг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан байна. Тайландад идэвхтнүүдийг өргөн хүрээнд нэгтгэсэн “Хэвлэл мэдээллийн шинэтгэлийн төлөө аян” хүйн өргөн нэвтрүүлгийг хөхиүлэн дэмжих, түүнд зориулан долгионы давтамжийн нөөцийг хамгаалахад гол үүрэг гүйцэтгэсэн бол Эль Сальвадор улсад Эль Сальвадорын Орлоцоо бүхий радио, хөтөлбөрийн холбоо (ARPAS) нь өөрийн сүлжээнд нэгдсэн хүйн радио станцуудад давтамж хуваарилахын тулд үндэсний хэмжээнд давтамж худалдан авах стратегийн шийдвэр гаргасан ажээ. Их Британид Хүйн хэвлэл мэдээллийн холбоо (СМА) нь интернетээр өргөн нэвтрүүлэг дамжуулахад шуурхай дасан зохицоход нь зориулан гишүүддээ техникийн туслалцаа үзүүлсэн ажээ.

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- AMARC-ALC (2008) Principles for a Democratic Legislation on Community Broadcasting

http://amarcwiki.amarc.org/upload/documents/Principles_Community_Broadcasting_legislation.pdf

- Buckley, S., K.Duer, T.Mendel and S. O'Siochru (2008) *Broadcasting, Voice and Accountability: A public interest approach to policies, laws and regulations*, Ann Arbor: University of Michigan Press

² popular education - хялбаршуулсан байдлаар иргэдэд улс төр, нийгэм, эдийн засгийн мэдлэг олгодог хэлбэр (Орч.)



БЕНИН УЛС: Хэвлэл мэдээллийн зохицуулалтын Баруун Африкийн загвар

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бенин улсад өргөн нэвтрүүлгийг либеральчилж, хэвлэл мэдээллийн салбарт хувийн радио, телевиз, мөн хүйн олон нийтийн өргөн нэвтрүүлгийг нээлттэй болгосны дараа 1997 онд хүйн радио үүсч бий болжээ.

Тэнд одоо тусгай зөвшөөрөл бүхий 47 орчим хүйн радио, арилжааны бус бусад радио үйлчилгээ үзүүлж байна. Бенин улсад хүйн радиогийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, зохицуулалтыг хариуцаж, мөн хүйн радиод олгох тэтгэлгийг хамруулан, хэвлэл мэдээллийг дэмжих хөрөнгийг захиран зарцуулдаг хараат бус зохицуулагч ажилладаг.

Бенин улсад 1990 оны Үндсэн хуулиар үг хэлэх эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан бөгөөд 1992 онд байгуулагдсан Haute Autorite de l'Audiovisuel et de la Communication (НААС) хэмээх хараат бус зохицуулалтын байгууллага эрх чөлөөг хамгаалдаг. НААС нь дуу, дүрс бичлэгийн салбарыг либеральчлан, хувийн радио, телевизийн үйлчилгээг нээлттэй болгосон 1997 оны наймдугаар сарын 20-ны өдрийн 97-010 тоот хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

НААС нь арилжааны болон арилжааны бус радиогийн ялгааг тогтоож, арилжааны бус радиогийн үйлчилгээний журам, тусгай зөвшөөрөл олгох шалгуур зохицуулалтын удирдамж (Cahiers des Charges)-ийг боловсруулан мөрддөг. НААС-ын шаардлагын дагуу хүйн радионууд нь ашгийн бус нийгэмлэг хэлбэрээр зохион байгуулагдах

бөгөөд нутгийн иргэдийн төлөөллөөс бүрдсэн гүйцэтгэх эрх мэдэл бүхий удирдлагын хороо байгуулна. Энэ нь ерөнхийдөө хүй олны байгууллагууд, эмэгтэйчүүдийн бүлэг, бусад байгууллагын гишүүдээс бүрддэг.

НААС нь хүйн радиог ашгийн бус статусаас гадна радиогийн хамрах хүрээ, тодорхой нэг хүй олонд чиглэсэн, тодорхой нэг хэл хэрэглэдэг, орон нутгийн мэдээлэл, иргэдийг идэвхжүүлэх, соёлын хөгжил, цаашдын боловсролд нь чиглэсэн нэвтрүүлгийн хөтөлбөртэй эсэхээр нь хүйн радио гэж хүлээн зөвшөөрдөг байна. Хүйн радиод тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь НААС-аас давтамжийн төлөвлөлтөд тулгуурласан боломжит давтамжийн жагсаалтыг нийтлэх, олон нийтийн, хувийн, арилжааны бүхий л салбараас өргөдөл хүлээн авах уралдаан

зарлахаас эхэлдэг байна. Үйл явц нь өргөдлийг хүлээн авч хянан, хөтөлбөрийн агуулга, санал болгож буй үйлчилгээ хэрэгжих боломжтой эсэхэд тулгуурлан давтамжийг хуваарилна.

Долгионы давтамж хүссэн өргөдлүүдийг НААС, өргөдөл гаргагчид, олон нийтийн төлөөллийг байлцуулан олны өмнө ил тод шалгаруулдаг.

НААС нь Бенин улсын Сэтгүүлчдийн холбоо (Association des Journalistes du Benin)-ны Ёс зүйн дүрмийн биелэлтэд хяналт тавьж, "Хэвлэл мэдээллийн ёс зүйн ажиглагч" (Observatoire de la Deontologie dans les Medias) өөрийн зохицуулалтын байгууллагатай хамтран ажиллаж, өргөн нэвтрүүлгийн агуулга нь мэргэжлийн хэм хэмжээ, ёс зүйд

нийцсэн эсэхийг нягталдаг. Энэ нь сануулга өгөх, сарын хугацаагаар үйл ажиллагааг түр зогсоох, тусгай зөвшөөрлийн хугацааг богиносгох, эсвэл долгионыг цуцлах зэрэг хариуцлага хүлээлгэж болно.

Хүйн радиогийн санхүүжилтийг ихэвчлэн зар мэдээ, соёлын арга хэмжээ, сайн дурын ажил гэх мэтээр дамжуулан нутгийн иргэдээс бүрдүүлдэг. Олон улсын хандивлагчдын хувь нэмэр нь тоног төхөөрөмж авах эх үүсвэр болдог байна. Жилийн 200,000 ам.доллар орчим хэмжээний төсвийн санхүүжилт нь хүйн радиог хамруулан хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслүүдэд зориулагддаг. Сургалт, хэвлэл мэдээллийн жижиг төслүүдийн санхүүжилтийг НААС захиран зарцуулна. Санхүүжилт хүссэн төслүүдийг агуулга, чанараар нь сонгон шалгаруулдаг ажээ.

ОНЦЛОГ ШИНЖ

- Зохицуулалтын хүрээ нь арилжааны бус радио үйлчилгээг хангана
- Олон нийтийн сонгол хийх зэргээр долгион хуваарилах нээлттэй, ил тод тогтолцоотой
- Хэвлэл мэдээллийн салбарыг хамруулж, өргөн нэвтрүүлгийн агуулгыг хамтран зохицуулдаг
- Санхүүжилтийн янз бүрийн эх үүсвэртэй бөгөөд үүнд төсвийн санхүүжилтийн механизм багтдаг.



ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Republique du Benin (1992) Loi Organique no. 92-021 du 21 août 1992 relative à la Haute Autorité de l'Audiovisuel et de la Communication (НААС)
http://www.haacbenin.org/article.php?id_article=97 (accessed 31/12/2009)
- Republique du Benin (1997) Loi Organique no. 97-010 du 20 août 1997 portant libéralisation de l'espace audiovisuel et dispositions spéciales relatives aux délits en matière de presse et communication audiovisuelle
- НААС (1998) Cahiers des charges pour l'installation et l'exploitation d'une radiodiffusion sonore privée non commerciale http://www.haacbenin.org/article.php?id_article=105 (accessed (31/12/2009)

ХОЛБОО БАРИХ

La Haute Autorité de l'Audiovisuel et de la Communication
Цахим хуудас: <http://www.haacbenin.org>



ДАНИ УЛС: Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн өргөтгөсөн бодлого

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дани улс нь 175 ашгийн бус нутгийн радио, 277 ашгийн бус телевиз (үүнээс 115 нь кабель, 164 нь газрын дамжуулалтаар өргөн нэвтрүүлэг цацдаг) бүхий хүйн өргөн нэвтрүүлгийн сайн тогтолцоотой. Хүйн өргөн нэвтрүүлгийн хөгжил нь орон нутгийн арилжааны өргөн нэвтрүүлгээс илүү чухалд тооцогддог. 1997 оноос Засгийн газрын санхүүжилтийг олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийг дэмжихийн тулд айл өрхийн төлж буй татвар буюу хураамжийн төлбөрөөс зарим хэсгийг нь зориулах хэлбэрээр олгодог.

Дани улсад хүйн өргөн нэвтрүүлэг (ikke-kommercielle lokale radio- og TV-stationer) 1970-аад онд орон нутгийн кабелийн телевизийн туршилтаас эхэлсэн түүхтэй бөгөөд 1983 онд анхны арилжааны бус орон нутгийн радиод туршилтын журмаар тусгай зөвшөөрөл олгосноор илүү өргөн хүрээтэй хөгжлийн эхлэл тавигджээ. 1986 онд хүйн радио тогтмолжиж, 1987 онд хүйн телевизтэй болон өргөжсөн байна. Орон нутгийн арилжааны өргөн нэвтрүүлэг хожим нь бий болж, 1989 оноос зар сурталчилгаа явуулахыг зөвшөөрч, 2003 оноос сүлжээ байгуулах зөвшөөрөл олгогдсон. Орон нутгийн өргөн нэвтрүүлэг нь ихэнхдээ арилжааны бус байдаг. Үүний зэрэгцээ үндэсний болон бүс нутгийн хэмжээнд арилжааны өргөн нэвтрүүлэг нь



олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид, Данийн Радио, TV2 гэсэн сувгуудтай өрсөлддөг.

Арилжааны радио, телевизэд зар сурталчилгаа явуулж эхэлсэнтэй зэрэгцэн арилжааны өргөн нэвтрүүлгийн төлж буй татвараас арилжааны бус үйлчилгээг дэмжих сан байгуулжээ. Арилжааны өргөн нэвтрүүлэг эрхлэгчид үүнээс зайлсхийх бодлого баримталж эхэлснээр хэрэг дээрээ маш бага мөнгө орж иржээ. Ийнхүү 1991 онд үүнийг зогсоосон байна. 1994 оноос хүйн радиог улсын хонжворт сугалаагаар дамжуулан санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр болсон. 1997 онд арилжааны бус өргөн нэвтрүүлгийг олон нийтэд үйлчилдэг өргөн

нэвтрүүлгийн хэсэг хэмээн өргөтгөсөн үзэл баримтлалыг хуулиар хүлээн зөвшөөрч улсын татаас өгөх болсон байна. Энэ нь одоог хүртэл үргэлжилж байна. 2009 он гэхэд тусламжийн тэтгэлэгт жилийн төсвөөр 52,9 сая Дани крон буюу 10,2 сая ам.долларыг олгосон байна.

Орон нутаг дахь арилжааны бус радио, телевизүүдэд олгох санхүүжилтийн дэмжлэгийг хараат бус зохицуулагч Радио телевизийн удирдах зөвлөл шийдвэрлэдэг. Энэ этгээд нь хувийн, хүйн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох, түүнчлэн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буйд мониторинг хийдэг юм. Санхүүжилтийн нэг хэсгийг урсгал зардалд дэмжлэг үзүүлэх, нөгөө хэсгийг нь нэвтрүүлэг бэлтгэхэд зориулан орон нутгийн мэдээлэл, иргэдийн хүртээмжийг хөхиүлэн дэмжих, цөөнхийн бүлэг, чанартай хөтөлбөрийг дэмжихийн тулд өрсөлдүүлэх үндсэн дээр хуваарилдаг. Энэ хөрөнгө нь хурааж буй байдлаараа, нэг хүнд ногдох хэмжээгээрээ ч (жилд насанд хүрсэн нэг хүн 2 ам.доллар орчим) олон нийтэд үйлчлэх өргөн

нэвтрүүлгийг дэмжихийн тулд хуримтлуулдаг хөрөнгөөрөө ч, механизмынхаа хувьд ч Европдоо хамгийн томд орно. Уг аргыг хэд хэдэн хандлага туршсаны дараа нэвтрүүлсэн бөгөөд энэ нь төр, засаг солигдох үеүүдийг туулан, нэлээд удаан хугацааны турш тогтвортой байдлаа үзүүлсэн. Урсгал зардал, нэвтрүүлэг бэлтгэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь хүйн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд эдийн засгийн тогтвортой байдлын тодорхой баталгаа болж байгаагаараа давхар ач холбогдолтой юм. Үүний зэрэгцээ нэвтрүүлэг бэлтгэх сайн туршлагыг урамшуулахын тулд өрсөлдөөний элементтэй байдаг. Олон нийтэд үйлчлэх өргөн нэвтрүүлэгт дэмжлэг үзүүлэхүйц телевизийн тусгай зөвшөөрлийн хураамж, бусад хэлбэрийн татвар хуримтлуулдаг энэ механизмыг бусад улс оронд нэвтрүүлэх боломжтой. Үүний сацуу зарим улс оронд тусгай зөвшөөрлийн хураамжийг ийм аргаар тараах нь улс төрийн эсэргүүцэлтэй тулгарч болох юм. Олон нийтэд үйлчлэх гол өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд сөрөг нөлөөгүйгээр хэрэглэж болно гэдгийг Дани улс нотлон харуулсан юм.

ОНЦЛОГ ШИНЖ

- Хүйн өргөн нэвтрүүлгийн хувьд төсвийн санхүүжилтийн механизмын стратегитай
- Олон нийтэд үйлчлэх өргөн нэвтрүүлэгт зориулан өрхийн хураамжийн тодорхой хэсгийг хуваарилдаг
- Үйл ажиллагаа, нэвтрүүлэг бэлтгэх зардлын аль алийг нь санхүүжүүлдэг.
- Хараат бус зохицуулагч этгээд энэ хөрөнгөө захиран зарцуулдаг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Данийн Соёлын яам <http://www.kum.dk>
- Sammenslutningen af lokale radio- og TV-stationer i Danmark <http://www.slrtv.dk/>
- Jauert, Per and Prehn, Ole (2003) The Danish Subsidy Scheme for Non-Commercial Local Stations, Javnost Vol 10, No1 <http://www.javnost-thepublic.org/article/2003/1/5/>


ХОЛБОО БАРИХ

Styrelsen for Bibliotek og Medier

Утас: +45 33733373

Электрон шуудан: post@bibliotekogmedier.dk

Цахим хуудас: <http://www.bibliotekogmedier.dk>





ЭКВАДОР УЛС: CORAPE – Хүйн радиогийн үндэсний нэгтгэл

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эквадор улсад Нийтийн боловсролын радиогийн зохицуулах зөвлөл (La Coordinadora de Radio Popular Educativa de Ecuador) болох CORAPE нь улс даяар радио станцуудыг нэгтгэж, нийтийн, хүй олонд зориулсан, боловсролын радиогийн салбарыг бэхжүүлэхийн төлөө ажилладаг. Энэ зөвлөл нь хүйн радиогийн эрх зүй, зохицуулалтыг боловсронгуй болгоход тодорхой үүрэг гүйцэтгэсэн юм. Өөр бусад үйл ажиллагааны зэрэгцээ мэдээ, мэдээллийн үйлчилгээгээр хангах, сэдэвчилсэн сүлжээ зохион байгуулах, зөвлөлдөх арга хэмжээ авах, өргөн нэвтрүүлгийн кампанит ажил явуулах, сургалт зохион байгуулах, чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

CORAPE нь Эквадор улсад хүйн радиогийн салбарыг төлөөлөх, дэмжлэг үзүүлэх, бэхжүүлэхийн тулд 1990 онд үндэсний зохицуулах байгууллага болж үүссэн. Цэргийн дэглэмд байх үед буюу 20 жилийн өмнө батлагдсан Радио, телевизийн хуулиар (Ley de Radiodifusión y Televisión) хүйн радиог 1995 он хүртэл хүлээн зөвшөөрдөггүй байв. Хэвлэл мэдээллийн хуулийн шинэтгэлийн хүрээнд 1995 оны хүй олонд үйлчлэх өргөн нэвтрүүлгийн (estaciones de servicio público las destinadas al servicio de la comunidad) үзэл баримтлалыг



танилцуулсан. Гэсэн хэдий ч арилжааны бүхий л үйл ажиллагааг хориглож, дамжуулалтын хүчин чадалд хязгаарлалт тогтоон, “Үндэсний аюулгүй байдал гэсэн шалтгаан”-аар армиар урьдчилан зөвшөөрөл авахыг шаардах зэрэг зарим хязгаарлалттай байв. Шинэ хууль нь үзэл бодлын эрх чөлөө, түүнийг илэрхийлэх эрхэд харшилж буй асуудлаар

CORAPE маргаан үүсгэсэн бөгөөд хүйн радио болон түүний ард түмэн, хүй олны эрхийг хөхиүлэн дэмжих идэвхтэй үүргийг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхөд цаашдын шинэтгэл шаардлагатай байлаа. 2002 онд

CORAPE Үндсэн хуульд заасны дагуу хуулиа өөрчлөн шинэчлэх хэрэгцээ шаардлагыг гаргаж тавьсаныг Үндэсний Конгрессийн Эдийн засгийн комиссын дэмжлэг авч, дараагийн шинэтгэлийн ажлуудаа удирдан явуулжээ. Хэвлэл мэдээллийн хуулийн нэмэлт өөрчлөлт (89-2002 тоот хууль)-өөр хүйн станцуудын онцлог шинжийг (estaciones comunitarias) хүлээн зөвшөөрч, суваг, давтамжийн хүртээмж, арилжааны орлого хайх эрх зэргээрээ хувийн арилжааны өргөн нэвтрүүлэг эрхлэгчидтэй адил эрхтэй гэдгийг баталгаажуулсан. CORAPE одоогоор Эквадор улсын 24 мужийн 21-ийг төлөөлөх 34 хүйн радио станцыг гишүүнээр нэгтгэж, хотын хүн амын 30 хувь, хөдөөгийн 60 хувьд хүрч үйлчилдэг.

CORAPE нь Эквадор улс даяар хүйн радио станц, уран бүтээл үйлдвэрлэгч бүлгүүдийг нэгтгэсэн ардчилсан холбоо юм. Бүхий л гишүүн байгууллагын төлөөллөөс бүрдэх

ОНЦЛОГ ШИНЖ

- Хүйн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид болон уран бүтээл үйлдвэрлэлийн төвүүдийн үндэсний альянс
- Сонгогдсон Удирдах зөвлөлтэй ардчилсан засаглалтай
- Хэвлэл мэдээллийн хуулийн шинэтгэлийн төлөөх нөлөөллийн үйл ажиллагаа нь мэдэгдэхүйц амжилтад хүрсэн
- Нийгмийн хөгжилд анхаарлаа хандуулсан төсөл хэрэгжүүлж, үйлчилгээ үзүүлдэг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Davila, G (2004) *Una Utopía Convertida en Realidad*
<http://legislaciones.item.org.uy/index?q=node/308>
- IICD (2007) *Radios Comunitarias: Situación en el Ecuador*
<http://legislaciones.item.org.uy/files/Situacion%20Ecuador%202007.pdf>

ХОЛБОО БАРИХ

La Coordinadora de Radio Popular Educativa de Ecuador

Утас: +593 2 2523 006

Электрон шуудан: corape@corape.org.ec

Вэб хуудас: <http://www.corape.org.ec>

Ерөнхий Ассамблейгаас ажилчдаа удирдан, өдөр тутмын ажлаа хариуцах үүрэгтэй Гүйцэтгэх нарийн бичгийн даргыг томилдог Захирлуудын Зөвлөлийг сонгоно. CORAPE нь ардчилсан харилцааг үйл ажиллагааныхаа гол цөм болгон, ач холбогдол бүхий эрх зүйн шинэтгэлийг хийхдээ оролцооны аргыг ашигладаг. Уг холбоо нь Эквадор улсад хүйн радиог дэмжих үйлчилгээ, төслийн баримт бичгийг олон талт байдлаар хөгжүүлдэг ба эрх, хөгжлийн төлөө өөрсдийнх нь хүсэл зориг илэрдэг. Ерөнхийдөө эрх зүйн хүрээ илүү сайжирснаар нэгтгэлийн ажлууд нь нийгмийн хөгжлийн зорилтуудад анхаарч, гол үйл ажиллагаа нь Амазоны бүс нутаг, Кичва хэлээр яригчид, (Перутай хиллэж, хамтран ажилладаг) цагаач, хүүхэд, залуус болон байгаль орчны асуудалд чиглэсэн сэдэвчилсэн цуврал сүлжээгээр зохион байгуулах боломж олгосон. Нэгтгэлээс Испани хэлээр хоёр, Кичва хэлээр нэг, нийт гурван өдөр тутмын товхимол гарган үндэсний мэдээний





ЭЛЬ САЛЬВАДОР УЛС: ARPAS

– Сүлжээ байгуулах боломж олгосон долгион

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1998 онд Эль Сальвадорын Оролцоо бүхий радио, хөтөлбөрийн холбоо (Asociación de Radios y Programas Participativos de El Salvador – ARPAS) нь 92.1 богино долгион худалдан авч, зогсоход хүрч байсан бага хүчин чадал бүхий хүйн радио станцуудад өргөн зурвасын давтамжийг дахин хуваарилсан байна. Ийнхүү худалдан авсан нь долгионыг хүй олонд тулгуурласан, ашгийн бус өргөн нэвтрүүлэгчдэд зориулан нөөцлөхийг зөвшөөрсөн хууль тогтоомж батлуулахын төлөө Сальвадорын эрх мэдэлтнүүдтэй хийсэн урт удаан тэмцлийн дараах гол өөрчлөлт байв.

үйлчилгээ үзүүлдэг.

1995 онд Эль Сальвадор дахь Цахилгаан холбооны зохицуулах төрийн агентлаг (AN-TEL) нь Сальвадорын Үндэсний иргэний цагдаагийн албанд хүйн радиогийн арван станцыг татан буулгах тушаал өгсөн байна. Тэдгээр радио станц бүгд нийгмийн нөхцөл байдлыг сайжруулахын төлөө санаа тавьдаг төрийн бус, хараат бус байгууллага байсан ба нутаг орныхоо хамгийн ядуу оршин суугчдад үйлчилгээ үзүүлдэг, нэвтрүүлэг хийх, солилцохдоо оролцооны аргыг дэмждэг, бүгд ARPAS-ын гишүүн байсан гээд нийтлэг дэг жаягтай байсан юм. Эдгээр арван радиог урьд жил нь Segundo Montes радио манлайлж, хүчээ нэгтгэн ажиллахаар болсон байна. Учир нь ARPAS-ын Жойс Алемэн “Радионууд нь үндсэн зарчмуудаа хангалттай ухамсарлаж



байна. Хэрэв бид нэгдэхгүй, хамтдаа үйлдэл хийхгүй бол бүх боломжоо алдаж, ялагдах болно” гэжээ.

1998 онд 92.1 богино долгионыг худалдах



боломж гарсанд ARPAS маш хурдан хариу үйлдэл үзүүлжээ. Эль Сальвадорын Цахилгаан холбооны хуулийн төсөлд хүйн радиод зориулан давтамж нөөцлөх тухай нэмэлт оруулах санал боловсруулж, хүргүүлсэн зэрэг зургаан жилийн нөлөөллийн ажлын үр дүнд 2000 онд Засгийн газар ARPAS-ыг хүлээн зөвшөөрч, мөн гишүүн радионуудад зориулан ашиглах өргөн нэвтрүүлгийн давтамжийн зурвас худалдан авахыг зөвшөөрсөн байна. Түүнээс хойш, байгууллага 92.1 богино долгион худалдан авсан нь ашиг тусаа өгч, сүлжээ хүйн радиогийн 28 үйлчилгээ, уран бүтээлийн 6 төвтэй болон өргөжсөн байна. ARPAS нь гишүүн хүйн радио станцууддаа ашиглуулахаар давтамжийн дахин хуваарилалт хийх боломжтой болжээ.

ARPAS нь нөлөөллийн нэгдмэл ажил, шинэлэг арга хэмжээ, удаан хугацаанд чадавх бэхжүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан хүйн

ОНЦЛОГ ШИНЖ

- Хүйн радио станц, уран бүтээлийн бүлгүүдийн холбоо
- Эрх зүй, зохицуулалтын хувьд хүлээн зөвшөөрүүлэх нөлөөллийн ажил хийсэн
- Богино долгионы хэсгийг баталгаатай болгоход хамтын хүчин чармайлт гаргасан
- Чадавх бэхжүүлэх, агуулга боловсруулахад дэмжлэг үзүүлдэг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- **Movimiento para la Comunicación Democrática**
<http://www.movimientocomunica.blogspot.com/>

ХОЛБОО БАРИХ

Asociación de Radios y Programas Participativos de El Salvador (ARPAS)
Утас: +503 22604427
Цахим хуудас: <http://www.arpas.org.sv>

радио өөрийнхөө тогтвортой байдлыг хэрхэн хангаж болохыг харуулсан амжилттай жишээ юм. Радио давтамжийн зурвасын хүртээмж бол хүйн радио өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийн хувьд түүнийг байгуулах, тогтвортой байдлыг хангах үндэс юм. Эль Сальвадор улсад хүйн радиог хөгжүүлэх явцад улс төр, арилжааны эсэргүүцэлтэй тулгарсан ч, ARPAS нь гишүүн радионуудаа хаагдахаас нь сэргийлэх боломж олгоход хүрэлцэхүйц хэмжээгээр богино долгионы хэсгээс худалдан авах амжилттай хэлэлцээ хийсэн юм. Хөндлөнгийн ийм оролцоогүйгээр Эль Сальвадорын хүйн радионуудын ихэнх нь үгүй болж, үүнтэй цуг энгийн иргэд ардчиллын үйл явцад оролцох боломжгүй болох байсан. ARPAS нь иргэний нийгмийн Ардчилсан Харилцааны Хөдөлгөөн (Movimiento para la Comunicación Democrática)-ний нэг хэсгийн хувьд хэвлэл мэдээллийн шинэтгэлийн төлөө нөлөөллийн ажлаа үргэлжлүүлж байна. Түүнчлэн санхүүгийн тогтвортой байдал, зохион байгуулалт, удирдлагын ур чадвартай холбоотой практик чадавхыг хөгжүүлэх, хүйн радиогийн хөтөлбөрийн агуулга, соёлын илэрхийлэлд дэмжлэг үзүүлэхэд ч анхаарч байгаа юм. 2004 оны Үндэсний сонгуулийн үеэр ARPAS-ын гишүүд сонгууль сурвалжлах сэтгүүлчдийн орон нутаг, бүс нутагт мэдээ бэлтгэх сүлжээг байгуулжээ. Үүндээ Эль Сальвадор даяар санал хураалтын дүн мэдээ дамжуулах үүрэг бүхий 150 гаруй сурвалжлагчийг хамруулсан нь хүртээмжийн хувьд арилжааны хэвлэл мэдээллээс хол давжээ.



ФРАНЦ УЛС: FSER – Арилжааны бус, нутгийн радиог дэмжих сан

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Франц нь хүйн радиогийн зохицуулалт, санхүүжилтийн хүрээ бий болгосон Европын анхны улс юм. 500 гаруй хүйн радио (radios associatives)-д санхүүжилтийн солбилцлын татаасын механизмаар дэмжлэг үзүүлдэг. Арилжааны радио, телевизийн станцууд арилжааныхаа орлогоос Орон нутгийн радио илэрхийллийг дэмжих сан (Fonds de soutien a l'expression radiophonique locale – FSER)-д шимтгэл төлдөг. Хүйн радио станцууд нь, орлогынхоо хорин хувиас илүү хувийг арилжааны эх үүсвэрээс олдоггүй тохиолдолд орлогынхоо 50 орчим хувьтай тэнцэх дэмжлэгийг сангаас авах боломжтой.

Франц улсад хүйн радиогийн түүх төрийн мэдлийн өргөн нэвтрүүлэг монополь ноёрхсон 1970-аад оны үед тусгай зөвшөөрөлгүй ажиллаж байсан “чөлөөт” радио станцууд (radios libres)-аас эхэлдэг. 1982 онд Дуу, дүрс бичлэгийн харилцаа холбооны тухай хууль (82-652 тоот) батлагдаж, өргөн нэвтрүүлэг либеральчлагдан, хувийн радио эрхлэгчдэд зориулан долгионыг нээлттэй болгосон байна. Энэ хуулиар мөн орон нутгийн арилжааны бус радио үйлчилгээг өөрсдийн нийгмийн зорилгоо биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор FSER байгуулагдсан ажээ. FSER нь арилжааны өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийн зар сурталчилгаанаас олсон орлогоос ногдуулсан шимтгэлээр санхүүждэг.

1986 онд Харилцааны эрх чөлөөний хууль (86-1067 тоот)-иар хувийн өргөн

нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, зохицуулалтыг хангах үүрэг бүхий Conseil Supérieur Audiovisuel (CSA) байгуулагдав. Энэ хуулиар зар сурталчилгаа, ивээн тэтгэлгээс 20-иос доош хувийн орлого олдог үйлчилгээ эрхлэгчид FSER-аас санхүүгийн дэмжлэг авах боломжтой ажээ. 1989 оны наймдугаар сарын 29-нд батлагдсан 34 тоот Communiqué хэмээх баримт бичигт CSA нь хувийн радио үйлчилгээний таван ангиллыг тодорхойлсон байна. А ангиллын үйлчилгээнд ашгийн бус үйлчилгээ багтах ба FSER-аас дэмжлэг авах боломжтой. А ангиллын үйлчилгээний тусгай зөвшөөрөл



эзэмшигчид нь орлогынхоо 20-иос доош хувийг зар сурталчилгаа, ивээн тэтгэлгээс олдог, 06.00-22.00 цагийн хооронд дөрвөөс багагүй цагийн орон нутгийн хөтөлбөртэй, тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашгийн бус холбоо байдаг, хөтөлбөрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний гишүүн холбоод бэлтгэдэг гэх мэт шинжийг агуулсан байх ёстой.

FSER-аас санхүүжилт хуваарилах журмыг 2006 оны наймдугаар сарын 25-ны өдрийн 2006-1067 тоот тушаалаар баталж, FSER-ийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулсан байна. 2007 оны жилийн тайланд дурдсанаар FSER нь нийтдээ 25.49 сая евро (36,6 сая ам.доллар)-гийн санхүүгийн дэмжлэг олгожээ. Үүний 80 хувийг 588 хүйн радиогийн үйл ажиллагааны зардалд (тус бүрт нь дунджаар 49,500 ам доллар), үлдсэн хэсгийг үйл ажиллагаа эхлэх зардал, тоног төхөөрөмж шинэчлэх, сайжруулах, мөн өрсөлдүүлэн шалгаруулах замаар нийгмийн төслүүд, байгууллагын хөгжлийг дэмжихэд зориулсан байна.

FSER нь хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зориулагдсан, төрийн санхүүжилтийн Европдоо хамгийн удаан хэрэгжиж буй механизм юм. FSER-ийн санхүүжилт нь Франц дахь хүйн радиогийн үйл ажиллагааны зардлын 50 орчим хувийг даадаг ба

арилжааны бус бусад эх үүсвэрээс санхүүжилт олохыг нь дэмжих үндсэн дээр энэ хэмжээг тогтоосон байна. Тус сан нь 25 гаруй жил энэхүү салбарын эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж байгаа билээ.

Арилжааны бус станцууд

зар сурталчилгааны орлогоос татгалзсаны хариуд арилжааны салбарт ногдуулсан шимтгэлээр дамжуулан солбилцлын татааст хамрагдах энэ түүхэн тохиролцоог хувийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид өргөнөөр хүлээн зөвшөөрч, энэ нь засгийн газрын өөрчлөлтүүдийн үед ч төрийн бодлогын дэмжлэг хэвээр үлдсэн билээ. FSER-д хяналт тавьдаг 11 хүнтэй зөвлөлийн дөрөв нь хүйн радиогийн салбарын төлөөлөл байдаг.



ОНЦЛОГ ШИНЖ

- Хүйн өргөн нэвтрүүлэгт зориулсан солбилцлын татаасын санхүүжилтийн стратегитай
- Арилжааны өргөн нэвтрүүлгийн салбарын орлогоос жилийн шимтгэл ногдуулдаг
- Арилжааны бус өөр бусад эх үүсвэрт тохируулан санхүүжилтийг хуваарилдаг
- Салбарын төлөөллийг оролцуулсан зөвлөл захиран зарцуулдаг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Conseil superieur de l'audiovisuel <http://www.csa.fr>
- Syndicat national des radios libres <http://www.snrl.org>
- Confederation Nationale des Radios Associatives <http://www.cnra.fr>
- Fonds de soutien à l'expression radiophonique locale: Rapport d'activite 2007 http://www.ddm.gouv.fr/IMG/pdf/Rapport_d_activite_2007_FSER_HQ.pdf

ХОЛБОО БАРИХ

Fonds de soutien a l'expression radiophonique locale Ministere de la culture et de la communication – Direction du developpement des medias

Утас: +33 1 40 15 73 57

Электрон шуудан: fser@culture.gouv.fr

Цахим хуудас: <http://www.ddm.gouv.fr>



НЕПАЛ УЛС: АСОРАВ-хүйн радиогийн салбарыг хамгаалж буй нь

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

АСОРАВ-ын эрхэм зорилго нь Непал улсад хүйн радиог дэмжих, хамгаалах, тогтвортой хөгжүүлэхэд оршино. АСОРАВ нь мэдээлэл солилцох, мэдлэг хуваалцах, ур чадварыг нь хөгжүүлэх замаар гишүүн байгууллагууддаа үйлчилгээ үзүүлэх зорилготой. Мөн хүйн радио станц байгуулах, чадавхыг нь бэхжүүлэх, тоног төхөөрөмж нийлүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, байгууллагыг хөгжүүлэхэд туслах зэргээр дэмжлэг үзүүлдэг.

Хүйн радио Непал улсад 1997 онд Катманду хотод Сагармата (Sagarmatha) радио байгуулснаар эхэлжээ. Үүнийг Непалын Байгаль орчны сэтгүүлчдийн форум (NEFEJ) байгуулсан байна. Сагармата Радио нь Өмнөд Ази дахь анхны хүйн радио бөгөөд Непал улсын хараат бус өргөн нэвтрүүлгийн анхдагч юм. Үүнээс хойш таван жилийн хугацаанд Непал улсад хувийн богино долгионы 15 орчим станц, Люмбини (Lumbini), Мадханпохара (Madhanpokhara), Химчули FM (Himchuli FM) зэрэг нь ашгийн бус хүйн радио байжээ. Дөнгөж үүсч буй салбарыг дэмжихийн тулд Непалын Байгаль орчны сэтгүүлчдийн форум нь Хүйн радиог дэмжих төв байгуулж, эрх ашгаа хамгаалах, хүйн радиог цаашид хөгжүүлэх чадвар бүхий



төлөөллийн этгээд бий болгохын тулд радио станцууд өөрсдөө нэгджээ.

Непалын Хүйн радио өргөн нэвтрүүлэгчдийн холбоо (АСОРАВ) нь хүйн радиогийн чадавхыг бэхжүүлэх, тэдгээрт ардчиллыг бүтээн байгуулахад хувь нэмрээ оруулах боломж олгох, хүмүүсийг улс төрийн үйл явц дахь оролцоог дээшлүүлэх, ард иргэдээр хөтлүүлсэн хөгжлийг дэмжихийн тулд ерөнхий форумын хэлбэрээр 2000 онд байгуулагдсан байна. Хүйн радио хоорондын эв санааны нэгдлийг хөхиүлэн дэмжсэнээр тэд хүйн радио өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийн /үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, гадуурхагдсан* иргэдийн дуу хоолойг

* Гадуурхагдсан иргэд (гадуурхагдсан бүлэг) - үндэстний цөөнх, угсаатны цөөнх, эрхтний бэрхшээлтэй хүмүүс, эмэгтэйчүүд зэрэг нийгэм, эдийн засгийн хувьд ялгаварлан гадуурхалтад өртөмхий бүлэг (Орч.)

нухчин дарах, ялангуяа төрийн, түүнээс гадуур этгээдүүдийн халдлага, заналхийллээс хамгаалахад гол үүрэг гүйцэтгэж байна.

2005 оны 2 сард Гянендра хаан сонгогдсон парламентыг тарааж, засгийн эрхийг булаан авахад хараат бус өргөн нэвтрүүлэгчид бодит аюул заналхийлэлтэй тулгарсан юм. Цэргүүд радио станцуудад ирж, удирдлагуудад мэдээ, цаг үе үйл явдлын бүх өргөн нэвтрүүлгийг зогсоох тушаал өгчээ. Хүйн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид ардчилал, хүний эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэлтэй байх эрхийг хамгаалахын төлөө аяны манлайд явж байв. Шинэ Үндсэн хуультай болж, хожим нь монарх дэглэмийг татан буулгахуйц үр дүнд хүргэсэн 2006 оны Ард түмний хөдөлгөөний дараачаас их бага хэмжээний шаардлагын дагуу богино долгионы тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн байна. Шинэ Үндсэн хуультай болсон эхний нэг жилд гэхэд 150 гаруй тусгай зөвшөөрөл олгосны 65 гаруй нь ашгийн бус станцууд байв. Ашгийн бус станцын дийлэнх нь ACORAB-ын гишүүн бөгөөд хэвлэл

мэдээллийн эрх зүйн шинэтгэлийн төлөө нөлөөллийн ажлаа үргэлжлүүлж, хүйн радиог хүлээн зөвшөөрүүлжээ.

ACORAB-ийн бодлого, стратеги нь хүний эрх, ардчиллын хэм хэмжээг хамгаалахад үндэслэгдсэн үнэт зүйлийг удирдлага болгодог байгууллага юм. Гишүүн станцуудын ардчилсан оролцоо, удирдах зөвлөлийн гишүүд, ажилтнуудын тогтмол сонгуулийг дэмжсэнээр байгууллагын дүрэм, журам, үйл ажиллагаа, удирдлагын тогтолцоондоо эдгээр үнэт зүйлээ тусгахыг тэд эрмэлздэг. Байгуулагдсанаасаа хойш тэд ашгийн бус, нийтийн эрх ашигт үйлчилдэг, үзэл бодолтой байж, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөг дээдлэхийг хөхиүлэн дэмжих, санаа бодол, хэтийн төлвийн олон талт байдлыг баталгаажуулан, хүмүүсийн мэдээллийн хүртэмжид тус дөхөм болох, нийгмийн давхарга, гарал угсаа, хүйс, яс үндэс, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахын эсрэг үйл ажиллагаа явуулдаг хүйн радиогийн загварыг хөхиүлэн дэмжсээр ирсэн юм.

ОНЦЛОГ ШИНЖ

- Хүйн өргөн нэвтрүүлгийн үндэсний төлөөллийн холбоотой
- Сонгогдсон Удирдах зөвлөлийн ардчилсан удирдлагын бүтэцтэй
- Эв санааны нэгдэл, харилцан туслалцах, хамтын үйл ажиллагааг хөхиүлэн дэмждэг
- Хүний эрх, ардчиллыг хамгаалахад үндэслэгдсэн үнэт зүйлтэй



ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Pringle, I and Subba, B (2007) Ten years on: The state of community radio in Nepal Paris: UNESCO
- http://portal.unesco.org/geography/en/files/7991/11966615215State_of_Community_Radio_in_Nepal_abridged.pdf/State+of+Community+Radio+in+Nepal_abridged.pdf

ХОЛБОО БАРИХ

- Непал улсын Хүйн радиогийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийн холбоо (ACORAB)
- Утас: + 977 1 5551161 / 5551171
- Электрон шуудан: info@acorab.org.np
- Цахим хуудас: <http://www.acorab.org.np>





ӨМНӨД АФРИК: MDDA – хэвлэл мэдээллийн санхүүжилт ба олон талт байдал

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Өмнөд Африкийн Хэвлэл мэдээллийн хөгжил, олон талт байдлын агентлаг (MDDA) нь хэвлэл мэдээллийн орчин тэнцвэргүй байдаг түүхэн уламжлалыг халж, хэвлэл мэдээллийн орон талт байдлыг хөхиүлэн дэмжихийн тулд байгуулагджээ. Тус агентлаг нь хүйн хэвлэл мэдээлэл, арилжааны жижиг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд санхүүжилтийн тэтгэлэг олгож, мөн сургалт, салбарын судалгааны ажлыг санхүүжүүлдэг. Хэвлэл мэдээллийн хөгжил, олон талт байдлын агентлаг нь хараат бус удирдах зөвлөлөөр удирдуулдаг нийтийн байгууллага бөгөөд хэвлэл мэдээллийн зонхилох гол хэрэгслүүдийн хандив, түүнчлэн засгийн газрын тэтгэлгээр санхүүждэг.

.....

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл төгсгөл болсны дараа 1990-ээд оны үед ардчилсан өргөн нэвтрүүлгийн орчны төлөө иргэний нийгмийн идэвхтэй кампанит ажлын үр дүнд Өмнөд Африкт хүйн өргөн нэвтрүүлэг хурдацтай хөгжиж эхэлжээ. Өмнөх төрийн монопольчлол төгсгөл болох үед Өмнөд Африкийн Өргөн нэвтрүүлгийн корпораци (SABC) нь олон нийтийн, арилжааны, хүйн өргөн нэвтрүүлэг хэмээх ангиллын тогтолцоонд шилжиж, SABC-ыг шинэчлэн байгуулжээ. Хуучин уламжлалын гайгаар шоовдорлогдсон хүй олны хэрэгцээ шаардлагад үйлчлэх хэрэгслийн хувьд хүйн өргөн нэвтрүүлгийг арилжааны өргөн нэвтрүүлэг эрхлэгчдээс давууд үзсэн тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн байна. Одоо

тэнд 100 гаруй хүйн радио станц байдаг. Хүйн өргөн нэвтрүүлэг нь ашгийн төлөө бус ажиллах ба Өмнөд Африкийн Хараат бус харилцаа холбооны байгууллага (ICASA)-аас 2005 онд батлагдсан Электрон харилцаа холбооны тухай хуулийн дагуу зохицуулалт хийдэг.



Шоовдорлогдсон, төлөөлөл багатай бүлэг хэсгийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц хүйн өргөн нэвтрүүлгийн салбар, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийн тогтвортой байдлыг

хангах, тасралтгүй хөгжүүлэхийн тулд 2003 онд MDDA-г байгуулжээ. Энэ бол нийтийн байгууллага ба хариуцлага, удирдлагын тогтолцоог нь MDDA-ийн 2002 оны 14 тоот тогтоолоор баталсан байна. MDDA нь зарим санхүүжилтээ Засгийн газраас, заримыг нь хувийн хэвлэл мэдээллийн салбар, мөн Өмнөд Африкийн Өргөн нэвтрүүлгийн корпорацын хандиваар бүрдүүлдэг. Тэд 2004 оноос тэтгэлэг олгож эхэлсэн байна. Үүнээс хойш, 2009-2010 оны жилийн тайланд дурдсанаар бол 284 гаруй төсөл санхүүжүүлсэн ба 103 сая орчим ганд (15 сая ам.доллар)-ыг тэтгэлгийн санхүүжилтэд зарцуулжээ.

MDDA нь бүхий л Өмнөд Африкчуудын хүсэл эрмэлзэл, хэрэгцээ шаардлагыг тусгах, ялангуяа шоовдорлогдсон хүй олны гадуурхагдсан, хаягдсан байдлыг засч залруулахын тулд хэвлэл мэдээллийн хөгжил, олон талт орчинг бүрдүүлэх бүрэн эрхтэй. Энэ эрх мэдлээ хүйн хэвлэл мэдээлэл, түүнчлэн сонин хэвлэл, радио, телевизийг хамруулан арилжааны жижиг хэвлэл мэдээлэлд төслийн тэтгэлэг олгох хэлбэрээр дэмжлэг үзүүлэн хэрэгжүүлдэг байна. Агентлагт орлогынхоо 20-иос илүү хувийг захиргааны зардалд

ОНЦЛОГ ШИНЖ

- Хэвлэл мэдээллийн хөгжилд зориулан санхүүжилт олгодог нийтийн байгууллага нь хуулийн дагуу байгуулагдсан
- Шоовдорлогдсон бүлэг хэсэг, хүй олонд хүртээмжтэй байхыг хөхиүлэн дэмждэг
- Хүйн хэвлэл мэдээлэл, арилжааны жижиг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд анхаарлаа төвлөрүүлдэг
- Зонхилох гол хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба засгийн газрын тэтгэлгээр санхүүждэг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Media Development and Diversity Agency Act (2002) <http://www.mdda.org.za/gifs/MDDA%20Act.pdf>
- Media Development and Diversity Agency Annual Report 2009/10 http://www.mdda.org.za/MDDA%20Annual%20Report2009_2010%20.pdf
- National Community Radio Forum <http://www.ncrf.org.za>

ХОЛБОО БАРИХ

Хэвлэл мэдээллийн хөгжил, олон талт байдлын агентлаг
Утас: +27 11 643 11 00
Электрон шуудан: info@mdda.org.za
Цахим хуудас: <http://www.mdda.org.za>

зарцуулахгүй байх шаардлага тавигддаг. Тэтгэлгийн санхүүжилтийн 60-аас багагүй хувийг хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд, 25 хувийг арилжааны жижиг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 5 хувийг судалгаа, үлдсэн хэсгийг бусад санаачилгад зориулан зарцуулдаг ажээ.

MDDA-д стратегийн чиглэлийг тодорхойлдог хараат бус Удирдах зөвлөл хяналт тавьдаг. Гүйцэтгэх удирдлага нь 22 хүнтэй ажлын багийг толгойлох ба хөрөнгө босгох ажил, түншлэгчийн харилцаа, тэтгэлгийг хэрхэн захиран зарцуулж буй, судалгаа, чадавх бэхжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьдаг. MDDA нь 7 жилийн үйл ажиллагааны турш хүйн радиогийн тогтвортой байдал, өсөлт хөгжилтөд хувь нэмэр оруулж, нутгийн уугуул хэл дээрх хүйн сонинуудад шуурхай дэмжлэг үзүүлж, хүйн телевизийн суурийг тавихад туслалцаа үзүүлсэн байна.





ТАЙЛАНД УЛС: CPMR – Хэвлэл мэдээллийн шинэтгэлийн төлөө иргэний нийгмийн аян

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нийтийн хэвлэл мэдээллийн шинэтгэлийн аян (CPMR) нь Тайланд улсын хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны шинэтгэлийн төлөө ажилладаг иргэний нийгмийн байгууллага, багш, хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийн нэгтгэл юм. Бодлогын мониторингийг олон нийтийн ашиг сонирхлын төлөө нөлөөллийн ажилтай хослуулснаараа CPMR нь хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны эрх зүй, зохицуулалтыг боловсронгуй болгоход нөлөө үзүүлж, хүйн радиод зориулан өргөн нэвтрүүлгийн давтамж нөөцлөхөд дэмжлэг үзүүлэх, хамгаалахад гол үүрэг гүйцэтгэсэн. Богино долгионы давтамжийн зурвасын 20 хувийг хүйн радиод зориулан нөөцөлсөн нь 5000 гаруй хүйн радио үйлчилгээ эрхлэх боломж бүрдүүлжээ.

1992 оны 5 сарын иргэдийн эсэргүүцлийг цэргийн хүчин цус урсган нам дарснаар Тайландад үүссэн улс төрийн хямрал нь 1997 оны Үндсэн хуулийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай зүйл заалтын тухай асуудал хөндөгдөж, хэвлэл мэдээллийн шинэтгэл хийх шаардлага тавихад хөтөлсөн юм. Үндсэн хуулийн 40-р зүйлд “радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн дамжуулалтын давтамж, радио цахилгаан холбоо нь олон нийтийн ашиг сонирхол бүхий үндэсний харилцаа холбооны нөөц мөн” гээд долгион хуваарилах, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг зохицуулан хянах хараат бус зохицуулах байгууллагын эрх зүйн үндсийг тогтоожээ.

Тай сайн дурынхны үйлчилгээ (The Tai Volunteer Service) нь хэвлэл мэдээллийн шинэтгэлийг түргэтгэх, түүний практик хэрэгжилтийг хөхиүлэн дэмжихийн тулд 40-р зүйлд мониторинг хийх комисс байгуулжээ. Энэ бүлэг хожим нь Нийтийн хэвлэл мэдээллийн шинэтгэлийн төлөө аян болон шинэчлэгдэн зохион байгуулагдсан.

CPMR-ын нөлөөллийн ажил нь 2000 онд Дамжуулалтын давтамж хуваарилах, өргөн нэвтрүүлэг, цахилгаан холбооны бизнесийг зохицуулах байгууллагын тухай хуультай боло-



ход нөлөөлжээ. Үүний дагуу ашгийн бус хүйн өргөн нэвтрүүлэгт зориулан өргөн нэвтрүүлгийн давтамжийн зурвасын 20 хувийг нөөцөлсөн байна. Хүйн радиод зориулан давтамж нөөцлөх хууль нь хэзээ ч бүрэн хэрэгжээгүй юм. Учир нь, санал болгосон хараат бус зохицуулах байгууллага байгуулагдаагүй ажээ. Нөөцөлсөн давтамжийн зурвас ашиглах эрхдээ тулгуурлан хүйн радио станцууд албан ёсны зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн ба 2005 он гэхэд засгийн газар үүнийг дуугүй л хүлээн зөвшөөрдөг байв. 2008 оны Өргөн нэвтрүүлгийн тухай шинэ хуулиар тусгай зөвшөөрөлгүйгээр өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхийг хууль бус гэж үзжээ. Түр зохицуулалтын дагуу 5500 хүйн радиог, түүний үйл ажиллагааг тогтмолжуулах зорилго бүхий үйл явцын нэг хэсэг гэж үзэн Үндэсний цахилгаан холбооны комисс бүртгэж авсан байна.

Тогтворгүй, туйлширсан улс төрийн орчин Тайландын хэвлэл мэдээллийн шинэтгэлд маш их нөлөөлсөн юм. Энэ нь эргээд үйлчилгээний тоо хэт олшроход хүргэж, арилжааны болон улс төрийн ашиг сонирхол бүхий бүлгүүдийн санаачилгаар олон тооны үйлчилгээ бий болжээ. CPMR нь хэвлэл мэдээлэлд олон нийтийн оролцоог хангахын

тулд тогтмол нөлөөллийн тасралтгүй үйл ажиллагаа явуулав. Ингэхдээ үр ашиг бүхий хэвлэл мэдээллийн шинэтгэл нь зөвхөн хууль, зохицуулалтын өөрчлөлтийг бус, харин бодлогын практик хэрэгжилт нь доод шатны түвшин дэх хүйн хэвлэл мэдээллийг хөхиүлэн дэмжиж, туслалцаа үзүүлэхийг шаарддаг гэдгийг таниулсан байна. CPMR нь Хүйн радиогийн холбоо, багш, өргөн нэвтрүүлэгчидтэй хамтран ажиллаж, үйл ажиллагаа нь зогсох аюул нүүрлэсэн хүйн радио станцуудыг хамгаалах, хүйн радиогийн хөгжлийг дэмжсэн, хүлээн зөвшөөрсөн хуулийн зүйл заалт, зохицуулалтын удирдамжийн төсөл боловсруулах ажлыг дэмжих зэргээр хүйн радиогийн хөгжлийн бодлогод үргэлжлүүлэн мониторинг хийж байв. Парламентад, хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан CPMR-ын кампанит ажил нь Тайланд улсад хэвлэл мэдээлэл, харилцааны эрхийг нийгэм, улс төрийн хувьд хүлээн зөвшөөрөхөд хүргэж, мянга мянган хүйн радио үйлчилгээ байгуулагдан, үйл ажиллагаагаа явуулах таатай орчинг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан билээ.



ОНЦЛОГ ШИНЖ

- Иргэний нийгмийн кампанит ажил нь хэвлэл мэдээллийн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд дэмжлэг болсон
- Хэвлэл мэдээллийн ажилтан, иргэний нийгмийн идэвхтэн, багш нарыг хамруулсан өргөн нэгтгэл
- Давтамж нөөцлөх, тусгай зөвшөөрөл олгоход амжилт олсон
- Иргэдийн хэвлэл мэдээлэл, харилцааны эрхэд үндэслэгдсэн үнэт зүйл

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Brooten, Lisa and Klangnarong, Supinya (2009) People's media and reform efforts in Thailand, *International Journal of Media and Cultural Politics*, Vol 5, Issue 1 and 2, pages 103-117 Intellect <http://www.nationmultimedia.com/home/2009/08/25/business/99-of-all-radios-registered-with-NTC-30110566.html>
- The Nation (2009) 99% of all radios registered with NTC, published in The Nation online on August 25, 2009 at <http://www.nationmultimedia.com/>
- Witayasakapan, Jiraporn (2007) Women, good governance and community radio, paper for the AMARC WIN Workshop at GK3, Kuala Lumpur http://www.media4democracy.com/eng/news_002.html

ХОЛБОО БАРИХ

CPMR

Утас: +66 26910574 / 26910574

Электрон шуудан: cpmr@media4democracy.com

Цахим хуудас: <http://www.media4democracy.com>



УРУГВАЙ УЛС: Хүйн өргөн нэвтрүүлгийн тэгш хүртээмж

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2007 оны арванхоёрдугаар сард батлагдсан Уругвай улсын Хүйн өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар аналог, тоон системийн аль аль орчинд хүйн өргөн нэвтрүүлгийг тов тод хүлээн зөвшөөрч, түүнийг дэмждэг. Хуулиар олон нийтийн, арилжааны, хүйн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд радио давтамжийг тэгш хуваарилахаар зохицуулсан. Мөн тусгай зөвшөөрөл олгох нь шударга, ил тод үйл явц байх бөгөөд иргэний нийгмийн байгууллагуудыг хамруулсан хараат бүс зөвлөх хороо хяналт тавина.

.....

Уругвай улсад хүйн өргөн нэвтрүүлэг нь албан ёсны эрх зүйн хүрээнээс гадуур үүссэн ба эрх баригчид станцуудыг хаахад маш хялбар байлаа. 2000 онд Уругвайн Засгийн газраас хүйн радиогийн үйл ажиллагааг хууль ёсны болгоход бэлэн байгаагаа мэдэгджээ. AMARC-ын Уругвай дахь салбар зарим хүйн радиог төлөөлөн хүйн радиогийн тусгай зөвшөөрөл олгох, радиог хаах явдлыг төгсгөл болгохыг эрмэлзэж, засгийн газар, иргэний нийгмийн хооронд яриа хэлэлцээ хийхийг уриалсан байна. 2002 онд харилцааны зохицуулагч байгууллага URSEC (Unidad Reguladora de Servicios de Comunicaciones)-аас хүйн өргөн нэвтрүүлгийг зохицуулах хуулийн төсөл боловсруулав. Үүнийг хүйн радионууд хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэн, эсэргүүцсэн байна. Учир нь төсөлд дамжуулалтын бүс хэтэрхий хязгаарлагдмал, өргөн

нэвтрүүлгээ явуулж байгаа радио станцуудыг хамруулаагүй, тусгай зөвшөөрөлгүйгээр өргөн нэвтрүүлэг эрхэлсэн тохиолдолд хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэх, түүнчлэн долгионы зөвшөөрлийг албан хаагчдын үзэмжээр олгон ашиглуулахаар заасан байв.

2005 онд Засгийн газрын өөрчлөгдсөний дараа хүйн өргөн нэвтрүүлэг эрхлэгч, сэтгүүлч, багш нарын эвсэл Хүйн өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн шинэ төсөл боловсруулжээ. Төслийг хууль тогтоогчдын бүлэг Парламентын хэлэлцэх асуудалд оруулж, Америкийн улс дундын Хүний эрхийн Комиссын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тусгай илтгэгч 2006 онд Уругвайд албан ёсны айлчлал хийх үйл явцыг цаашид түргэтгэжээ. Тусгай илтгэгч Игнасио Алварез хуулийн төслийг “яаралтай хэлэлцэх”-ийг

шаардан, “Радио электрон давтамжийн зурвас ба хүйн радио хэвлэл мэдээллийн ашиглалт” нэртэй хууль олон улсын хэм хэмжээнд нийцсэн болохыг мэдэгдсэн байна.

2007 онд Уругвай улсын хууль тогтоогчид хүйн радио, телевизийг албан ёсоор хүлээн зөвшөөрч зохицуулсан Хүйн өргөн нэвтрүүлгийн тухай хууль баталжээ. Уг хуулиар дунд, богино агаарын долгион, телевизийн давтамжийн зурвасын гуравны нэгийг хүй олонд суурилсан хэвлэл мэдээлэлд нөөцлөх, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, академик боловсролын байгууллагуудаас дийлэнх нь бүрдсэн, хараат бус зөвлөлийн хяналт дор давтамжийг ил тод, ялгаварлан гадуурхалгүйгээр хуваарилах үйл явцыг тогтоосон байна. 2008 оны 8 сард URSEC тоон системийн телевизийн газрын дахин дамжуулалт бүхий 9 сувгийн гурвыг нь хүйн телевизэд зориулан нөөцөлж, түүнийг нээлттэй, нийтийн өрсөлдөөнөөр хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Уругвайд Хүйн өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдсан нь олон жилийн турш, засгийн газруудын өөрчлөлтийг дамжсан нөлөөллийн үйл ажиллагааны оргил, хүйн

өргөн нэвтрүүлэгчдийн бий болгосон эвслийн хүч билээ. Хуулийн төсөл боловсруулахад иргэний нийгмийг татан оролцуулсан нь түүний хэрэгжилтэд иргэний нийгэм хяналт тавих тухай зүйл заалтад тусгалаа олсон юм. Шинэ хуулиар хамрах хүрээ, орлогын эх үүсвэрт аливаа хязгаарлалт тавиагүйг Латин Америкийн бүс нутагт ач холбогдол бүхий чухал жишиг гэж үзэж болно. Өргөн нэвтрүүлгийн долгионы давтамжийн зурвасын гуравны нэгийг нөөцлөхөөр илэрхий амласан нь тоон телевизийн ирээдүйн хөгжилд түлхэц болох юм. Энэ нь мөн тоон телевизийн үйлчилгээнд зориулсан давтамжийн зурвас төлөвлөлтийн олон улсын жишиг болно.



ОНЦЛОГ ШИНЖ

- Хүйн радио, телевизэд зориулсан хуулийн зүйл заалттай
- Аналог, тоон давтамжийн зурвасын гуравны нэгийг нөөцөлсөн
- Давтамж хуваарилах үйл явц нь нээлттэй, ил тод
- Иргэний нийгмийг хамарсан хараат бус зөвлөх хороотой

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- AMARC-Uruguay <http://amarcuruguay.org>
- IACHR/Office of Special Rapporteur for Freedom of Expression (2006) Observations and recommendations regarding the situation of freedom of expression in Uruguay <http://www.cidh.org/relatoria/showarticle.asp?artID=686&IID=1>
- IFEX/AMARC (2007) Senate passes approves community broadcasting bill http://www.ifex.org/uruguay/2007/11/27/senate_passes_community_broadcasting/
- IFEX/AMARC (2008) Community stations given unprecedented access to digital television frequencies http://www.ifex.org/uruguay/2008/08/15/community_stations_given_unprecedented/
- Rep. of Uruguay (2007) Ley No. 18.232 Servicio Radiodifusión Comunitaria <http://200.40.229.134/leyes/AccesoTextoLey.asp?Ley=18232>

ХОЛБОО БАРИХ

Unidad Reguladora de Servicios de Comunicaciones

Утас: +598 2902 8082

Электрон шудан: ursec@ursec.gub.uy

Цахим хуудас: <http://www.ursec.gub.uy>



НЭГДСЭН ВАНТ УЛС: Canstream – интернет өргөн нэвтрүүлэг хялбарчилсан нь

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Canstream нь Нэгдсэн Вант улсын хүйн хэвлэл мэдээллийг нэгтгэсэн, гишүүнчлэлтэй, Хүйн хэвлэл мэдээллийн холбоо (СМА)-ны төсөл юм. Энэ нь шууд урсгалт, подкастинг (podcasting) үйлчилгээний хялбар, боломжийн үнэтэй хүртээмжийг хангажээ. Эхэн үедээ гишүүддээ зориулсан үнэ төлбөргүй үйлчилгээ байснаа Canstream нь одоо олон нийтээс дэмжлэг авч, тодорхой тооны хэрэглэгчийн сантай болжээ. Тэд нэвтрэх, давтан хандахад төлбөр авч, өөрийгөө санхүүжүүлдэг болсон байна. Canstream нь Нэгдсэн Вант улсад интернетийг хүйн хэвлэл мэдээллийн агуулга түгээх шинэ талбар гэж түргэн хүлээн зөвшөөрөхөд хувь нэмэр оруулсан юм.

СМА-г (Хүйн радиогийн холбооны хувьд) хүйн хэвлэл мэдээллийн бодлого, эрх зүйн шинэтгэлийн төлөө аян зохион байгуулахын тулд 1983 онд байгуулжээ. 1996 онд орон нутгийн, хүйн телевизийн шинэ боломжууд, хүйн хэвлэл мэдээллийн индэр болохын хувьд интернетийг яаралтай ашиглахын тулд илүү өргөн чиглэлтэй болж, Хүйн хэвлэл мэдээллийн холбоо гэж нэрээ өөрчилсөн байна. Тоон хуваагдал, шинэ хэвлэл мэдээллийн боломжуудын сорилд анхаарлаа төвлөрүүлэн Хүйн хэвлэл мэдээллийн холбоо нь “Тоон системд зохицох нь” хэмээх судалгаа, хөгжил, чадавх бэхжүүлэх хөтөлбөр гаргажээ.

Эдгээр ажлаас урган гарсан санааны нэг нь хэвлэл мэдээллийн шууд урсгал, хэвлэл

мэдээллийн цахим архивыг хөнгөвчлөхийн тулд дундын сервертэй болох тухай ухагдахуун байв. Ингээд 2001 онд Европын холбоо, Йоркшир, Хамберийн Бүс нутгийн хөгжлийн агентлагаас санхүүжилт авчээ. Энэ нь дэд бүтэц, техникийн дэмжлэгт хөрөнгө оруулах боломж олгон, 2002 онд Интернет хэвлэл мэдээллийн үйлчилгээ (IMS) байгуулагджээ. Хүйн хэвлэл мэдээллийн холбооны гишүүдэд үүнд чөлөөтэй нэвтрэх боломж олгохын зэрэгцээ Йоркшир дахь бүлэг хэсгүүдэд нэмэлт дэмжлэг үзүүлж байв. Энэ төсөл эзэмшигчийн программ хангамжийг ашиглаж эхэлсэн



бөгөөд хожим нь Linux үйлдлийн систем, Icast урсгалын медиа сервер ашиглан нээлттэй эх үүсвэрийн шийдэлд (open source solution) шилжсэн байна. Эрэлтэд тулгуурласан аудио, видео системийг агуулгын менежментийн системийн нээлттэй эх үүсвэр, мөн Dublin Core Metadata Initiative (DCMI) стандартад тулгуурласан, хэрэглэгчийн хүссэн мета-өгөгдөл ашиглан хөгжүүлэхийн тулд нэмэлт хөрөнгө оруулалт олсон ажээ. Ийнхүү 2003 онд хүйн хэвлэл мэдээллийн цахим 'The Showcase' архив бий болсон нь YouTube-г бүтээхээс хоёр жилийн өмнө Нэгдсэн Вант Улсын хүйн хэвлэл мэдээллийн салбарт анхдагч болсон байна.

2006 оноос RSS формат, подкастинг-podcasting (вэб синдикат ашиглан хэвлэл мэдээллийн файл түгээх)-ийн өсөлтөд хариу арга хэмжээ болгон эрэлтэд тулгуурласан үйлчилгээг медиа подкастингийн байршуулалтыг Лаудблог-Loudblog хэмээх агуулгын менежментийн нээлттэй эх үүсвэр рүү шилжүүлжээ. Энэ нь шууд явж буй өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийг архивлан, подкастингийг багтаан хэвлэл мэдээллийн агуулгыг эрчимтэй хүргэх боломж бүрдүүлсэн байна. 2007 онд энэхүү

төсөл нь Canstream хэмээх шинэ, төлбөртэй үйлчилгээ болжээ. Хоёр жилийн дотор Canstream нь тухайн үйлчилгээг ашигладаг 150 орчим хүйн хэвлэл мэдээллийн бүлгийг хамруулан хэрэглэгчдийн төлбөрөөр өөрийгөө санхүүжүүлэх болсон байна. Хэрэглэгчийн төлбөрийн орлого дээр цахим хуудас хийж өгөх, байршуулах, арга хэмжээнүүдэд дэмжлэг үзүүлдэг цахим хэвлэл мэдээлэл зэрэг нэмэлт үйлчилгээ дөхөм болдог ажээ.

Canstream нь хүйн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд хэвлэл мэдээллийн агуулгаа интернеттэй холбогдон цахим урсгалд оруулах боломж олгох, хэрвээ хүсвэл, хүйн шинэ өргөн нэвтрүүлгийн бүлгүүдэд, гагцхүү интернетийн төсөл маягаар арга хэрэглүүрээр хангаж өгдөг байна. Тэд хэвлэл мэдээллийн агуулгыг архивлах, эрэлтэд тулгуурласан цахим хэвлэл мэдээллийг хүргэх боломж олгодог. Энэ нь аль болохоор төлбөргүй, нээлттэй програм хангамжийн эх үүсвэрт тулгуурлан, түүнчлэн хурд, найдвартай ажиллагаа, хүчин чадлыг хангахын тулд Лондонгийн гол интернет солилцоон дахь сервер дээр ажилладаг. Уг төсөл нь хүйн хэвлэл мэдээллийн агуулгыг хүргэхэд интернетийн хэрэглээг түргэтгэсэн юм.

ОНЦЛОГ ШИНЖ

- Цахим хэвлэл мэдээллийн дэд бүтэц дэх салбарт хөтөлөгдсөн хөрөнгө оруулалт хийсэн
- Хүйн хэвлэл мэдээллүүдэд зориулан интернетийн тусгай үйлчилгээгээр хангадаг
- Анхлан төлбөргүй, нээлттэй програм хангамжийн эх үүсвэрт тулгуурласан
- Үйлчилгээ хэрэглэгчдийн төлбөрөөр өөрийгөө санхүүжүүлдэг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Community Media Association <http://www.commedia.org.uk>

ХОЛБОО БАРИХ

Canstream

Утас: +44 1142795219

Э-шуудан: info@canstream.co.uk

Цахим хуудас: <http://www.canstream.co.uk>



ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

Хүйн хэвлэл мэдээллийн байгууллагуудад эдийн засгийн хувьд оршин тогтноход хэцүү болох үе байнга тулгардаг.

Шоовдорлогдсон, гадуурхагдсан хүй олон, хүмүүст хүрэх, тэднийг татан оролцуулах чадвартай байх нь энэ салбарын нэг онцлог шинж юм. Ийм маягаар хүйн хэвлэл мэдээлэл нь нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлдэг ба зөвхөн арилжааны хэлбэрт суурилан ажилласнаар амьдрах чадвар бий болж, тогтвортой байдал нь хангагддаггүй. Төлбөрийн чадвартай сонсогчдыг онилон орлого олдог хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эргэн тойронд төлбөрийн чадваргүй сонсогч олноор байдаг. Учир нь, тэр хүмүүст гол гол хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүртээмж муу байдаг. Тэд хөдөөгийн алслагдсан газар нутагт оршин суугч, эсвэл хотынхны гадуурхагдсан хэсэг, эсвэл шоовдорлогдсон цөөнхийн бүлэг байдаг тул дийлэнхэд нь дуу хоолойгоо сонсох, мэдээлэлтэй байх хэрэгцээ шаардлага байдаг юм.

Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол нийгмийн үйлдвэрийн хэлбэр юм. Өмнөө тавьсан нийгмийн зорилтуудад амжилттай хүрэхийн тулд тэдгээр нь тогтвортой байдлыг хангах эдийн засгийн загвартай болохыг эрэлхийлдэг. Үүний зэрэгцээ аливаа үйлдвэрийн нэгэн адил үгүйдээ урсгал зардлаа нөхөхөд нь хүрэлцэхүйц хэмжээний орлого олохын тулд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, санхүүгийн асуудлаа шийдвэрлэх болдог билээ.

Хүйн хэвлэл мэдээллийн салбарынхаа адил эдийн засгийн тогтвортой байдлын загвар нь янз бүр байгаа хэдий ч баттай суурьтай болсон ихэнх байгууллагад хэд хэдэн нийтлэг шинж байна. Өөрийн үйлчилж буй хүй олноос хандив цуглуулах, гишүүнчлэлийн хураамж авах, зарлал явуулах, төлбөртэй үйлчилгээ явуулах гэх зэргээр хөрөнгө хуримтлуулах дэмжлэгийн стратеги байхаас гадна бусад эх сурвалжаас хөрөнгө босгох, дайчлахад бэлэн байх ёстой. Төрийн хөгжлийн агентлагууд, төрийн бус байгууллага, мөн нийгмийн харилцааны болон бусад аргаар олныг татан оролцуулах хэлбэр санал болгох зэрэг нь үүнд хамрагдах бөгөөд мөн зардалдаа

хяналт тавих, бага зардлаар үйл ажиллагаа явуулах чадвар ч хэрэгтэй болдог. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажиллаж буй хүмүүс хөлс мөнгө шаардахгүйгээр цагаа зориулах, эсвэл маш бага хөлсөөр ажиллах хэрэгтэй болдог. Учир нь тэр хүмүүс хүйн хэвлэл мэдээлэл нь нийгэмд ашиг тусаа өгдөг тэр үнэт зүйлийг ухаарч, тухайн хүй олонд үйлчлэхэд оруулж буй хувь нэмрээ үнэлэмж, шагнал гэж ойлгодог.

Гэсэн хэдий ч тогтвортой байдал гэдэг бол зөвхөн эдийн засгийн асуудлаас илүү өргөн ойлголт болохыг Дагрон (2004) болон бусад хүмүүс тэмдэглэсэн юм. Үүнд нийгмийн тогтвортой байдал, түүнчлэн байгууллагыг бэхжүүлж, тогтвортой байдлыг хангах асуудал хамрагдана. Үүний зэрэгцээ хүйн хэвлэл мэдээллийнхэн техникийн болон байгаль орчны тогтвортой байдлын сорил бэрхшээлийг анхааралдаа авах шаардлагатай.

Нийгмийн тогтвортой байдал гэдэг нь хэвлэл мэдээллийн байгууллага, өөрийн үйлчилгээ үзүүлж буй хүй олон, эсвэл сонсогчдын хоорондын харилцаа юм. Хүйн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд ийм харилцаа холбоо туйлын чухал. Учир нь, хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд олгосон эрх, түүний зорилго нь тэрхүү харилцаа холбоонд тулгуурлан нийтийн хэрэгцээнээс үүдсэн ашиг сонирхолд үйлчлэх үүрэг билээ. Хүйн хэвлэл мэдээллийн олон байгууллага нийгмийн өргөн хүрээтэй хөдөлгөөнөөс салбарласан бөгөөд тэдгээрийн мэдэгдэхүйц, мөн үл ажиглагдахуйц дэмжлэг дор үйл ажиллагаагаа үргэлжүүлж байна.

Байгууллагыг бэхжүүлэн, тогтвортой байдлыг хангах гэдгийг үйл ажиллагааны удирдлага, засаглалыг бэхжүүлэхэд чиглэгдсэн бүтцийн асуудал гэж ойлгоно. Хоорондоо тохирч бүрдүүлсэн, төлөөлөл бүхий удирдах этгээд байх ёстой. Хүйн өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн удирдах байгууллага, мөн уран бүтээл туурвих явцад ард иргэдийг татан оролцуулах нь нэн чухал. Ингэснээр “бид үүнийг эзэмшиж, үүнд оролцож буй” гэсэн мэдрэмж хүмүүст илүү төрдөг.

Техникийн тогтвортой байдал нь техникийн дэмжлэг, мөн тохирсон технологи сонгох мэдлэг шаардлагатай гэсэн үг. Технологи нь эдэлгээ даахуйц, хямд төсөр, ажиллуулахад хялбар, шаардлагатай үед орлуулах боломжтой байна. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл техникийн найдвартай системгүй байх нь сонсогч, ажилтан, дэмжигчдээ алдах эрсдэл дагуулна. Техникийн тогтвортой байдлын үүднээс авч үзвэл харилцаа холбооны технологийн хөгжлийн хурдац нь гар утас, интернет зэрэг зохистой шинэ арга хэрэгслийг ашиглах чадварыг шаардаж буй хэрэг юм.

Байгаль орчны тогтвортой байдал нь хүмүүс цаг уурын өөрчлөлттэй тулгарах болсонтой уялдан илүү тод яригдах болжээ. Хүйн хэвлэл мэдээллийн хувьд байгаль орчны тогтвортой байдлын стратеги эдийн засгийн, техникийн тогтвортой байдалд хувь нэмэр болно. Жишээ нь, нарны эрчим хүч зэрэг сэргээгдэх эрчим хүчийг ашиглаж болно. Мөн дахин ашиглах, дахин боловсруулах, хаягдал ашиглах, электрон хаягдлаас ангижрах зэрэг стратеги байгаль орчны тогтвортой байдалд багтана.

Энэ хэсэгт хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тогтвортой байдлыг хангах янз бүрийн стратегийн тухай онцлон өгүүлсэн болно. Чилийн Сантьяго дахь Тиера (Tierra) радио, Сенегалын Дакар хот дахь Ндеф Ленг (Ndef Leng) радио зэрэг нь нийгмийн хөдөлгөөнөөс үүсэлтэй. Словений Любляна дахь 1969 онд

байгуулагдсан Студент (Student) радио, 1976 оноос хойш эфиртэй байгаа Австралийн Мельбурн хотын ЗСиАр (3CR) радиогийн хүчтэй хамгаалагдсан хараат бус байдал нь удаан хугацаанд оршин тогтноход нь маргашгүй хувь нэмэр оруулсны тод жишээ мөн. Нийгэм, улс төрийн зөрчилдөөний нөхцөл байдал онцгой сорил бэрхшээл болдгийг Колумбийн Магдалена Медео бүс нутаг дахь хүйн хэвлэл мэдээллийн AREDMAG сүлжээ, Хойт Уганда дахь Апак (Арас) радио, хөдөөгийн хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд теле төвийн технологийг радио өргөн нэвтрүүлэгтэй хослуулж буй Бурундигийн Гихета хүйн хэвлэл мэдээллийн төвийн (Giheta CMC) жишээ харуулна. Йордан улсын Амман хот дахь Аль Балад (Al Balad) радио нь радио, телевизийн тусгай зөвшөөрлийг хатуу хяналтдаа байлгадаг Ойрхи Дорнодод интернетийг өргөн нэвтрүүлэгт ашиглах анхны гараа болсны жишээ. Энэтхэгийн анхны хүйн радио болох Пастапурын Сангхам (Sangham) радио нь өөртөө туслах бүлэг хэсгүүдийн сүлжээ бөгөөд хүй олны бие даасан байдал, байгаль орчны тогтвортой байдлыг хангахын тулд хэрэгжүүлдэг радио төслүүдийг дэмжих өргөн хүрээтэй стратегийнх нь нэг хэсэг юм. Манагуа хот дахь Ла Примерисима (La Primerisima) нь Никарагуадаа тэргүүлэгч, мэдээ, цаг үеийн үйл явдлын радио станц бөгөөд хүй олны санаачилга болохын хувьд хараат бус байдлаа бэхжүүлэхийн төлөө ажилтан, сонсогч, дэмжигчдээс бүрдсэн гишүүнчлэлтэй холбоо байгуулжээ.

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Dagron, A.G. (2004) Sustainability of CMCs, in Hughes, S., S.Eashwar and Jnnings, V.. (2004) A guide to community multi-media centres: How to get started and keep going. Paris: UNESCO



АВСТРАЛИ УЛС: 3CR – ард түмний хүч

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3CR нь Австрали улсын Мельбурн хот дахь хүйн радио юм. Тус радио нь хэвлэл мэдээллийн зонхилох гол хэрэгслүүдийн хүртээмж дутмаг, ялангуяа ажилчин ангийнхан, эмэгтэйчүүд, нутгийн уугуул иргэд, түүнчлэн нутгийн оршин суугчдын дуу хоолойг хүргэх, тэдэнд тулгамдаж буй асуудлыг хөндөхийн тулд байгуулагдсан. 3CR нь 1976 оноос өргөн нэвтрүүлгээ явуулж байна. Хязгаарлагдмал санхүүжилт, зар сурталчилгааг үл явуулах бодлоготой хэдий ч тэд долоо хоног тутам 130 гаруй нэвтрүүлгийг нийгэм, соёлын янз бүрийн ашиг сонирхол бүхий бүлэг хэсгүүдэд зориулан, тэдний хүчээр бэлтгэн явуулах талбар бий болгосон эрч хүчтэй, альтернатив өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг тогтворжуулсан байна.



Австрали улсад хүйн радиогийн өргөн нэвтрүүлэг 1972 онд Аделей дахь их сургуулийн 5UV радиогоор эхэлжээ. 1974 онд богино долгионы өргөн зурвас нээлттэй болсноор хурдацтай хөгжих болсон байна. Хөгжмийн өргөн нэвтрүүлгийн нийгэмлэгийн Сидней дэх (2MBS, 2004 оны арванхоёрдугаар сард байгуулагдсан), Мельбурн дэх (3MBS, 1975 оны долдугаар сард байгуулагдсан) сонгодог хөгжмийн бишрэн шүтэгчид анхны богино долгионы станцуудыг байгуулжээ. Харин 1976 оны долдугаар сард өргөн нэвтрүүлгээ эхэлсэн 3CR радио нь үүнээс тэс өөр байсан ба тэд хэвлэл мэдээллийн зонхилох гол хэрэгслүүдийн уламжлал ёсоор гадуурхан тоодоггүй нийгмийн тэр бүлгүүд,

тухайлбал ажилчин ангийнхан, нутгийн уугуул иргэд, эмэгтэйчүүдэд хүйн радиогоор дамжуулан дуу хоолойгоо хүргэхэд гол анхаарлаа төвлөрүүлдэг.

3CR радио нийт сонсогч, түүнчлэн тусгай ашиг сонирхол бүхий бүлэг, хэсгүүдийн аль алинд нь зориулан өргөн нэвтрүүлэг явуулдаг ба 20 орчим хэл дээр хөтөлбөр бэлтгэж, нийгмийн шударга ёс, байгаль орчин, соёл, хөгжим, үйлдвэрчний эвлэл зэрэг сэдвийг тусгадаг байна. Ингэхдээ 3CR-гийн олон өргөн нэвтрүүлэгч нь нийгмийн хөдөлгөөнд оролцдог хүй олны идэвхтнүүд бөгөөд мэдээ, цаг үе, үйл явдалд альтернатив байдлаар хандахдаа гарамгай хүмүүс юм. “Охид эфирт”,



“Эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн өдөр”, Австралийн шоронд хоригдож буй нутгийн уугуул эрчүүд, эмэгтэйчүүдийн амьдралыг харуулсан “Торны цаана” зэрэг нэвтрүүлэг нь үндэсний хэмжээний шагнал хүртсэн ажээ.

ЗСР нь зар сурталчилгаа, арилжааны ивээн тэтгэлэг авахгүй байх бодлого, мөн өргөн хүрээтэй хүй олны эзэмшлийн бүтцээрээ хараат бус байдлаа хүчтэй хамгаалдаг. Уг станц нь голчлон гишүүдийн татвар, хандивт түшиглэн санхүүгийн хувьд хараат бус байдаг. Үүнээс гадна радио нь жил тутам өөрийн гол хөрөнгө босгогч болох “радиотон (radiothon)”-ноороо дамжуулан 500000 австрали доллар (500000 ам.доллар)-тай тэнцэх үйл ажиллагааны нийт төсвийнхөө гуравны нэгийг олдог ажээ. Мөн станц нь

ОНЦЛОГ ШИНЖ

- Хүйн радио нь гадуурхагдсан бүлгийн дуу хоолойг хүргэдэг
- Хөтөлбөр нь нийгэм, соёл, олон хэлний илэрхийлэл болдог
- Гишүүнчлэлийн татвар, хандиваар бие даан санхүүждэг
- Хүй олонд суурилсан эзэмшил, удирдлагатай

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Community Broadcasting Association of Australia <http://www.cbaa.org.au>
- Community Broadcasting Foundation <http://www.cbf.com.au>
- Lobato, H. (2010) Community radio: the independent alternative <http://www.upstart.net.au/2010/06/07/community-radio-the-independent-alternative/>

ХОЛБОО БАРИХ

ЗСР Хүйн радио
Утас: + 61 394198377
Электрон шуудан: stationmanager@3cr.org.au
Цахим хуудас: <http://www.3cr.org.au>



Хүйн өргөн нэвтрүүлгийн сангаас тодорхой төсөл, хөтөлбөрт зориулсан нэг удаагийн тэтгэлэг авдаг байна.

1976 онд анх байгуулагдахад нь гишүүнчлэлтэй этгээд болох Хүйн радиогийн нэгдсэн холбоо (CRF)-гоор дамжуулан ЗСР-г эзэмшин өмчлөх болсон ба нэгдсэн гишүүд, станцын ажилчид, дэмжин хэрэглэгчдийн төлөөлөл түүнд багтдаг. CRF нь станцын хувьд шийдвэр гаргах эрх мэдэл бүхий удирдах дээд этгээд ба жилд дөрвөн удаа хуралдана. Өдөр тутмын үйл ажиллагааных нь төлөө долоон ажилтантай багаа удирддаг станцын менежер хариуцлага хүлээх ба Удирдлагын хороо хяналт тавьдаг. 400 орчим сайн дурын ажилтан нэвтрүүлэг хөтлөх, станцын ажиллагаанд туслах зэргээр тогтмол оролцож ажиллана.





БУРУНДИ УЛС: Гихета хүйн хэвлэл мэдээллийн төв (Giheta СМС) – энх тайван, хөгжлийг хөхиүлэн дэмжих нь

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Гихетагийн Хүйн хэвлэл мэдээллийн төв бол Бурунди улсын орон нутгийн хөгжлийн Dushirehamwe ТББ-гийн төсөл ба хөдөөгийн болон эмэгтэйчүүдийн хөгжлийг хөхиүлэн дэмжихийн тулд цахилгаан холбоо, өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээлэл ажиллуулдаг. Компьютерийн чадвар эзэмшүүлэх сургалт явуулдаг хөдөөгийн теле төвийг, хөдөөгийн эмэгтэйчүүдийн ажиллуулдаг Radio Ijwi ry'Umukemyezi хүйн радиотой хоршуулан ажиллуулснаараа энэхүү төсөл нь өмнөх зөрчилдөөний дараа эвлэрэл, энх тайвныг бүтээн босгоход тэргүүлэх үүрэг гүйцэтгэсэн. Dushirehamwe ТББ нь хөгжлийн үр дүнд хүрэх тодорхой чиглэлтэй болохын тулд оролцоонд тулгуурлан хэрэгцээ шаардлага тодорхойлох системийг ашиглажээ.

Гихета нь Бурунди улсын төв, Гишега мужид оршдог хөдөөгийн дүүрэг юм. Энэ нь нийслэл Бужумбура хотоос 100 орчим км-ын зайд оршдог. Бурунди улсын хөдөөгийн бусад нутагт ч түгээмэл байдагчлан түүний хүн амын 90 гаруй хувь нь фермерийн жижиг аж ахуйтай ба ихэнхдээ хөдөө аж ахуйн эрхлэгч байдаг. Гихета Хүйн хэвлэл мэдээллийн төв (ХХМТ)-ийг Бурунди улсын орон нутгийн хөгжлийн Dushirehamwe ТББ ЮНЕСКО-гийн санхүүгийн дэмжлэгээр байгуулжээ. Dushirehamwe ТББ нь Бурунди улсын 13 мужид оршдог хүй олны сангуудын сүлжээ бөгөөд зөрчилдөөний дараа эвлэрэл, энх тайвны бүтээн босголт, хөгжлийн төлөө үйлст тэргүүлэх үүрэг гүйцэтгэх хөдөөгийн

эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхийг чармайн ажилладаг. Тэдний төслүүд жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх, зөрчилдөөний зуучлал, эвлэрлийн асуудалд төвлөрөн, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг тэмцдэг.

Гихета ХХМТ нь орон нутгийн хүмүүст утас, интернетээр үйлчилж, компьютерийн чадвар эзэмшүүлэх сургалтын тоног төхөөрөмж бүхий теле төв, мөн хүйн радио станцтай. Ijwi ry'Umukemyezi Радио (RIU) нь 1990-ээд оны эхэн үед болсон иргэний дайнаар ядуурал гуйланчлалд хүчтэй нэрвэгдсэн иргэдэд үйлчилдэг. Энэ нь “Эмэгтэйчүүдийн дуу хоолой” гэсэн үг бөгөөд нутгийн хүй олон дундаас, хөдөөгийн эмэгтэйчүүд үйл

ажиллагааг нь явуулдаг байна. Хүйн радио станцыг Бурунди улс, босогчдын янз бүрийн хөдөлгөөнүүдийн хооронд энх тайвны гэрээнд гарын үсэг зурсан тэр үед суурилуулсан ажээ. Хөдөө аж ахуйг дахин сэргээх, урьд өмнө нь сөргөлдөж байсан бүлгүүд энх тайвнаар зэрэгцэн орших, эрх чөлөөтэй хамтран амьдрахад туслах, хүний эрхийг хүндэтгэхийг ухааруулах, орон нутгийн ардчилал, эрүүл мэнд, боловсролыг хөхиүлэн дэмжихэд хувь нэмрээ оруулахад зориулан RIU-ийн хөтөлбөрийн агуулгыг боловсруулсан байна.

Dushirehamwe ТББ-ын сүлжээ нь хүй олны сан бүр нь муж, хотын засаг захиргааны хороог хамруулсан сайтар бодож боловсруулсан засаглалын бүтэцтэй, байгууллагын тов тод, алсын хараатай, технологийн талбар гэхээсээ илүү хөгжлийн үр дүнд гол анхаарлаа төвлөрүүлдэг. Орон нутгийнхаа хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд орон нутгийн

эзэмшлийг баталгаажуулахын тулд хүй олонд суурилсан, оролцоо бүхий хэрэгцээ шаардлага тодорхойлох систем ашигладаг байна. Өмнөө тавьсан зорилтууддаа хүрэх боломж олгохын тулд Dushirehamwe ТББ-д орон нутаг, олон улсын зүгээс санхүү, техникийн тусламж ирсэн байна.

Гихета ХХМТ нь хөгжлийн зорилгоо биелүүлэхийн тулд теле төвийн технологийг хүйн радиотой хослуулахын ашиг тусыг харуулж чадсан юм. Зөрчилдөөнт байдлаас сэргээн босголт шилжсэн улс оронд нутгийн хүй олонд суурилсан харилцаа холбоогоор дамжуулан яриа хэлэлцээ өрнүүлэх нь найрсаг харилцаа тогтоох, эвлэрүүлэх, энх тайвныг бүтээн босгох үйл явцад амин чухал зүйл юм.

Гихетад эмэгтэйчүүд орон нутгийн хөгжилд өргөн хүрээнд үр нөлөө үзүүлж буй хүйн хэвлэл мэдээллийн санаачлагыг тэргүүлэн, энэ үйл явцад манлайлж байна.

ОНЦЛОГ ШИНЖ

- **Цахилгаан холбоо, хүйн радиог хослуулсан Хүйн хэвлэл мэдээллийн төв**
- **Зөрчлийн дараах эвлэрэл, энх тайвны бүтээн босголт, хөгжилд гол анхаарлаа төвлөрүүлдэг**
- **Сайтар боловсруулсан засаглалын бүтэц, байгууллагын тов тодорхой алсын хараатай**
- **Зорилтуудаа хүй олонд суурилсан, оролцоо бүхий хэрэгцээ шаардлагын судалгаагаар тодорхойлдог**

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Nkurunziza, J.P. (2009) Radio Ijwi ry'Umukenyenzi (Voice of the woman) of Giheta
<http://www.telecentre.org/profiles/blogs/radio-ijwi-ry-umukenyenzi-voice>

ХОЛБОО БАРИХ

Radio Ijwi ry' Umukenyenzi "R.I.U 104.1 FM"
Утас: +257 29554706
Электрон шудан: ijwi.umukenyenzi@yahoo.fr



ЧИЛИ УЛС: Тиера (Radio Tierra) радио нь олон нийтийн хөдөлгөөнд үндэслэгдсэн

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тиера (Tierra) радио нь Чили улсын Сантьяго хотод байдаг хүн хэвлэл мэдээллийн хөтөлбөр юм. Уг хөтөлбөр нь ардчиллын үйл хэрэг, нийгмийн өөрчлөлтийн төлөө 25 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй эмэгтэйчүүдийн хөгжлийн төлөөх "Ла Морада" ашгийн бус нийгэмлэгийн улс төрийн чиг хандлага болоод практик туршлага дээр суурилжээ. Жендерт суурилсан төлөв байдалтай, эмэгтэйчүүдийн харилцаа, эрүүл мэнд, иргэншлийн асуудалд анхаарлаа төвлөрүүлсэн Тиера радио нь хүний эрх, нийгмийн шударга ёсыг хамгаалагч төдийгүй нийгмийн идэвхийн талбарын хувьд үндэсний, мөн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байна.

Чили улсад ардчиллыг сэргээн босгосноос хойш нэг жилийн дараа буюу 1991 онд байгуулагдсан Тиера радио нь Чилийн Сантьяго хотын оршин суугчдад AM дунд долгионоор өдөр бүр 4 цагийн хараат бус, хүй олонд тулгуурласан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлж байна. Түүнчлэн 2004 оноос хэвлэл мэдээллийн агуулгын шинэ хэлбэрүүд бий болгох боломж олгосон, мөн дотоод, гадаадын сонсогчдод зориулсан радио дохионы өргөн нэвтрүүлэг цацах интернетиин боломжид тулгуурлан ажиллаж байна. Тиера радио нь иргэний дундаас үүссэн бөгөөд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, харилцах эрхээ эдлэх нь ардчилсан аливаа нийгмийн гол үндэс хэмээн үнэт зүйлсээ тодорхойлжээ. Түүнчлэн,

иргэний нийгмийн тодорхой сонирхлыг тусгах, иргэд хоорондын харилцааг бэхжүүлэх, эмэгтэйчүүдийн оролцоог идэвхжүүлэн хангахыг эрмэлздэг байна.

Сантьяго хотноо төвтэй Corporaciyn Feminista La Morada эмэгтэйчүүдийн байгууллага нь Данийн Эмэгтэйчүүд, хөгжлийн төлөөх KULU (Kvindernes U-landsudvalg) төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр Тиера радиог үүсгэн байгуулжээ. La Morada байгууллага нь тус радиотой менежментийн туршлагаасаа хуваалцан, түүний тогтвортой байдал, хөгжин дэвшихэд шаардагдах хөрөнгө, нөөцтэй болох боломж олгосон. Тус байгууллага нь мөн радио станцын чиглэл, агуулгыг тодорхойлох улс төрийн феминист чиг хандлага, түүнчлэн



менежмент, өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх үйл явц бий болгожээ.

Тиера радио нийгмийн харилцаан дахь санаа бодол уралдуулах талбар болсоор байна. Зарим хүмүүс түүнийг нийгмийг өөрчлөх феминист үзэл баримтлагч гэдэг бол нөгөө хэсэг нь нийгмийн хөдөлгөөнүүд шууд харилцах талбар хэмээн үздэг. Сүүлийн жилүүдэд тус радио нь Чилид олон нийтийн байгууллагын дахин сэргэх үйл явц болоод Латин Америк дахь нийгмийн шинэ хөдөлгөөний өсөлт бойжилтод нөлөөлжээ. 'Voces de la Ciudadania' нэвтрүүлгийн гол шугам нь иргэд эвлэлдэн нэгдэх, харилцах орон зай бөгөөд сүүлийн 10 жилийн дотор хэдэн зуун хувь хүн, олон нийтийн байгууллага, хамт олон, сүлжээг хамруулжээ.

ОНЦЛОГ ШИНЖ

- Иргэний нийгэм, эмэгтэйчүүдийн хөдөлгөөн дэх нийтэч суурьтай
- Иргэншил, хүний эрх, ардчиллаас гаралтай үнэт зүйлстэй
- Оролцооны болон өөрөө танигдах менежментийн загвартай
- Үйл ажиллагаа, эдийн засгийн үндсийн олон талт хөгжилтэй

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Poblete, Juan (2006) Culture, neo-liberalism and citizen communication: the case of Radio Tierra in Chile, *Global Media and Communication* Vol 2(3) pages 315-334. Sage Publications
- Wilson, Perla (2006) Democracia al débito en las comunicaciones, *Cara y Señal*, Volume 5. AMARC-ALC <http://www.caraysenal.agenciapulsar.org/0.php?cys=5&s=5&n=1>

ХОЛБОО БАРИХ

Тиера радио
Утас: +562 7351779
Цахим хуудас: <http://www.radiotierra.com/>



Тиера радио нь Чилид өрнөсөн улс төрийн асар том өөрчлөлтийн үеэс эхтэй юм. Тус радио нь нийгэм, улс төрийн үнэт зүйлс дээр суурилсан бөгөөд энэ үзэл баримтлалдаа тууштай байхын зэрэгцээ нийгмийн харилцааны суурь болсон үүрэг хариуцлага, үйл ажиллагаандаа хяналт тавьж, шүүмжлэлтэй хандаж чаддаг байна. Тиера радиогийн феминист болон олон нийтийн өргөн хөдөлгөөний баттай нийтэч суурь, гишүүдийнх нь хамтач хүсэл зориг, туршлага, мөн сургалт явуулах, үйлдэлд дуудсан нийгмийн кампанит нэвтрүүлэг бэлдэх, түгээх, хамтын ажиллагааны төсөл боловсруулах, түүнчлэн зар сурталчилгаа, арилжааны ивээн тэтгэлэг зэрэг санхүүжилтийн олон загвар нь тогтвортой байдлын үзүүлэлтүүд болно.





КОЛУМБ УЛС: AREDMAG – зөрчилдөөний үед хэвлэл мэдээллийг хамгаалах нь

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Колумб улс нь Латин Америкийн орнуудаас хүйн өргөн нэвтрүүлгийн эрх зүй, зохицуулалтыг тусгайлан хангасан анхдагч орнуудын нэг юм. Гэсэн хэдий ч, хүртээмж нь төдийлэн баталгаажаагүй байна. Зэвсэгт мөргөлдөөн нүүрлэсэн Магдалена Медио нутаг дахь иргэд дуу хоолойгоо сонсгохын төлөө тэмцэх шаардлага тулгарсан аж. Магдалена Медио дахь AREDMAG (La Asociaciyn Red de Emisoras Comunitarias del Magdalena Medio) хүйн радиогийн сүлжээ нийгэмлэг эрхийнхээ төлөө нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, орон нутагт чадавх бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн.

Колумбийн эрх зүйн бодлого, зохицуулалт нь хүйн өргөн нэвтрүүлгийг хүлээн зөвшөөрдөг. Ингэснээр 1000 гаруй хүйн радио байгуулагдах боломж олгосон боловч зэвсэгт мөргөлдөөн, хагас цэрэгжилтийн бүлгийн нөлөөлөлд автсан бүс нутагт эдгээр өргөн нэвтрүүлгийн эрх зүй, зохицуулалтын хүч суларсан. Магдалена Медио дахь AREDMAG нь зөрчилдөөн нүүрлэсэн энэ бүс нутгийн нийгмийн институт, хөдөлгөөнүүдэд чухал дэмжлэг болж байна.

AREDMAG нь оролцоо бүхий хүй олныг идэвхжүүлэн, түүнчлэн орон нутгийн хөгжлийн төслүүдээр хүйн радиог дэмждэг иргэний нийгмийн холбоо юм. Уг сүлжээ нь Магдалена Медио дахь Хөгжил ба энхийн хөтөлбөрийн харилцаа, соёлын стратегиас эхтэй бөгөөд тухайн бүсийн зэвсэгт

мөргөлдөөнийг багасгахад чиглэгджээ. Энэ хүрээндээ, AREDMAG радиогийн үндсэн зорилт нь соёл, мэдээлэлд тулгуурласан хөтөлбөр бүтээх арга замаар хүйн радиог хүчирхэгжүүлснээр энхийн үйл явц, тогтвортой хөгжлийг хангах нийгмийн харилцааны хэлбэрүүдийг бий болгон, хөгжүүлэх явдал болно. Уг сүлжээ нь агуулгын үйлдвэрлэл, технологийн хөгжлийг дэмжиж, сүлжээнийхээ хүрээнд өөрийн менежментийн ур чадварыг дээшлүүлэх, соёлын өвөрмөц шинжийг олонд таниулах, радио станцуудын санхүүгийн тогтвортой байдлын механизмыг хамтран бий болгох чиглэлээр орон нутгийн хүйн өргөн нэвтрүүлэгчидтэй хамтран ажилладаг.

AREDMAG сүлжээний амжилтын нэг хэсэг нь Магдалена Медио нутгийн хүн амын

мэдээлэлтэй байх эрхийг нь хамгаалах замаар хүйн радиог бүх нийтээр хүлээн зөвшөөрөх хандлага бий болгож, хөхиүлэн дэмжихэд оруулж буй хувь нэмэр юм. Практик түвшинд уг сүлжээ нь хүүхдийн эрх, тэдний өөрийгөө илэрхийлэх боломж руу чиглэсэн сэдэвчилсэн нэвтрүүлгийг дэмжих замаар хүүхдэд зориулсан мэдээллийн орон зай бий болгодог. Сүлжээний дэмжлэг нь хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл оршин тогтнох, тогтвортой байхад зайлшгүй хэлхээ холбоо гэдгийг AREDMAG харуулсан. Сургалт

ОНЦЛОГ ШИНЖ

- Хүйн радиогийн иргэний нийгмийн нийгэмлэг ба сүлжээтэй
- Энх тайван, зөрчил бууруулах ба хөгжлийн төлөө хүсэл зоригтой
- Хүмүүсийн харилцах эрхийн төлөө нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг
- Сургалт, агуулга үйлдвэрлэл, техникийн туслалцаа үзүүлдэг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- The Communication Initiative Network Community Radio Network Association of Magdalena Medio (Asociación Red de Emisoras Comunitarias del Magdalena Medio - AREDMAG)
<http://www.comminet.com/es/node/127870/306>

ХОЛБОО БАРИХ

La Asociaciyn Red de Emisoras Comunitarias del Magdalena Medio
Утас: +57 3123778346
Электрон шуудан: aredmag@aredmag.org.co
Цахим хуудас: <http://www.aredmag.org.co/>

зохион байгуулах, хоорондоо холбоо бүхий радио станцуудын хооронд нэвтрүүлгээ нэмэгдүүлэхийн тулд агуулга солилцох, хамтран ажиллахад анхаардаг. AREDMAG-ын хүйн радиогийн үүрэг бол энх тайван цогцлоох хөдөлгөгч хүч гэж үздэг хандлага нь өвөрмөц. Энэ нь итгэж үнэмшүүлэх илгээлт дамжуулах хандлагаас илүүтэйгээр хүйн нэгж бүрийг энхийн бүс гэж үзэж, эрхийнхээ дагуу иргэдийн харилцан яриа, шийдвэр гаргах оролцоог бэхжүүлснээр эсрэг тэсрэг санаа бодолд хүлээцтэй хандахыг хөхиүлэн дэмждэг.





ЭНЭТХЭГ УЛС: Сангхам радио (Sangham Radio) нь гадуурхагдагсдын дуу хоолойг хүргэх нь

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сангхам радио нь Энэтхэг улсад эфирээр нэвтрүүлгээ цацсан хамгийн анхны хүйн радио бөгөөд 2006 онд батлагдсан Энэтхэг улсын Хүйн радиогийн бодлогын үр дүн юм. Тус радиог эмэгтэйчүүд удирддаг бөгөөд нийгмийн бүлэг болох далитчуудад зориулагдсан анхны радио станц гэдгээрээ онцлог. Андра Прадеш мужийн Медак дүүргийн Пастапур дахь Мачнор тосгонд байрлах уг радио станц нь 90.4 богино долгионоор өдөрт цаг гучин минутын нэвтрүүлэг цацдаг ба 75 орчим тосгоны оршин суугчдад хүрдэг.

.....

2008 оны 10 сарын 15-нд Сангхам радио богино долгион ашиглан хүйн радиогийн хараат бус үйлчилгээ үзүүлж эхэлсэн нь Энэтхэгийн хүйн радиогийн хөгжилд түүхт өдөр байв. Энэ нь тосгоны далит эмэгтэйчүүдтэй 20 гаруй жил ажилласан Деккан хөгжлийн нийгэмлэг (DDS) төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр 10 гаруй жилийн турш Пастапурын хүйн олны хүрээнд явуулсан хөгжлийн үйл ажиллагааны оргил нь байлаа.

Деккан хөгжлийн нийгэмлэг нь 1999 онд орон нутгийн иргэдэд зориулсан аудио, видео нэвтрүүлэг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг санаачилсан байна. Уг төсөл нь тосгоны сангхам (эмэгтэйчүүдийн өөртөө туслах бүлгүүд) бүлэгт төвлөрөн, өөрийн зохион байгуулалт болоод өөртөө туслах уламжлал дээр үндэслэгджээ. Community Media Trust (Хүйн хэвлэл мэдээллийн итгэлцэл) байгууллага



(Сангхам радио түүний нэг хэсэг болдог) нь 2001 онд бичиг үсэгт тайлагдаагүй 7 далит эмэгтэйн удирдлага дор байгуулагдсан. Тэд анхны аудио бүтээлүүдээ дуу бичлэгийн хальсанд бичиж тараажээ. Хожим нь, ЮНЕСКО болон бусад байгууллагын дэмжлэгээр студийн тоног төхөөрөмж, дамжуулагчтай болж, радио



станцын дэд бүтцийн ажил дууссан. 2006 оны 11 дүгээр сард Энэтхэгийн хүйн радиогийн бодлого батлагдах үеэр 600 цагийн бэлэн хөтөлбөртэй хүйн радиогийн хүчин чадал бий болсон байв. Зөвхөн эфирт гарах зөвшөөрөл л хэрэгтэй байв. DDS нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө 2007 оны эхээр Энэтхэг улсын Мэдээлэл, өргөн нэвтрүүлгийн яаманд гаргасан байна. Ингээд 18 сарын дараа зохицуулалтын зөвшөөрөл авах эцсийн шат дамжлагыг дуусгажээ.

Сангхам радио нь гадны дэмжлэг авсан нь ашигтай болсон хэдий ч түүний тогтвортой байдал нь орон нутгийн иргэдийн эдийн засаг, нийгмийн дэмжлэгээс үүсэлтэй. Сангхам радиод санхүүгийн туслалцаа үзүүлэх төлөвлөгөө 2009 оны долдугаар сард албан ёсны болсон байна. Уг төлөвлөгөөний дагуу, 5000 сангхам иргэн тус бүр сар болгон 50 рупи хандивлах бөгөөд радио станц жилдээ 250,000 рупи буюу ойролцоогоор 5000 ам.долларын хандив цуглана гэсэн үг.

ОНЦЛОГ ШИНЖ

- Энэтхэг улсад байгуулагдсан анхны хүйн радио
- Далит эмэгтэйчүүдийн өөртөө туслах (Сангхам) бүлгүүдэд тулгуурласан/төвлөрсөн
- Хүй олны бие даасан байдлыг хангах алсын хараатай
- Хүй олны бүлгүүдийн дэмжлэгтэйгээр тогтвортой ажилладаг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Pavarala, V, and Malik, K (2007) *Other Voices: The struggle for community radio in India* New Delhi: Sage Publications

ХОЛБОО БАРИХ

Deccan Development Society
 Утас: +91 8451282271
 Электрон шуудан: ddspastapur@gmail.com
 Цахим хуудас: <http://www.ddsindia.com>

Медак бол тус улсын хамгийн буурай хөгжсөн, ган гачигт нэрвэгдсэн газрын нэг юм. Тэнд ядуурлын түвшин өндөр. Өөрсдийнх нь мэдлийн хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь ядуурлыг арилгах гол хүчин зүйл болж чадна хэмээн орон нутгийн далит эмэгтэйчүүдийн урт хугацааны турш мэдэрч байсан тэр хэрэгцээнийх нь оргил бол Сангхам радио юм. Хүйн радио нь гадуурхагдсан бүлгийн хэтийн төлөв байдал, хэрэгцээ шаардлагын төлөө дуугардаг. Түүний ололт амжилт нь Пастапур дахь далит эмэгтэйчүүдийн өөрсдийн гэсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болох гэсэн том зорилготой нягт уялдаатай. Тогтвортой байдал нь тогтвортой хөгжилд зайлшгүй шаардлагатай бие даасан хүйн олон байх алсын хараатай холбоотой. Сангхам радиод ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувьд бие даасан байдал гэдэг нь хоол хийхээс гадна мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийнх нь бие даасан байдал гэсэн үг юм. Төсөл нь үндэсний хэмжээнд хүйн радиогийн анхдагч болохын зэрэгцээ тухайн газар нутагтаа өөртөө туслах болоод харилцан туслалцах бат бөх үндэстэй.





ЙОРДАН УЛС: Аль-Балад (Radio Al-Balad)-интернет-эхлэх цэг болох нь

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Аль-Балад буюу хуучнаар АмманНет FM радио нь Йорданы анхны хүйн радио юм. Түүнийг мөн Арабын ертөнц дэх анхны интернет радио гэж үздэг. 2000 онд интернетээр өргөн нэвтрүүлэг эрхлэгч, цахим хуудас хэлбэрээр хууль тогтоомжийн хязгаарлалтуудыг тойрч үйл ажиллагаагаа эхэлжээ. 2005 оны долдугаар сард хувийн радио станцууд албан ёсны зохицуулалтын зөвшөөрөл авч эхэлснээс хойш FM 92.4 радио газрын дамжуулалтаар өргөн нэвтрүүлгээ цацаж эхэлсэн. Бүс нутагтаа хүйн радиогийн анхдагч хэмээн алдаршсан.

2000 онд сэтгүүлч Дауд Кутаб болон хараат бус хэвлэл мэдээллийн хэсэг ажилтан газрын дамжуулалтын долгион нь төрийн монополийн хяналтанд байдаг улсад интернетээр өргөн нэвтрүүлэг цацах боломж гарсанд зоригжин АмманНет радиог үүсгэн байгуулжээ. Радио станцыг анхлан ЮНЕСКО болон Их Амманы засаг захиргаа дэмжсэн байна. Тус радио өргөн нэвтрүүлгийн орчныг нээлттэй болгоход Йорданы засгийн газарт нөлөөлөн хурдасгагчийн үүрэг гүйцэтгэж, 2005 онд Йорданд албан ёсоор эзэмшигчийн тусгай зөвшөөрөл авсан анхны хүйн өргөн нэвтрүүлэг эрхлэгч болсон байна.

Богино долгионы өргөн нэвтрүүлгийн зөвшөөрөл эзэмшдэг болсноос үүдэн нэрээ Аль-Балад хэмээн өөрчилж, орон нутгийн мэдээ, цаг үе үйл явдалд тусгайлан төвлөрч

хөгжсөөр байна. Орон нутгийн асуудлууд анхаарлын гадна үлддэг хэт төвлөрсөн хэвлэл мэдээллийн орчинд үйл ажиллагаа явуулж буй радио станц парламент болон хотын захиргааны үйл ажиллагааг сурвалжилж эхлэхэд албаны зарим хүрээллийн эсэргүүцэлтэй анхандаа тулгарч байв. Гэсэн хэдий ч, радио нь хөл дээрээ бат зогссон бөгөөд мэдээ, улс төрийн хөтөлбөр явуулах тусгай зөвшөөрлөө амжилттай авчээ. Мэдээг ингэж голчлон сонгосон нь сонсогчдынх нь тоог нэмэгдүүлсэн бөгөөд 2009 оны Йорданы хэвлэл мэдээллийн судалгаагаар орон нутгийн мэдээний цахим хуудас дотор тэргүүлэх байр эзлэв.

Аль-Бадад радиогийн хөтөлбөрийн хүрээ нь гүнзгий сэтгэгдэл төрүүлдэг. Орон нутгийн мэдээ, цаг үе үйл явдлын сурвалжлагаас гадна, орон нутгийн хөгжимчдийг дэмжиж,

спортын мэдээ, сурвалжлага өргөнөөр нэвтрүүлдэг байна. Олон нийтийн оролцоог хангах, тэдний санал сэтгэгдлийг сонсохын тулд утсаар шууд харилцах нэвтрүүлэг хийдэг. Эмэгтэйчүүдийг дэмжих нь тэдний онцгой асуудлыг явуулахад анхаардаг. Тус радио нь мөн сургуулиудтай хамтран ажилладагаараа нэртэй. Сурагчдыг залуучуудын сонирхлыг тусгасан долоо хоног тутмын нэвтрүүлэг бэлтгэхэд сургаж, тэдэнд дэмжлэг үзүүлдэг байна.

Олон нийтийн, хувийн, хүйн хэвлэл мэдээллийн хоорондын чиг шугам Йордан улсад бүдэг хэвээр байна. Аль-Бадад радиог арилжааны радио хэмээн тооцох нь элбэг ч, түүний зарчим, үйл ажиллагаа нь хүй олонд чиглэгдсэн байдаг. Радио нь хандивлагчдын зар сурталчилгаа, студийн түрээс, мессежээр сонсогчдын санал сэтгэгдлийг хүлээн авах зэрэг орлого олох механизмтай хослуулах

ОНЦЛОГ ШИНЖ

- Ойрхи Дорнод дахь интернет, богино долгионы хүйн радиогийн анхдагч
- Орон нутгийн мэдээ, цаг үе үйл явдал, улс төрийн сурвалжлагаараа онцлог
- Хандивлагчдын дэмжлэг, өөрийн орлого бүхий эдийн засгийн холимог загвар
- Бүс нутагтаа хүйн хэвлэл мэдээллийг дэмжих төв болон хөгжиж буй

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- AmmanNet <http://en.ammannet.net/>

- Agrabawe, T., S. Zaida, D. Kuttub (2008) Community Radio for Development in Jordan

ХОЛБОО БАРИХ

Аль-Бадад радио

Утас: +962 64645486

Электрон шуудан: Info@ammannet.net

Цахим хуудас: <http://www.balad.fm/>

замаар эдийн засгийн холимог загварыг бий болгожээ. Хөтөлбөр, удирдлагын бүтэц нь хүй олны эзэмшил, орон нутгийн оролцоотой, түүнчлэн удирдлагын зөвлөлд ажиллагсадын төлөөлөл байдаг. Засаглалын хувьд сонсогчдын клуб байгуулдаг албан ёсны тогтолцоотой.

Аль-Бадад радио нь улс төр, эрх зүй, зохицуулалтын ихээхэн саад тогтортой нөхцөлд үр дүн бүхий нөлөөллийн ажиллагаа, интернетийг шинээр ашиглах замаар бүс нутагтаа хэвлэл мэдээллийн ардчилалд хувь нэмрээ оруулсан юм. Ингэж ажиллахдаа, тус радио нь Йордан болон Ойрхи Дорнодын бусад улс оронд хүйн радио байгуулахад анхны шанг татжээ. АмманНет сургалтын төв нь Сири, Египет, Саудын Араб болон Палестины сэтгүүлчдийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.





НИКАРАГУА УЛС: Ла Примерисима (La Primerisima) бол ард түмэн эзэмшдэг мэдээний радио

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ла Примерисима радиогийн хуучин болон тухайн үеийн ажилчид нийлэн 1990 онд Никарагуагийн Радио өргөн нэвтрүүлгийн мэргэжилтнүүдийн холбоо (La Asociación de Profesionales de la Radiodifusión – APRANIC) байгуулжээ. Энэ баг нь, хүй олны чин сэтгэлийн санаачилгаар байгуулагдсан радиогоо өөрсдөө эзэмших замаар хараат бус байдлаа хамгаалах зорилт дэвшүүлжээ. APRANIC-ийнхан радиогийнхоо хууль ёсны эзэмшигч байх оролдлого нь амжилт олсон юм. Удаах 20 жилийн хугацаанд Ла Примерисима нь түүний нийгэм, соёл, байгууллагынхаа зорилтуудыг тогтворжуулахын тулд оролцоо бүхий удирдлага, хөтөлбөрийнхөө хүрээг тэлжээ.

APRANIC нь Ла Примерисима радиогийн хараат бус байдлыг хамгаалахын төлөө нэгдсэн сэтгүүлч, ажилтан, сонсогч, мөн тэднийг дэмжигч хүний эрхийн олон улсын бүлгүүдийн холбоо юм. Энэ нь мэдээ, цаг үе, үйл явдлын хөтөлбөрөөрөө радио үйлчилгээ эрхэлдэг Никарагуадаа тэргүүлэх радио юм. Уг бүлэг төрийн эзэмшилд байсан радиогийн техник, бусад эд хөрөнгийг Холбоонд хандивлах хүсэлт тавин хөөцөлдсөн нь амжилттай болжээ.

Багийн Ла Примерисима радиогийн амин чухал тулгуур болох оролцооны механизм, ил тод удирдлага, ардчилал ба ажилчдын эзэмшил гэсэн зарчмыг үйл ажиллагаандаа баримталдаг. Бүх гишүүд нь үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, бодлого, хөтөлбөрт хийх аливаа өөрчлөлтийг соёрхон баталдаг

Ерөнхий чуулганд оролцоно. Эндээс гаргасан шийдвэрүүдийг Ерөнхий чуулганаас нэр дэвшүүлсэн Гүйцэтгэх зөвлөлөөр дамжуулан радиогийн удирдлагад хүргэдэг байна. APRANIC нь өөрийн үйлчилгээ үзүүлж буй хүй олонтойгоо хэрхэн харилцах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох замаар оролцоо бүхий хэвлэл мэдээллийн төлөө хүсэл зоригийг хадгалан хамгаалдаг. Үндэсний чөлөөлөлтийн сандинист фронт (FSLN) байгууллагатай улс төрийн холбоотой байсан өмнөх түүхээс үл хамааран шударга, үнэн мэдээ сурвалжлага бэлтгэн явуулдаг хэмээх тус радиогийн нэр алдрыг өргөхийн төлөө Холбооны гишүүд бүрэн хариуцлага хүлээдэг. Бодлогын шийдвэрүүд нь радио станцыг засгийн газраас хол байх, хувь хүмүүсийн зүгээс агуулгад хяналт тавих гэсэн оролдлогоос ангид байхад зориулагддаг.

Үүний зэрэгцээ редакц нь өөрөө сонсогчидтойгоо байнга харилцан холбоотой байж тэнцвэрт байдлаа хадгалдаг.

Ла Примерисима радиогийн жишээ нь төрийн өргөн нэвтрүүлгийн өмч хөрөнгийг соёлын хувьд тохиромжтой, найрсаг хандлагаар ард иргэдийн эзэмшилд шилжүүлсний үлгэр дууриал юм. “Ард түмний радио” гэгдэх чиглэл бол түүний бүхий л үйл ажиллагааных нь цөм бөгөөд эргээд хүмүүс өөрсдөө радиогоо тогтвортой байлгадаг. Ла Примерисима радио Никарагуа даяар нэвтрүүлгээ цацаж, газар зүйн байрлалын хувьд тодорхой нутгийн иргэд гэж заагладаггүй боловч ядуучууд тухайн орны өнцөг булан бүрт оршин суудаг. Чухамхүү, тэд л энэ радиог улсын хамгийн нэр хүнд бүхий гурван хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэгэнд тооцогдоход нөлөөлжээ.

ОНЦЛОГ ШИНЖ

- Хараат бус мэдээ, цаг үе үйл явдлын нэвтрүүлэг эрхэлдэг радио үйлчилгээ
- Үндэсний хэмжээнд ашиг сонирхол бүхий хүй олонд үйлчилдэг
- Ажилчид, сонсогчид, дэмжигчдийнхээ эзэмшилд байдаг
- Оролцоо бүхий ил тод засаглалын бүтэц

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Dragon, Alfonso Gumucio. CFSC Case Study: La Primerisima. Communication for Social Change Consortium. <http://www.communicationforsocialchange.org/mazi-articles.php?id=241>

ХОЛБОО БАРИХ

Ла Примерисима радио
Утас: +505 22227936
Электрон шуудан: info@radiolaprimerisima.com
Цахим хуудас: <http://www.radiolaprimerisima.com/>

Никарагуачууд бүгдээрээ энэ радиогийн дуу хоолойг дэмждэггүй бөгөөд түүний хараат бус байдал өөрийн гэсэн үнэ цэнэтэй. Анхны жилүүдэд дээрэмчид Санта Клара дахь радиогийн дамжуулагч, тоног төхөөрөмжийг ул мөргүй болтол нь галдан шатаажээ. Ла Примерисима дэд бүтцээ сэргээн босгож, эфирт эргэн ирэхийн тулд орон нутгийн болон олон улсын нөхөрлөлүүдээс тусламж хүссэн билээ. Энэ нь тухайн радио нийтийн хэрэгцээ, мөн хүйн олны оролцоонд үндэслэгдсэнийг тод томруун харуулсан юм. Эдийн засгийн доройтол нүүрлэж, санхүүгийн бэрхшээл тулгарсан тэр цаг үед APRANIC нь бүтээлч шийдлүүдийг боловсруулжээ. Үүний нэг жишээ нь, нэвтрүүлэг бүрийг “бичил үйлдвэр” гэж үзэн, продюсерууд нь өөрсдийнхөө нэвтрүүлгийн зардлаа нөхдөг уламжлалт бус арга байсан юм.





СЕНЕГАЛ УЛС: Ндеф Ленг (Radio Ndef Leng) радио нь сонсогчдод ярих боломж олгодог

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ндеф Ленг радио нь Сенегал улсын нийслэл Дакар хотод оршин суудаг цөөнхийн хамгийн том бүлэг болох сереречуудад зориулсан радио юм. Энэ бол 14 хэл дээр нэвтрүүлэг бэлтгэн цацдаг, яриа зонхилдог радио юм. Зорилтот хүй олноосоо хүчтэй язгуурласан энэ радиогийн санхүүгийн эх үүсвэрийн ихэнх хэсэг нь харилцан яриа, хэлэлцүүлгийн шууд нэвтрүүлэгт идэвхтэй оролцдог өөрийн сонсогчид, түүнчлэн гишүүнчлэлийн татвар, хандиваас бүрддэг. Радио станц нь цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчээр дамжуулан хүлээн авч буй дуудлагаас орлого олж, түүнийгээ сонсогчдын утасны төлбөрөөс нэхэмжилдэг.

Union des associations culturelles Sÿrire байгууллага 1994 онд байгуулагдаж, 1996 онд төрийн бус байгууллага хэмээн хүлээн зөвшөөрөгджээ. Радио нь серере хэлээр яригчдын хэл, соёлыг хөхиүлэн дэмжих, соёл, нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөө ажилладаг 43 бүлэг, холбооноос бүрдсэн сүлжээгээр дамжуулан тэдний нэгдэл нягтралд туслах зорилготой. Харилцаа холбооны хэрэгслийн хүртээмж дутмаг байсан нь эдгээр холбоодын сул тал гэдгийг Холбоо мэдэрсэн байна. Ингээд 1999 онд хүйн радио байгуулах шийдвэрт хүрчээ. Мэдээллийн яаманд хандан тусгай зөвшөөрөл хүссэний дагуу 2001 оны 4 дүгээр сард зөвшөөрсөн хариу авч, 2001 оны долдугаар сарын 19-нд эфирт гарчээ.

Ндеф Ленг радио нь серере хэлнээс гадна франц, волоф хэл дээр шууд мэтгэлцээн,

хэлэлцүүлэг болон боловсролын нэвтрүүлгийг багтаасан холимог хөтөлбөртэй. Мөн 3500 гишүүнтэй сонсогчдын клубтэй, 100 гаруй хүн нэвтрүүлэг бүтээхэд оролцдог. Радиог сайн дурынхан ажиллуулдаг ч сайн дураараа тогтмол ажиллагчид урамшуулал авдаг байна. Радиогийн сонсогчид маш идэвхтэй, радио нь тодорхой асуудал, цаг үеийн үйл явдлын талаар утсанд холбогдон санал бодлоо илэрхийлэхийг хүссэн сонсогчдыг дэмжиж, шууд харилцан ярихад голлон анхаардаг. Радио нь сард 5000 орчим дуудлага хүлээн авдаг ба зорилтот хүн амаас баримжаагаар 150000 гаруй сонсогч тэдэнтэй холбогддог.

Радиогийн санхүүжилтийн ихэнх хэсэг нь утсаар шууд харилцах нэвтрүүлэгт оролцохын тулд залгадаг сонсогчдын төлбөр, түүнчлэн байнгын сайн дурын хандиваас бүрддэг.

Утасны төлбөрийг цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчээр дамжуулан авдаг бөгөөд сар бүр радио руу шилжүүлдэг. Сонсогчдын дэмжлэгээс гадна тэд ивээн тэтгэлгээр бүтээсэн нийтийн үйлчилгээний зар сурталчилгаа, үндэсний хийгээд олон улсын хөгжлийн байгууллагуудаас хөрөнгө босгодог байна. Жишээ нь, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх кампанит ажилд зориулагдсан нэвтрүүлэг бэлтгэдэг ажээ. Радио мөн “Fonds d'appui de la presse” хэмээх Сенегал дахь хараат бус өргөн нэвтрүүлэг, сонин хэвлэлийг дэмжих сангаас тусламж авдаг.

Ндеф Ленг радио 2001 оноос хойш серере хэлтнүүдэд зориулсан өргөн нэвтрүүлгийн тэргүүлэгч үйлчилгээ хэвээр байгаа бөгөөд Фатикт хоёр дахь салбараа нээх зөвшөөрөл авчээ. Түүний тогтвортой байдал нь нэр хүндтэй серере соёлын холбоо, өөрсдийнх нь хэл, соёлын илэрхийлэл болохуйц хүйн радиотой байх ашиг сонирхлоос үүдэлтэй юм. Ндеф Ленг радио нь энэхүү дэмжлэгийг яриа зонхилсон радио нэвтрүүлгийн хэлбэрт үндэслэн, сонсогчдын оролцооноос орлого бүрдүүлэх эдийн засгийн загвар болгон хувиргаж чадсан юм.

ОНЦЛОГ ШИНЖ

- Серере соёлын холбоо байгуулж, ажиллуулж байна.
- Оролцоо бүхий, ярианд суурилсан нэвтрүүлгийн загвар.
- Сонсогчид нь хураамж, хандив, утасны төлбөрөөр дамжуулан дэмждэг.
- Сайн дурынхан удирдаж, ажиллуулдаг.

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Dragon, Alfonso Gumucio. CFSC Case Study: La Primerísima. Communication for Social Change Consortium.
<http://www.communicationforsocialchange.org/mazi-articles.php?id=241>

ХОЛБОО БАРИХ

Ндеф Ленг радио

Утас: +221 8640129

Электрон шуудан: babacardiouf@yahoo.fr



СЛОВЕНИ УЛС: Студент радио (Radio Student) – хараат бус бөгөөд конформист (аялдан дагах) бус

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Студент радио нь Любляна Их сургуулийн оюутны холбооноос эрхлэн ажиллуулдаг ашгийн бус, хотын оршин суугчдад зориулсан хүйн радио юм. Энэ нь Европын хамгийн эртний арилжааны бус радионуудын нэг ба 1969 онд байгуулагдсан цагаасаа хойш тасралтгүй ажиллаж байна. Улс төрийн нэвтрүүлэг, түүнчлэн Югославын коммунизмын сүүлийн жилүүдэд болон Словенийг тусгаар тогтноход хүргэсэн 1991 оны арав хоногийн дайны үеэр конформист бус байр суурь баримталснаараа алдаршжээ.

Студент радиог 1968 оны “оюутны сэхээрэл”-ийн дараа 1969 онд Люблянагийн Их сургуулийн Оюутны холбоо үүсгэн байгуулжээ. Энэ нь анхнаасаа л хараат бус сэтгүүл зүй, альтернатив хөгжмийн өлгий байв. Хорват, Боснийн иргэний дайны үеэр Студент радио нь хуучин Югославын хараат бус бусад өргөн нэвтрүүлэгчидтэй холбоотой байж, дүрвэгсдийн нөхцөл байдалд анхаарлаа төвлөрүүлэн, долоо хоног бүр, тогтмол серб-хорват хэл дээр нэвтрүүлэг явуулдаг байжээ. Хожим, Словенид хувийн арилжааны өргөн нэвтрүүлэг нэмэгдэхтэй зэрэгцээд, Студент радио нь альтернатив соёл, боловсролын радио станц болон өөрийгөө шинээр нээж, шоовдорлогдогсдын талыг баримтлан,

хэвлэлийн эрх чөлөө, олон талт байдлыг хөхиүлэн дэмжсээр иржээ. Студент радио нь өөрийн залуу идэвхтнүүд болох ирээдүйн сэтгүүлч, дууны инженер, дижей, хөтлөгчдийг гэгээрүүлэхэд анхаардаг. Бүтэн цагаар ажилладаг дөрвөн ажилтан, 200 гаруй байнгын идэвхтэнтэй. Тэдний дийлэнх нь оюутан боловч дотор нь сэхээтэн, сэтгүүлч, уран бүтээлч, их сургуулийн багш нар ч байдаг.

Студент радиогийн редакц нь хэвлэл мэдээллийн бусад хэрэгслийн үл тоомсорлон, эсвэл үл хайхран орхидог тийм мэдээлэл,





урлагийн хэлбэр, дуу хөгжим, соёлыг танилцуулах бодлого баримталдаг. Хөгжмийн агуулгын хувьд дэлхий нийтийн хөгжмийн чиг хандлагаас зайлсхийн, пост-хардкор, техно, хип хоп, блюз, жаз, дэлхийн хөгжим, эксперименталь болон орчин үеийн дуу хөгжим зэрэг альтернатив хөгжмийн төрөл зүйл дэх конформист бус, шинэ дуу чимээний эрэл хайгуул хийдэг байна. Радио нь улс төр, нийгмийн асуудалд ч конформист бус хандлага баримталдаг. Тэд иргэний нийгэм, төр, улс төр, соёл, дуу хөгжим, хүмүүнлэг, их сургуулийн болон оюутны байгууллагын үйл явдлуудыг сурвалжилдаг. Ингэхдээ ардчилал, хүний эрхийг хөхиүлэн дэмжиж, чөлөөт үг, хүлцэл, эв нэгдлийн зарчмын төлөө дуугарч, цөөнх болоод эмзэг бүлгүүдийг дэмжиж, улс төр, үзэл суртал, шашин, санхүү гэх мэт эрх мэдлийн давамгайлсан эх сурвалжийг дээдлэхээс үлэмж зай барин ажилладаг байна.

ОНЦЛОГ ШИНЖ

- 1969 оноос хойш оюутнууд эзэмшиж, удирдаж буй радио
- Альтернатив хөгжим, хараат бус сэтгүүл зүйд анхаарлаа төвлөрүүлдэг
- Ардчилал, хүний эрх, үг хэлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмждэг
- Шүүмжлэлт, хараат бус, конформист бус гүн ухаан

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Culture.si. Radio Študent (RŠ) (October 2010)
[http://www.culture.si/en/Radio_%C5%A0tudent_\(R%C5%A0\)](http://www.culture.si/en/Radio_%C5%A0tudent_(R%C5%A0))

ХОЛБОО БАРИХ

Студент радио
 Утас: +386 12428 800
 Электрон шуудан: info@radiostudent.si <http://www.radiostudent.si>



Студент радио бол өөрсдийнх нь намтар, тогтвортой байдал, оршин тогтнох хүсэл эрмэлзлийнх нь нэг хэсэг болсон тийм хүмүүсийн радио юм. Энэ бол Люблянагийн Их сургуулийн Оюутны холбоонд харъяалалтай ч өөрийн эрх мэдэл бүхий нэгж юм. Анхлан жараад онд оюутны хөдөлгөөнөөс үүсч, арав хоногийн дайн, хуучин Югославын зөрчилдөөнт үеийг туулан өнгөрүүлсэн уг радио өдгөө хуучин Югославын улсууд дотроос Европын Холбооны гишүүн болсон анхны энэ оронд үг хэлэх эрх чөлөөний төлөө хатуу зогсон үлгэрлэж байгаа билээ. Тус радио он удаан жил оршин тогтнож буй нь л өвөрмөц байр суурьтайг илтгэнэ. Үүний зэрэгцээ энэ жишээ шийдвэр төгс хараат бус байдлын гүн ухаан нь хүйн радио цаг хугацааны явцад өөрөө оршин тогтнох соёлын зайлшгүй хэрэгцээ бий болгодог болохыг харуулсан юм.





УГАНД УЛС: Апак радио (Radio Apac) – нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулахад тусалдаг

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Апак радио нь 18 жилийн турш үргэлжилсэн иргэний дайны улмаас ядууралд автсан Хойт Угандад байрладаг хүйн радио юм. Уг радио зөрчилдөөний үеэр туйлын уян хатан байдлаар ажиллажээ. Сонсогчдод хүрч ажиллах, хүй олонд тулгуурласан байгууллагуудтай түншлэх аль аль хэлбэрээр нутгийн иргэдээс хүчтэй дэмжлэг авсан нь тус радиогийн бат суурь болдог. Одоо тэд теле төвийн тоног төхөөрөмж, дуу бичлэг, бизнесийн үйлчилгээтэй болж, хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслээ өргөжүүлж байна.

Апак хүйн радиог 1999 онд Хойт Угандын Апак дүүргийн иргэд байгуулжээ. Тус бүс нутагт 18 жилийн турш үргэлжилсэн зөрчилдөөн, иргэний дайны улмаас орон нутгийн, тэр дундаа хөдөө аж ахуйн эдийн засаг сүйрлийн ирмэг дээр иржээ. Апак радио нь байгуулагдсан цагаасаа эхлэн энхийг төвхнүүлэх, Апак, түүнтэй хөрш зэргэлдээ дүүргүүдэд оршин суудаг нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд нэвтрүүлгийн агуулга, үйл ажиллагаагаа чиглүүлсэн байна.

Радио нь нийгмийн хүчтэй зарчмыг удирдлага болгодог. Нийгэм, эдийн засгийг сайжруулах давхар зорилгоо биелүүлэхийн тулд боловсролын хөтөлбөрт түлхүү анхаардаг байна. Ингэхдээ, жирийн иргэдийн гүнд нэвтэрч, оролцоог хангах, нутгийн иргэдийн байгууллагуудтай хамтран ажиллахад анхаарлаа чиглүүлдэг. Сонсогчдынх нь амжилт, хөтөлбөрийнх нь өндөр түвшин

төрийн бус байгууллагууд, хөгжлийн агентлаг, төрийн байгууллагуудын түншлэн ажиллах сонирхлыг нь татдаг байна. Орон нутгийн бизнесийн байгууллагууд ч мөн адил тэдний сонсогчдыг татах амжилтыг хүлээн зөвшөөрч, зар сурталчилгааны зай талбай худалдан авах сонирхолтой болжээ. Апак радио нь сонсогчдынхоо дунд арга хэмжээ зохион байгуулах, унадаг дугуйгаар явж, “хаалганаас хаалганд” аян өрнүүлэх, хөдөлгөөнт радио ажиллуулан нэвтрүүлгээ явуулж, зорилтот хүй олонд хүрч ажилладаг байна. Тэд нутгийн иргэд, бизнесийн байгууллагуудад мультимедиа хэвлэл мэдээллийн үйлчилгээ үзүүлэх замаар хүйн хэвлэл мэдээллийн төв болон өргөжиж байгаа билээ. Апак радиогийн хүйн хэвлэл мэдээллийн төв нь утсаар яриулах, факс явуулах, интернет ашиглах, аудио бичлэг, эвлүүлэг хийх, баримт бичиг боловсруулах, сурталчилгааны материал хэвлэх, олшруулах зэрэг үйлчилгээ

үзүүлдэг. Ийнхүү нэмэлт үйлчилгээ үзүүлснээр, радио нь иргэдийнхээ амьдралд ч дэм болж, орлогоо олон янзаар бүрдүүлдэг.

Цахилгаан холбооны дэд бүтэц хязгаарлагдмал бүс нутагт мэдээлэл, боловсрол, иргэдийг гэгээрүүлэх үйлст радио амин чухал үүрэг гүйцэтгэж чаддагийн жишээг Апак радио тод томруун харуулжээ. Амь зуух төдий эдийн засгийн нөхцөл, үргэлжилсэн зөрчилдөөний

дунд тэд туйлын уян хатан байж чадсан юм. Зөвхөн чанартай хөтөлбөр төдийгүй олон тооны сонсогчдод бодитой хүрч чадсаны үр ашиг бол уг радиогийн амжилт юм. Иргэдийнхээ гүнд нь нэвтэрч, тэдэнд хүрч ажилласан арга, хүй олны байгууллагуудын засаглалын бүтцэд төлөөлөлтэй болж, нягт түншлэн ажилласан, шинийг санаачлах эрмэлзэл, иргэдэд зориулсан төрөл бүрийн үйлчилгээ нь мөн тэдний амжилтын хэсэг юм.

ОНЦЛОГ ШИНЖ

- Боловсролын асуудалд хүчтэй анхаарал тавьсан хүйн радио
- Орон нутгийн нийгэм, эдийн засгийг сайжруулахад чиглэсэн
- Түншлэл, иргэдийн гүнд нь нэвтэрч, оролцоог хангадаг
- Нэмэлт үйлчилгээ эрхлэх зэрэг олон янзын санхүүжилттэй

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- The Communication Initiative Network. Radio Apac (January 2009)
<http://www.comminit.com/en/node/132280/376>

ХОЛБОО БАРИХ

Апак радио
Утас: +256 77455593
Электрон шуудан: radioapac@iwayafrica.com
Цахим хуудас: <http://www.radioapac.com>

НИЙГМИЙН ҮР НӨЛӨӨГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

НИЙГМИЙН ҮР НӨЛӨӨГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Өргөн нэвтрүүлэг, цахилгаан холбоо нь хүний хөгжилд гүнзгий үр нөлөө үзүүлдэг, тэрхүү үр нөлөөний мөн чанар нь цогц хийгээд олон давхаргатай гэсэн санаа бодолтой үл нийлэгчид байж болох юм.

Энэ нь хүйн хэвлэл мэдээлийн нийгмийн үр нөлөөг үнэлэн дүгнэх, түүний үүрэг, үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд стратеги боловсруулах аль алинд нь төвөг учруулдаг. Энэхүү судалгаанд багтсан орон нутгийн түүх, жишээ нь хүйн хэвлэл мэдээлэл ямар өөрчлөлт авчирсан тухай гэрчлэн өгүүлнэ. Хүний хоорондоо харилцах анхан шатны хэрэгцээг хангах, түүнийг өргөжүүлэх чадвар нь дотоод хэрэгцээний үнэт зүйл, мэдээлэлтэй байхыг эрчимжүүлэх хэрэгслийн хувьд үнэт зүйл болно. Энэ хоёрыг хамтатгасан загвар болохын хувьд хүйн хэвлэл мэдээлэл нь үнэт зүйл бүрэлдэх, нийгмийн нэгдэл нягтралд хувь нэмэр оруулж, хүмүүст эрхээ эдлэх, шийдвэр гаргагчдад тайлагнах хариуцлагаа хүлээхийг шаардах боломж олгодог. Хүйн хэвлэл мэдээлэл нь сэтгэл зүй, нийгэм, эдийн засаг, улс төрийн өөр хоорондоо уялдаа бүхий, олон талтай үр дүн авчирдаг юм.

Харилцаа холбоо, хөгжлийн ажлын эхэн үед сэтгэл зүйн хүчин зүйл тусгалаа олсны нэг нь өнөө хэр хэвээр байгаа маркетингийн хэл бөгөөд хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо нэг талаас нь ойлголт, зан үйлийн өөрчлөлтөд хүргэдэг илгээлт, мэдээлэл түгээгч гэж ойлгож болно. Шаардлага, тооны өсөлтөөс үүдэн хүйн хэвлэл мэдээлэл нь зөвхөн мэдээллийн хүртээмж бий болгохоос гадна иргэдийн дуу хоолойг сонгож, нийгэмд хүргэдэг харилцаан дахь нийгмийн шинжид тулгуурласан шинэ төлөвтэй болжээ. Энэ утгаар бол нийгмийн үр нөлөө нь үнэт зүйл бүрдүүлэх, мэдлэгийн хөгжилд хөтөлснөөр нийгмийн өөрчлөлтөд хувь нэмэр оруулагч харилцан ярианы үйл явцад оршино. Хүйн хэвлэл мэдээлэл өсөн нэмэгдэж, хүлээн зөвшөөрөгдөхийн хэрээр сонгуулийн ил тод байдал, төрийн албан хаагч, шийдвэр гаргагчдын тайлагнан хариуцах үүрэгт хувь нэмэр оруулж буй нийгэм, улс төрийн үр нөлөө нь мэдэгдэхүйц болж байна.

Хүйн хэвлэл мэдээллийн нийгэмд үзүүлэх үр нөлөө цогцоороо нэн ач холбогдолтой

ба үүнийг өргөн хүрээнд ойлгон хүлээн авах болжээ. Энэ нь хүйн хэвлэл мэдээллийн хөгжлийг хөхиүлэн дэмжих төрийн тусгай бодлоготой олон оронд, түүнчлэн олон улсын тунхаглал, хэвлэлийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн тухай эрдэмтдийн бүтээлд тусгалаа олсон юм.

2007 онд Дэлхийн хүйн радио өргөн нэвтрүүлгийн холбоо хүйн радиогийн нийгэмд үзүүлж буй үр нөлөөнд судалгаа хийж, үгээ хэлэх, түүнийгээ хүргэх арга хэрэгслээр дутмаг ядуу, эмзэг бүлгийнхний дуу хоолойг сонсгодоогоороо ялгарах шинжтэй нь амжилтад хүргэсэн давуу тал болохыг ажигласан байна. Судалгаа нь дүгнэлтээ хүйн радио ядуурлыг бууруулах, мөн сайн засаглал, төрийн тайлагнан хариуцах байдал, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх, гадуурхагдсан бүлгийнхнийг татан оролцуулах, зөрчилдөөнийг шийдвэрлэх, энхийг төвхнүүлэх, гамшгийг гэтлэх, түүнд бэлэн байх зэрэг хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг болохыг тэмдэглэжээ.

Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд түвшин, мөн чанараараа маш их ялгаатай болох нь тодорхой. Жишээ нь, жендерийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, эсвэл өөрийн үйлчилж буй хүй олныг удирдлагын үйл явц, нэвтрүүлэг бэлтгэхдээ оролцоог нь бүрэн хангах талаар хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүр хүссэн хэмжээнд үр дүнтэй байж чаддаггүй.

Энэ хэсэгт хүйн хэвлэл мэдээллийн нийгэмд үзүүлж буй үр нөлөө, нийгмийн өөрчлөлтөд оруулж буй хувь нэмрийг харуулсан жишээнүүдийг онцлон дурдав. Эмэгтэйчүүдийн оролцоо, эзэмшил хүйн хэвлэл мэдээллийн олон төслийн төвд байдгийн жишээ нь хөдөөгийн эмэгтэйчүүдэд зориулан хөдөлгөөнт радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж буй Фижи улсын ФемЛИНК Пасифик радио юм. Мөн Боливийн Алтиплано дахь Винай Жата радио аймара омгийн эмэгтэйчүүдийн дуу хоолойг хүргэж байна. Белиз улсын Карибын эрэг дээр Хамалали Гаринагу радио гарифуна хүйн олны өвөрмөц соёлыг хамгаалж байгаа бол Бээжин дэх хэвлэл мэдээллийн “Нэг дээр нэмэх нь нэг” (One Plus One) төсөл интернет

ашиглан Хятадын эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолойг хүргэж байна. Ямайкад Кингстоны FREE FM радио шоронд очиж, хоригдлууд, тэдний харгалзагчдыг хүйн хэвлэл мэдээллийн нэвтрүүлэгт татан оролцуулдаг ажээ. Японы Кобе хот дахь FMҮҮ радио газар хөдлөлтийн дараа байгуулагдсан бөгөөд янз бүрийн нас, чадвар, соёл бүхий бүлэг хэсгийг нэг дор цуглуулдаг. Индонезийн Ачех сэргээн босголтын радио сүлжээ (Aceh Reconstruction Radio Network)-ний хүйн хэвлэл мэдээллүүд байгалийн

гамшиг, хүмүүнлэгийн зөрчилдөөний үед хүй олны бүлэг хэсгүүдийг янз бүрийн агуулгаар сэргэн өндийхөд нь туслах үүрэгтэй. Иракийн Халабжа дахь Данге Нве радио энх тайван, яриа хэлэлцээрийг хөхиүлэн дэмждэг бол Зүүн Тиморын Ракамбия радиог Дилигийн залуучууд шинэ улсаа төвхнүүлэн байгуулахын төлөө ажиллуулдаг. Мозамбик улсад хүйн радионууд нь чөлөөт, шударга сонгуулийг хөхиүлэн дэмждэг.

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- **AMARC (2007) Community radio social impact assessment: Removing barriers, increasing effectiveness**
http://amarcwiki.amarc.org/upload/documents/AMARCEvaluation_2007.pdf



БЕЛИЗ УЛС: Хамалали Гаринагу радио (Radio Hamalali Garinagu) нь Гарифуна соёлыг хамгаалах нь

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хамалали Гаринагу радио нь Белиз дэх Карибийн тэнгисийн эрэг орчимд оршин суудаг гарифуна хүмүүст өргөн нэвтрүүлгээ зориулдаг. Тус радио нь өвөрмөц гаринагу дуу хөгжим, соёлын өв уламжлалыг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилготой. Радио нь гарифуна хэл дээр нэвтрүүлэг явуулж, гарифунагийн уламжлалт болон орчин үеийн дуу хөгжмийг нэвтрүүлдэг. Хамалали Гаринагу радио нь мөн гарифуна хөгжимчдөд зориулж дуу, дүрс бичлэгийн студи ажиллуулан, тухайн бүс нутгаас гарифуна дуу хөгжмийн өвөрмөц архив бүрдүүлдэг байна.

Белиз дэх Гарифунагийн Үндэсний Зөвлөл 1981 онд байгуулагдсан, гарифуначуудын эрх, хөгжил, соёлыг хамгаалдаг. Гарифуна нь Карибын уугуул иргэд, 1635 онд боолын худалдаагаар ирсэн африкчуудтай гэрлэсний дүнд дундаас нь Сант Винсент арал дээр бүрэлдэн бий болсон соёлын өвөрмөц түүхтэй юм. Тэд бол өөрийн онцгой хэл, соёлтой гарифуна буюу гаринагу гэгдэх шинэ бүлэг хэсэг юм. Европын колончлолын хүчийг эсэргүүцэн олон жил тэмцсэний эцэст 1797 онд тэдгээр хүмүүс Төв Америк руу цөлөгджээ. Өдгөө Никарагуа, Гондурас, Гватемал болон Белиз зэрэг улсад Карибийн тэнгисийн эрэг дагуу тархан суурьшсан хүй олон гарифуна хэлээр ярьж байна.

2002 онд Гарифунагийн Үндэсний Зөвлөл нь Хамалали Гаринагу радиог Белиз дэх

гарифуна соёлыг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор байгуулжээ. Белиз дэх арилжааны дуу хөгжим, зугаа цэнгээний энэ радио өсөн хөгжиж буйг гарифуна хүмүүсийн дуу хөгжим, өв уламжлал, орхигдож буй соёлд хувь нэмрээ оруулж буй нэг хүчин зүйл хэмээн үзэх болжээ. Мэдлэгийн орчин суралцах хамтын нөхөрлөлөөс (Commonwealth of Learning) Хамалали Гаринагу радиод анхны дэмжлэг үзүүлж, зөөврийн радиогийн дамжуулах тоног төхөөрөмж хандивлажээ.

Өдгөө, радио нь Белиз улсын Карибийн тэнгисийн эргийг бүхэлд нь хамран, 10 гарифуна хүй олонд хүрч, гарифуна хэл дээр уугуул нутгийн уламжлалт ба орчин үеийн дуу хөгжим хосолсон үйлчилгээ эрхэлж байна. Тус радио нь байгуулагдсан цагаасаа өргөжиж эхлэн мультимедиа төв, дуу, дүрс бичлэгийн

студитэй болсон юм. Тэд орон нутгийн хөгжимчдийн бүтээлийг бичиж, үйлдвэрлэхэд идэвх зүтгэл гаргадаг. Үүнээс өмнө хөгжимчид адил төрлийн үйлчилгээ авахын тулд өндөр зардлаар АНУ явах хэрэг гардаг байжээ. Мультимедиа төв байгуулахад нь ЮНЕСКО тусалсан байна. Энэ тусламж нь Карибийн нутгийн уугуул хүй олныг мэдээлэл, харилцаа холбооны технологи, тэдний сургалтад хамрагдах боломжоор хангаснаар тусгаарлагдсан байдлыг нь арилгах хөтөлбөрийн нэг хэсэг байсан бөгөөд энэ нь орлогын эх үүсвэртэй болж, үйлдвэрлэл эрхлэх бололцоонд хөтөлсөн юм. Төв нь мөн өөрийн тогтвортой байдал, аж ахуйн үйлчилгээний стратегийн нэг хэсэг болгон



сурталчилгааны материал хэвлэх, өөр бусад үйлчилгээ эрхлэх ажил хийдэг байна.

Хамалали Гаринагу хүй олны мультимедиа төв нь мөн гаринагучууд, ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудад зориулж мэдлэг олгох, чадварыг

нь дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалт, нийгмийн хөгжлийн уулзалт, семинар зохион байгуулдаг байна. Уулзалт семинарууд нь ХДХВ/ДОХ-ын талаар ойлголт, мэдлэг дээшүүлэх гэх мэтээр радиогийн хөтөлбөрийн агуулгатай уялдсан байдаг. Тэдгээр нь мөн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, нутгийн иргэдийн хоорондын харилцаа холбоог бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг байна.

ОНЦЛОГ ШИНЖ

- Хүйн радио ба мультимедиа төв
- Белизийн гарифуна хүмүүст үйлчилдэг
- Эрх, соёл, хөгжлийг хөхиүлэн дэмждэг
- Гарифуна дуу хөгжим, хөгжимчдийг дэмждэг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- National Institute of Culture and History (2010) The National Garifuna Council: Its achievements
<http://www.nichbelize.org/iscr-featured-organisation/the-national-garifuna-council-its-achievements.html>

ХОЛБОО БАРИХ

Хамалали Гаринагу радио, Белизийн Гарифунагийн Үндэсний Зөвлөл
Утас: +501 6690639
Электрон шуудан: ngcbelize@gmail.com
Цахим хуудас: <http://ngcbelize.org/>



БОЛИВ УЛС: Винай Жата радио (Radio Winay Jatha) – аймара эмэгтэйчүүдийн дуу хоолой

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Винай Жата радиогийн харилцааны сүлжээ нь Боливийн Альтиплано хотын уугуул оршин суугч аймарачуудад дунд долгион ашиглан, Эль-Альто хот, Команчегийн засаг захиргаанд хүйн радиогийн үйлчилгээ үзүүлдэг. Нэгдмэл хөгжлийн төлөө аймара эмэгтэйчүүдийн төв (CDIMA) нь эмэгтэйчүүд, нутгийн уугуул иргэдийн эрхийг хамгаалах, аймара хэл, соёлыг бэхжүүлэх зорилгоор тус сүлжээг үүсгэн байгуулжээ.

Болив дахь хүйн өргөн нэвтрүүлэг 1940-өөд оноос эхтэй билээ. Тэр үед Боливийн цагаан тугалганы уурхайн ажилчдад зориулсан хэд хэдэн уурхайчны радио байгуулагдсан нь хүйн радиогийн дэлхийн анхны жишээний нэг юм. 1980-аад оны сүүлээс хүйн радио Боливид, ялангуяа Андын бүс нутгийн оршин суугчдын дунд олноороо байгуулагдсан байна. Хүйн радио нь өөрсдийнхөө хэл, соёлыг хөхиүлэн дэмжих, хамгаалах, нийгэм улс төрийн эрхээ эдлэхэд нь нутгийн уугуул иргэдэд чухал хэрэглүүр болжээ. Винай Жата радио нь Боливийн Альтиплано дахь аймара уугуул хүй олныг бэхжүүлэхийн төлөө аймара эмэгтэйчүүдээс гарсан өргөн санаачилгын нэг хэсэг юм.

Ашгийн бус, олон нийтийн байгууллага болох CDIMA өөрсдийнх нь эрх, соёлыг нь хүлээн зөвшөөрүүлэх замаар аймара эмэгтэйчүүдийг чадавхжуулах зорилгоор 1989 онд байгуулагджээ. CDIMA нь орон нутаг, бүс

нутаг, үндэсний хэмжээнд аймара эмэгтэйчүүд, залуучуудыг төрийн шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцуулах замаар Боливид нийгэм, улс төр, эдийн засгийн бүтцийг өөрчлөхийг эрмэлздэг. Тэд хэвлэл мэдээлэл, олон нийтийн бусад байгууллагатай уялдуулан зохицуулах замаар аймарачуудын төдийгүй улс орны улс төр, нийгэм, соёлын амьдралд эмэгтэйчүүдийн оролцоог өргөжүүлэн нэмэгдүүлэх, аймара эмэгтэйчүүд, мөн нутгийн уугуул иргэдийн бусад байгууллага, аймара эмэгтэйчүүдийн хэтийн амьдрал болоод ард иргэд, нутгийн уугуул үндэстнүүдийн статусыг бэхжүүлэх, эрхийг нь дээдлэх зэрэг зорилт дэвшүүлжээ.



CDIMA нь харилцаа холбооны тогтолцооны хөгжлийг аймара хүй олонд хүргэх чухал хэрэглүүр, харин радио бол үүнийг хэрэгжүүлэх хамгийн үр дүнтэй арга хэрэглүүр хэмээн үзжээ. Анх 1992 онд CDIMA нь тухайн үеийн тэргүүлэгч радиогоор аудио сурталчилгаа нэвтрүүлж, Сан Габриел дахь католик радиогоор 15-30 минутын долоо хоног тутмын нэвтрүүлэг явуулж эхэлсэн байна. CDIMA нь 1999 онд CPFOMAT эмэгтэйчүүдийн байгууллага, Паражес муж дахь Команче хотын захиргаатай хамтран 1490 дунд долгионы (AM) Винай Жата хүйн радиогийн тоног төхөөрөмж суурилуулжээ. 2008 онд Винай Жата хэмээх 740 дунд долгионы хоёр дахь радио Эль-Альто хотод байгуулагдав.

Өдгөө Винай Жата радио нь хэвлэлийн бүтээгдэхүүн, дүрс бичлэгийн материал, боловсролын санаачлагуудыг багтаан CDIMA-ийн боловсруулсан мультимедиа харилцаа холбооны стратегийн нэг хэсэг болсон. Тус радио нь аймара соёлыг бэхжүүлэх, эмэгтэйчүүд, аймара иргэдийн эрхийг хамгаалах алсын хараатайгаар аймара эмэгтэйчүүдийн дуу хоолой болон ажиллаж байна. CDIMA-ийн бэлтгэн хүйн бусад радиогоор нэвтрүүлэхийн хамт радиогийн энэ төсөл нь эмэгтэйчүүдийн эрх, Андын бүс нутаг дахь нутгийн уугуул иргэдийн эрхийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байна.

ОНЦЛОГ ШИНЖ

- Боливийн аймара хүмүүст үйлчилдэг хүйн радиогийн сүлжээ
- Эмэгтэйчүүдийн олон нийтийн байгууллага үүсгэн байгуулж, ажиллуулдаг
- Аймара хүмүүсийн хэл, соёл, эрхийг хамгаалдаг
- Өргөн хүрээтэй харилцаа холбоо, боловсролын стратегитай холбоотой



ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Asociación de Radios Comunitarias de Bolivia (APRAC) <http://www.apracbolivia.es.tl/>
- Aguirre Alvis, J.L. (2006) La radiodifusion comunitaria en Bolivia: un signo de esperanza por un pluralismo desde la palabra http://www.amarc.org/documents/articles/Radio_comunitaria_en_Bolivia.pdf

ХОЛБОО БАРИХ

Radio Winay Jatha Centro de Desarrollo Integral de la Mujer Aymara (CDIMA)

Утас: +591 2833910

Цахим хуудас: <http://www.cdimabolivia.org>



ХЯТАД УЛС: Нэг дээр нэмэх нь нэг (One Plus One) – бидэнгүйгээр бидний тухай зүйл үгүй

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Нэг дээр нэмэх нь нэг” радио нь Бээжин хотод байрладаг хүйн радиогийн уран бүтээлийн баг ба 2006 онд интернетээр өргөн нэвтрүүлгээ эхэлсэн. Эрхтний бэрхшээлтэй иргэдэд зориулж, адил бэрхшээлтэй хүмүүс ажиллуулдаг. 2008 оны Бээжингийн Паралимпийн



үеэр олдсон боломжоо ашиглан, тус баг нь төрийн хэвлэл мэдээллийн зөвшөөрөлтэйгээр интернетийн өөрийн талбар бий болгожээ. Хэвлэл мэдээлэл нь төрийн хүчтэй хяналтанд, интернетийн хатуу чанга шалгалтан дор байдаг улс оронд, Нэг дээр нэмэх нь нэг радио нь уламжлал ёсоор ялгаварлан гадуурхагдсан нийгмийн бүлгийн бие даасан, тууштай дуу хоолой болж байна.

Бээжингийн “Нэг дээр нэмэх нь нэг” соёлын төв нь 2006 онд BBC-ийн Дэлхийн үйлчилгээний сан (World Service Trust), Нэгдсэн Вант улсад байрладаг Чайна Вижн (China Vision) байгууллагуудын дэмжлэгтэй байгуулагджээ. Энэ бол эрхтний бэрхшээлтэй хүмүүст зориулан өөрсдийн адил бэрхшээлтэй хүмүүс ажиллуулдаг хараат бус, төрийн бус байгууллага юм. Тэд иргэний нийгмийн тэргүүн туршлагын загвар бий болгох, эрхтний бэрхшээлтэй болон гадуурхагдсан бусад хүмүүсийн хүчтэй, хараат бус дуу хоолойг хүргэхийг эрмэлзэн ажилладаг. Тус баг нь Өмнөд Бээжингийн цамхагт, өргөн

нэвтрүүлгийн сайн чанар бүхий радио уран бүтээлийн хүчин чадал, үүнд зориулагдсан сургалтын төв байгуулжээ. Тэдний 13 ажилчдын талаас илүү хувь нь харааны, мөн эрхтний бусад бэрхшээлтэй бөгөөд орчныг нь тэдний дасан зохицож ажиллахад нь тус нэмэр болохуйц тусгай эдлэл хэрэгслээр тохижуулсан байна.

“Нэг дээр нэмэх нь нэг” радио төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс зөвшөөрөл олж аван, уран бүтээлийн бие даасан төв байгуулсан нь бараг бүх улс даяар өргөн нэвтрүүлгээ цацах боломж олгосон юм. Тус радиогийн “Хятадын эрхтний бэрхшээлтэй иргэдийг ажиглах нь”, “Бангянгийн зөвлөгөө” болон “Нэг дэлхий нэг дуу хоолой” зэрэг

нэвтрүүлгийг 75 гаруй бүсийн, мөн орон нутгийн радиогийн эфирээр цацдаг байна. 2008 оны Бээжингийн Паралимпийн үеэр “Нэг дээр нэмэх нь нэг” багийн гишүүд нь Паралимп сурвалжлах эрх авсан нь Хятадын анхны эрхтний бэрхшээлтэй сэтгүүлчид байв. Бээжингийн Паралимпийг сурвалжлахын тулд, тус баг нь өдөрт гурван цагийн цахим радиогийн бие даасан хөтөлбөр эхэлжээ. Тэд өдгөө, эрхтний бэрхшээлтэй хүмүүс, бусад радиогийн продюсер, сурвалжлагчдыг илүү өргөн хүрээтэй сүлжээнд хамруулахын тулд хэвлэл мэдээллийн агуулга солилцох интернетэд суурилсан талбар бий болгохоор ажиллаж байна.

“Нэг дээр нэмэх нь нэг” радио нь өргөн нэвтрүүлгийн уран бүтээлээс гадна ядуу буурай, алслагдсан, хөдөө орон нутагт оршин суудаг эрхтний бэрхшээлтэй иргэдэд хүрэхийн тулд зөвлөгөө өгөх хөдөлгөөнт клиник ажиллуулж байна. Багийн гишүүд эрх зүй, эрүүл мэндийн туршлагатай мэргэжилтэн, мэргэшсэн хувийн зөвлөхүүдийн хамт нутгийн иргэдийн байгууллагатай хамтран ажиллаж, зохих мэдээлэл, зөвлөгөө өгч, тусламж үзүүлдэг байна.

ОНЦЛОГ ШИНЖ

- Эрхтний болон бусад бэрхшээлтэй хүмүүст зориулсан тийм бэрхшээлтэй хүмүүсээс бүрдсэн уран бүтээлийн бие даасан баг ажиллуулдаг
- Эрхтний болон бусад бэрхшээлтэй хүмүүсийн эрх, дуу хоолойг хөхиүлэн дэмждэг
- Үндэсний хэмжээнд хүрч ажиллах, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажилладаг
- Интернетийг түгээлтийн бие даасан хэрэглүүр болгон ашигладаг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Buckley, S. (2009) Disability no barrier for One Plus One
<http://asiapacific.amarc.org/blog/?p=70>

ХОЛБОО БАРИХ

“Нэг дээр нэмэх нь нэг” соёлын солилцооны төв
Утас: +86 1067259507
Электрон шуудан: oporadio@gmail.com
Цахим хуудас: <http://www.oneplusone.org.cn>

“Нэг дээр нэмэх нь нэг радио” нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд оруулж буй хувь нэмэр, эрхтний бэрхшээлтэй иргэдийн эрхийн манлайлагчийн хувьд ч ач холбогдолтой. Хятад улсын хүн амын 6.3 хувь буюу 82 сая нь ямар нэг байдлаар чадваргүй байдаг. Төрөлхийн эрхтний бэрхшээлтэй, эсвэл бага насандаа эцэг эхдээ хаягдсан, орон гэргүй, амин зуулгын гачигдал зэрэг нь санаа зовоож буй асуудлуудын тоонд багтдаг. Тэд нийгэм, эдийн засгийн хувьд ялгаварлан гадуурхалтад өртдөг, тэдний талаар гол хэвлэл мэдээллийн хэрэгслээр тусгах нь ховор байдаг. “Нэг дээр нэмэх нь нэг”-ийн үүсгэн байгуулагчийн нэг Гао Шангийн хэлснээр “Хятадын жирийн нэг асран хүмүүжүүлэх газраар ороход л эрхтний бэрхшээлтэй олон хүүхэдтэй таарч болно”. Тэдэнд ажил эрхлэх боломж хомс, харааны бэрхшээлтэй хүмүүс мөлжлөгт өртөхөд хялбар, иллэг бариа хийхээс бусад ажил хийх сонголт бараг байдаггүй. “Нэг дээр нэмэх нь нэг радио” нь зөвхөн эрхтний бэрхшээлтэй иргэдэд тулгардаг сэтгэл зовнидог асуудлын талаар дуугарах бус, мөн тэднийг чадавхжуулах, нийгэмшүүлэх, тэгш боломжийг хөхиүлэн дэмжих зорилго тавьдаг.





ФИЖИ УЛС: ФемТОК (femTALK) – ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ХҮЧИРХЭГЖҮҮЛЭХ ХӨДӨЛГӨӨНТ РАДИО

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ФемТОК радио нь Номхон далай дахь анхны, цорын ганц хөдөлгөөнт радио станц юм. Хөдөлгөөнт радиог 2004 онд эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх зорилго бүхий Фижид байрладаг ФемЛИНК Пасифик төрийн бус байгууллага байгуулжээ, Радио нь хагас хотожсон болон хөдөөгийн энхийг төвхнүүлэх, боловсрол олгох, жендерийн тэгш байдлын төлөө эмэгтэйчүүдийг харилцаанд татан оролцуулах боломж олгодог. Уг төсөл нь сургалт зохион байгуулах, уран бүтээлийн дэмжлэг үзүүлэх, богино долгионы өргөн нэвтрүүлэг дамжуулах хүчин чадал бий болгоход дэмжлэг үзүүлдэг байна.



ФемЛИНК Пасифик нь Фижигийн нийслэл Сува хотноо байрлах эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага бөгөөд эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх, хөгжлийн төлөө үйл ажиллагаа явуулах хүйн хэвлэл мэдээлэл эрхэлдэг. Тус байгууллага нь эмэгтэйчүүдийн эрх, тэдний дуу хоолойг хүргэх боломжийг хөдөөний эмэгтэйчүүдийн харилцааны ур чадвар, чадавхыг дээшлүүлэх практик санаачилгуудтай хослуулдаг байна. ФемЛИНК Пасифик 2004 оны тавдугаар сард тус улсдаа анхны, мөн цорын ганц хөдөлгөөнт хүйн радио болох ФемТОК FM 89.2 радиог байгуулжээ. Сува хотоос гадагш 10 км дотор нэвтрүүлгээ цацах хүчин чадалтай, хөдөлгөөнт

студи, дамжуулалтын тоног төхөөрөмж бүхий ФемТОК радио нь хагас хотожсон болон Насури, Нади, Ба, Лабаса орчмын хөдөөний хүй олонд хүрч байна. ФемТОК радио нь таван жилийн турш сургалт зохион байгуулж, өргөн нэвтрүүлэг бэлтгэн, энх тайван, жендерийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжихийн төлөөх өвөрмөц индэр болжээ.

Фижид хэвлэл мэдээллийн зохицуулалт үгүй, олон нийтийн өргөн нэвтрүүлэгч нь арилжааны болж буй зэргээс үүдэн орон нутгийн хүн ам, иргэний нийгмийн бүлгүүд хэвлэл мэдээлэлд нэвтрэх боломж буурчээ. ФемЛИНК пасифик нь эмэгтэйчүүдийн дуу

хоолойг нэмэгдүүлэхийн тулд ажиллахын зэрэгцээ эрх зүй, зохицуулалтын хувьд хүйн өргөн нэвтрүүлгийг хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө тууштай дуугарч байгаа билээ. Үүнтэй уялдан хөдөлгөөнт радио байгуулах санаа нь төслийн нэг хэсэг болж, “Эмэгтэйчүүдийн амралтын өдрүүдийн радио” эхлэх үндэс тавигдсан юм. ФемТОК 89.2 богино долгионы радио нь шийдвэр гаргах бүтцийнхний анхаарлыг татах, мөн бусад эмэгтэйчүүд, тэдний байгууллагуудтай яриа хэлцэл өрнүүлэх боломжийг олгохын тулд түргэн хугацаанд хөгжиж эхэлсэн юм. 50 гаруй залуу эмэгтэйчүүд өргөн нэвтрүүлгийн чадвар эзэмших сургалтад хамрагдаж, “Амралтын өдрүүдийн радио”-гийн уран бүтээлд гар бие оролцож байна.

Төслийн үр дүнд эмэгтэйчүүд эрхийнхээ талаар илүү мэдээлэлтэй болсон байна. Мөн Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Насури Холбоо зэрэг шинэ сүлжээнүүд байгуулагджээ. Тэдгээрт хамрагдсан эмэгтэйчүүд өөрсдийнх нь амьдралд нөлөө үзүүлэхүйц асуудал, Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325-р тогтоолын талаарх ойлгол-

тыг дээшлүүлэх, Эмэгтэйчүүдийн харилцан суралцах солилцооны тойрог буюу Худалдаа ба тусламжийн жагсаал зэрэг кампанит ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Тэдний “Ирээдүй үе” төслийн хүрээнд залуу эмэгтэйчүүд гудамжаар яван, ярилцлага авах, зах, худалдааны төвөөс сурвалжлага хийх, иргэдийн хүсэлтээр нэвтрүүлгийн агуулга тодорхойлох, тэднийг нэвтрүүлэгт оролцуулах зэргээр радио сурвалжлага бэлтгэх, уран бүтээл туурвих, нэвтрүүлэх ур чадвараа дээшлүүлэхэд хамрагддаг.

ФемТОК радио станц янз бүрийн соёлыг хөхиүлэн дэмжих, олон талт байдлыг дээдлэхийн тулд эрхтний бэрхшээлтэй, угсаатны цөөнх зэрэг гадуурхагдсан бүлгийн эмэгтэйчүүдийн оролцоонд анхаарал хандуулахыг эрмэлздэг байна. Улс төрийн тогтворгүй уур амьсгал, хандивлагч байгууллагуудын тэргүүлэх чиглэл ФемЛИНК Пасифик байгууллага, мөн ФемТОК радиогийн төсөлд сорилт болсон хэдий ч “Амралтын өдрүүдийн радио”-гийн өргөн нэвтрүүлгийн хугацаа хагас, бүтэн сайн өдрүүдэд 16 цаг орчим нэмэгджээ.

ОНЦЛОГ ШИНЖ

- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнт радиогийн уран бүтээл, өргөн нэвтрүүлгийн төсөл
- Амралтын өдрүүдэд өөр өөр газраас нэвтрүүлэг бэлтгэж дамжуулдаг
- Хөдөөний эмэгтэйчүүдийн дуу хоолойг хүчирхэгжүүлэхэд анхаарал хандуулдаг
- Хүний эрх, нутгийн иргэдийн харилцан яриа, энх тайвныг хөхиүлэн дэмждэг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- femLINK pacific (2008) Empowering communities, informing policy: the potential of community radio
http://www.femlinkpacific.org.fj/_resources/main/pdf/Empowering-Communities-InformingPolicyThePotentialofCommunityRadio.pdf
- femTALK: Women's community radio initiative
<http://www.comminit.com/en/node/131265/2754>

ХОЛБОО БАРИХ

ФемЛИНК пасифик

Электрон шуудан: femlinkpac@connect.com.fj

Цахим хуудас: <http://www.femlinkpacific.org.fj>





ИНДОНЕЗИ УЛС: ARRNet – туйлдсан ард иргэдийг нөхөн сэргээх нь

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Ачех Ниас” сэргээн босголтын радио сүлжээ (цаашид ARRNet) нь 2004 онд болсон Энэтхэгийн далайн цунамигийн дараахь сэргээн босголт, нөхөн сэргээлтийн төлөө үйл ажиллагаа явуулдаг Ачех болон Хойт Суматр дахь 46 хүйн радиогоос бүрддэг. Цунамигийн дараахь хэдэн долоо хоногт яаралтайгаар үр ашиг бүхий радио сүлжээ байгуулах шаардлагын дагуу ARRNet нь эрэг орчмын болон хөдөөгийн ард иргэдийг холбохын тулд радиог интернет, цахилгаан холбоотой хослуулжээ.

2004 оны арванхоёрдугаар сарын 26-ны өдөр болсон цунамид нэрвэгдсэн Ачех мужид туслагчдын дунд Индонезийн хүйн радиогийн салбарын идэвхтнүүд, Комбайн (Combine) хэмээх хүйн хэвлэл мэдээллийг дэмжих байгууллага байв. Цунамигийн чичирхийллээс бүр өмнө Ачех дахь хэвлэл мэдээлэлд хараат бус, олон талт байдал дутагдаж байлаа. Бүс нутагт онцгой байдал зарласан, засгийн газрын зэвсэгт хүчин салан тусгаарлагч Ачехийн Чөлөөт хөдөлгөөний эсрэг байв. Цунами нь олон тооны өргөн нэвтрүүлгийн хүчин чадлыг үгүй хийж, сүйрэлд өртсөн хүн ам мэдээ, мэдээлэлгүй хоцорчээ. Нийслэл Банда Ачехын гадна, эрэг орчмын болон хөдөөний ард иргэд хэвлэл мэдээллийн гачигдалд орсон байв.

Нэрвэгдсэн ард иргэдийн харилцааны хэрэгцээг хангах хариу арга хэмжээ болгох Ачехийн Яаралтай тусламжийн радио

сүлжээ нь өргөн нэвтрүүлгийн зөвшөөрөл авахын тулд засгийн газартай хамтран таван хүйн радио байгуулжээ. Хүйн радио нь Индонезийн харилцаа холбооны идэвхтэн, инженерүүдийн гүйцэтгэсэн өргөн хүрээтэй хариу арга хэмжээний нэг хэсэг нь бөгөөд үүнд мөн утасгүй интернетийн сүлжээ багтаж байв. ARRNet нь Ачехт хүйн радио бий болгон өргөжүүлж, сэргээн босголт, нөхөн сэргээлтийн үйлсэд анхаарал төвлөрүүлэхийн тулд яаралтай тусламжийн хариу арга хэмжээний төсөл хэрэгжүүлэх болсон байна. Санхүүжилтийг Японы Олон нийтийн хөгжлийн сангаас Дэлхийн банк захиран зарцуулах механизмаар дамжуулан олгожээ. 2005 оны 11 дүгээр сараас 2009 оны эхэн хүртэл уг төслийг хэрэгжүүлэхээр Нөөцийн Комбайн Хүрээлэн (Combine Resource Institution)-тэй гэрээ байгуулсан байна.

ARRNet нь Банда Ачехт хөдөөгийн хүйн

радиог утас, факсын шугам, төвдөө боловсруулсан мэдээ, агуулга солилцох, цахим хуудастай хослуулсан хэвлэл мэдээллийн холимог загварыг ашиглажээ. ARNet нь хүй олныг бие биетэйгээ шууд харилцах боломж олгодгоороо шуурхай, мэдэгдэхүйц үр нөлөөтэй юм. Харилцаа холбоо өмнө нь тусламжийн шинжтэй, засгийн газарт дөрлөгдсөн нөхцөлд ARNet нь хүй олны хэрэгцээ шаардлага, асуудал бэрхшээлийг хурцаар тавьж байв. ARNet радиогийн бий болгосон хоёр талт, хүй олны түвшний харилцан яриа нь бусад талаар ч ашигтай болжээ. Тэд санал гомдол, зовлон гашуудлыг ч анхаарлынхаа төвд байлгаснаар радио нь мониторингийн систем, мөн тайлагнан хариуцах механизмын үүрэг гүйцэтгэж байна. Тэд ард иргэдэд орон байр, амьжиргаагаа сэргээн босгох, эрүүл мэнд, боловсролоо нөхөн сэргээх талаар хоорондоо туршлага солилцох боломж бүрдүүлжээ. Радиогийн сайн дурын олон ажилчин өөрсдөө гэр орон, гэр бүл, найз нөхдөө алдсан байв. Хүйн радио нь гэмтэл бэртлийн тоо хэмжээ, нөхөн сэргээлтийн байруудын хэрэгцээ шаардлагын талаар нягт нямбай мэдээлэхэд онцгой анхаарсан юм.

ARNet нь цаг хугацаагаар хязгаарлагдсан төсөл байсан ч үйл ажиллагаагаа үргэлжлүүлж



байна. Өдгөө радиод Ачех дэх өөрсдийнх нь бүсийн холбоо, Нагру Ачех Дауссалам дахь Хүйн радиогийн сүлжээ (JRK- NAD) дэмжлэг үзүүлж байна. Цунами, түүний үр дагавар олон нийтийн санаа сэтгэлээс балран холдохын цагт хүйн радионуудын тэргүүлэх чиглэл өөр болсон байна. Төслийн төгсгөлд ARNet гишүүдээ ажлаа үргэлжлүүлэхэд нь зориулан "үндсэн хөрөнгө"-өөр хангасан байна. Зарим нь үүнийг ард иргэдийн оролцоог гүнзгийрүүлэн, орлого олох үйл ажиллагаатайгаа уялдуулсан бол нөгөө хэсэг нь тогтвортой амьжиргаа бий болгох стратегийн нэг хэсэг болгон хөдөө аж ахуй, малын үржил зэрэг эдийн засгийн үйл ажиллагаанд шууд хөрөнгө оруулалт хийжээ.

ОНЦЛОГ ШИНЖ

- Интернет, цахилгаан холбоон дээр суурилсан гамшгийн дараах радио сүлжээ
- Гамшигт нэрвэгдсэн хүй олны харилцаа холбооны хэрэгцээнд хариу арга хэмжээ болсон
- Харилцан яриа, хүй олны эзэмшил, сэргээн босголтын мониторингийг хөхиүлэн идэвхжүүлсэн
- Олон улсын тусламж, улсын хэмжээний шинжээч, идэвхтнүүдийн дэмжлэг авсан

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Birowo, Mario Antonius. The Use of Community Radio in Managing Natural Disaster in Indonesia at Prato CIRN Community Informatics Conference 2009. (Refereed Paper) <http://www.ccnr.net/pratoconf2009/pdfs/Birowo-.pdf>

ХОЛБОО БАРИХ

Combine Resource Institution

Электрон шуудан: office@combine.or.id

Цахим хуудас: <http://combine.or.id/>



ИРАК УЛС: Данге Нве радио (Radio Dange Nwe) – энх тайван, яриа хэлэлцээний дуу хоолой

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Халабжа дахь Данге Нве радио нь Хойт Ирактаа хамгийн анхны хараат бус хүйн радио юм. Нэн тэргүүнд эмэгтэйчүүд, залуучуудад анхаарлаа хандуулдаг тус радио нь энх тайван, яриа хэлэлцээний дуу хоолой болж иржээ. Тэрээр Халабжагийн ард иргэдийг удаан хугацааны турш үргэлжилсэн мөргөлдөөн, дайн байлдааны нөлөөллийг гэтлэн давахад тусалдаг. Тус радиогийн бүх ажилчид 1988 онд тосгоныг дайрахад ашигласан гэдгээр дуулиан тарьсан, итгэмээргүй тэр химийн хорт хийн дараа амьд үлдэгсэд юм.

Данге Нве (Шинэ дуу хоолой) радио нь Хойт Иракт хэвлэл мэдээллийн орчинг нээлттэй болгох алхмуудын дагуу 2005 оны зургадугаар сард байгуулагджээ. Өргөн нэвтрүүлгийн ихэнх шинэ үйлчилгээ нь улс төр, арилжааны ашиг сонирхолд хөтлөгдсөн нөхцөлд Данге Нве радио нь АНУ-ын төрийн бус хөгжлийн агентлаг болох “Олон улсын хөдөө аж ахуйн хамтын ажиллагаа, хөгжлийн агентлаг”, “Хилийн чанад дахь хамтын ажиллагааны туслалцааны сайн дурынхан” (ACDI/VOCA) байгууллага, Германы эмэгтэйчүүдийн хөгжлийн төрийн бус байгууллага (WADI e.V.), эмэгтэйчүүд, залуучуудын дуу хоолойг хүргэх зорилго бүхий Барселона хот дахь Гладис Палмера радиогийн тусламжтайгаар байгуулагдсан байна. Энэ бол бүс нутагтаа

хамгийн анхны хараат бус, хүйн радио бөгөөд курд, араб, перс болон бусад хэл дээр өдөрт 6 цагийн нэвтрүүлэг явуулдаг.

Ираны хилээс холгүй орших Халабжа хот нь 1988 онд Иракийн засгийн газрын зэвсэгт хүчин хүн амынх нь эсрэг химийн зэвсэг ашиглан дайрсан тэрхүү үл итгэм явдал болсон газар юм. Үүний улмаас олон хүн амь насаа алдаж, насан туршийн гэмтэл согогтой үлдсэн билээ. Тус бүс нутаг 1990-1991 онд Персийн булангийн дайнд мөн нэрвэгдсэн юм. Айдас, хуучин шарх нь сэдэрээс болгоомжлон хүлцэнгүй дуугүй байх дадал хэвшил нь дайн, мөргөлдөөн, хавчлагын ул мөрийг арилгахад саад тотгор болж байв.



Залуучууд, эмэгтэйчүүд, эрчүүд хамтран нутгийнхаа асуудал бэрхшээлийг сурвалжлан мэдээлэх орон зай бий болгосноор тус радио нь нийгэм хоорондын харилцааны суурь дүрмийг өөрчилсөн юм. Радиогийн 12 ажилтан бүгд хорт хийн дайралтын хохирогч болж, удаан хугацаагаар дүрвэгсэдийн хуаранд амьдарч байжээ. Тэдний ихэнх нь гүйцэд боловсрол эзэмшиж чадаагүй байна.

Бичиг үсгийн чадвар, албан ёсны боловсролын түвшин нь бага хүн амын дунд радио нь онцгой ач холбогдол бүхий үүрэг гүйцэтгэж, мэдээллийн хүртээмж бүхий эх сурвалж, яриа хэлэлцээний болон ард иргэдийг хүчирхэгжүүлэх хэрэглүүр болж байна. Тухайн нутагт эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь бичиг үсэгт тайлагдаагүй юм. Нийгэм, улс төрийн зөрчилдөөн нь бага, дунд боловсрол эзэмшихэд саад учруулсан. Хүмүүст, ялангуяа залуучуудад хоорондоо уулзаж ярилцах нийтийн эзэмшлийн газар дутмаг аж. Данге Нве радио эдгээр асуудлыг боловсрол, эрүүл мэндийн нэвтрүүлгээрээ хөндөж, хүчирхийлэл, дайн байлдааны уршгаас үүдсэн хор дагаврыг илрүүлдэг. Хүчирхийллийн урт хугацааны үр дагавар нь “Түүхийн семинар” хэлэлцүүлгийн нэвтрүүлгийн сэдэв болсон бөгөөд үүнд залуучууд, тэдний эцэг эх, өвөө эмээ нар оролцож, өнгөрсөн түүхийн тухай сургамж, сэтгэлийнхээ шархыг хуваалцдаг байна. Түүнчлэн тус радио нь төрийн албан хаагчдыг шууд нэвтрүүлэгт урьж оролцуулан, иргэдийн

ОНЦЛОГ ШИНЖ

- Хойт Ирак дахь анхны хараат бус хүйн радио
- Эмэгтэйчүүд, залуучуудын дуу хоолой болдог
- Оролцоо, орон нутгийн хариуцлагад хувь нэмэр оруулдаг
- Энх тайван, зөрчилдөөний дараах яриа хэлэлцээ, сэргээн босголтыг хөхиүлэн дэмждэг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- WADI (2007) Radio “New Voice”: First community radio in Iraq
http://www.wadi-online.de/index.php?option=com_content&view=article&id=24&Itemid=25

ХОЛБОО БАРИХ

Данге Нве радио
Утас: +964 7701962158

эрх, эрүүл ахуй, ус, цахилгаан хангамжийн дутагдал зэрэг амьжиргааны асуудалд анхаарал хандуулснаар тэдний хариуцлагыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Данге Нве радио нь зохион байгуулалтын ардчилсан бүтэцтэй. Тус радиод ажилладаг эмэгтэйчүүд, залуучууд нь радиогоо эзэмшиж, удирддаг. Ажилчид гурван сар бүр өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавих Захиргааны зөвлөлийг сонгодог ажээ. Радио нь сайн дурынхны оролцоог хөхиүлэн дэмжиж, сардаа 10-30 сайн дурынхан тогтвортой ажилладаг. Мөн байгаль орчны залуу идэвхтнүүд зэрэг сэдэвчилсэн бүлэг, клубууд зохион байгуулахыг дэмждэг ажээ.





ЯМАЙК: FREE FM – шоронгийн ханан дотроос

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

FREE FM нь Ямаик дахь насанд хүрэгчдийн засан хүмүүжүүлэх төв, Цамхагт гудамжнаа үйл ажиллагаа явуулдаг хүн мультимедиа төв юм. Тус төвийн харгалзагч, хүмүүжигчид нь хүмүүжлийн нэвтрүүлгийн агуулга боловсруулах, болсон явдлын талаар өөрсдийн бодлыг хуваалцахын тулд хамтран ажилладаг. Уг төсөл нь хоригдлуудыг засан хүмүүжүүлэх “Суралцагсад үнэнийг илэрхийлж байна” бүлгээс, Засан хүмүүжүүлэх үйлчилгээний газартай хамтран ЮНЕСКО болон Канадын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй хамтын нэгж юм.

FREE FM радио нь шорон дахь радио, компьютерийн лаборатори юм. FREE гэдэг үг нь ‘Fostering Rehabilitation Education and Entertainment’ гэсэн үгийн товчлол бөгөөд засан хүмүүжүүлэх боловсрол, зугаа цэнгэлийг дэмжих нь гэсэн утгатай ажээ. 1998 онд байгуулагдсан “Суралцагсад үнэнийг илэрхийлж байна” хэмээх шорон дахь бүлгийн уулзалтын үеэр гарсан санаа ийнхүү зорилт болсон байна. Тус бүлэг нь Америкийн өргөн нэвтрүүлэгч, өмнө нь хүмүүжигч байсан Рэй Хиллын хөтөлдөг, Хьюстон дахь KPFT 90.1 радиогийн “Шоронгийн шоу” хэмээх Баасан гариг бүрийн шөнийн нэвтрүүлгийн бичлэгийг сонсох зуур хайрын захидал илгээх, хорионд байгаа хайртай хүмүүсээ сэтгэл санаагаар дэмжих зэргээр радиогч хүмүүжигчдийн гэр бүл, найз нөхдийн дуу хоолой болгон ашиглаж буйд сэтгэл хөдөлсөн байна. Ийнхүү “Нийгмийн хоорондын харилцаа”

хөтөлбөрийн тухай, мөн эцэстээ радио байгуулах санаа төрүүлсэн.



FREE FM нь 2007 оноос нэвтрүүлгээ эфирт цацаж эхэлсэн ажээ. Туршилтийн төсөл нь Ямайкийн Кингстонд байрладаг насанд хүрэгчдийн чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх төв “Цамхагт гудамж”-наас өргөн нэвтрүүлгээ цацдаг. Энэ нь Засан хүмүүжүүлэх үйлчилгээний газартай хамтарсан төсөл бөгөөд ЮНЕСКО, Канадын Олон улсын хөгжлийн агентлаг дэмжлэг үзүүлдэг. Төслийн эхнээс, харгалзагч, хоригдлууд хэд хэдэн шинэлэг хандлага бий болгосон байна. “Нийгмийн хоорондын харилцаа” хэмээх олны танил болсон нэвтрүүлэгт зориулан албан хаагчид хоригд-

луудын гэр бүл, найз нөхдийн бичлэгийг хийж, тэд хорионд буй өөрсдийн хайртай хүмүүст дэмжлэг үзүүлсэн, мэндчилгээ дэвшүүлсэн үгийг дамжуулдаг ажээ. Ийм маягийн оролцооны нэвтрүүлгүүд нь ихэнхдээ хоригдлуудыг хайртай хүмүүстэй нь холбож буй цорын ганц харилцаа тул туйлын алдартай болжээ.

Шоронд хоригдогчдод хэрэгцээтэй хөтөлбөр бэлтгэхийн тулд хүмүүжигчдийн бүлэгт зориулан үйлдлийн судалгааны аргад суралцах сургалт хийжээ. Судалгаагаар, хоригдлууд өөрсдийн эрх, хугацаанаасаа өмнө суллагдах журмын тухай илүү ихийг мэдэхийг хүсдэг нь тогтоогдсон байна. Энэ мэдээлэл долоо хоног тутмын “Хүмүүжигчийн булан” нээхэд хөтөлж, шоронгийн ажилтнууд ийм чиглэлийн мэдээллийг хуваалцаж, асуултанд хариулдаг болжээ. Ажилтнууд дараа нь хоригдлуудын амьдралын нийтлэг хэв маяг, эрүүл мэндийн талаарх санал гомдлын тухай, мөн урьдчилан сэргийлэх талаарх ашигтай мэдээлэл зэргийг багтаан хөтөлбөрөө өргөжүүлсэн байна. Судалгаа нь хоригдлуудын дэмжлэгийг хүлээхэд тусалж, тэд, магадгүй анх удаа, албан тушаалтан болон өөрсдийн хоорондох шууд харилцааны гольдролыг мэдэрч, радиог амьдралынхаа чухал чиг шугам хэмээн үзэж эхэлжээ.

FREE FM нь уламжлал ёсоор бие биетэйгээ дайсагнадаг хоригдол, харгалзагч нарыг хамтран уран бүтээл хийхэд нэгтгэсэн нь засан хүмүүжүүлэх ажилд тус нэмэр болох юм. Нэвтрүүлгийн агуулга боловсруулахад

ОНЦЛОГ ШИНЖ

- Боловсрол, засан хүмүүжүүлэхэд чиглэгдсэн шоронгийн радио төсөл
- Хоригдлуудын бүлэг, засгийн газар, тусламжийн байгууллагуудын хамтын нэгж
- Хэвлэл мэдээллийн уран бүтээл туурвихад хоригдлууд, харгалзагчдыг хамруулдаг
- Шорон доторх гэмт хэрэг мэдэгдэхүйц буурсан үр дүнтэй

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- UNESCO (2008) Prison community radio: FREE FM streams live online
http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=26640&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html

ХОЛБОО БАРИХ

Ямайкийн FREE FM шоронгийн радио
Утас:+876 9220021

аль хэр их хамтран ажиллана, хоёр бүлэг тэр хэрээр хоорондоо харилцана. Чухамхүү тэрхүү мөчүүдэд төслийн хамгийн үнэт зүйл илүү тодорхой болж, хувирч өөрчлөгдсөн холбоо хэлхээгээр дамжин, хоёр бүлэг нэгэн зорилготой болжээ. Хоёр бүлэг хоёул бичлэг хийх, цахим эвлүүлэг хийх, судалгаа авах, нэвтрүүлэг хөтлөх, өргөн нэвтрүүлгийн ёс зүй зэрэг радиогийн бүтээл туурвих суурь чадвар олгох түргэвчилсэн сургалтад хамрагджээ. Төсөл эхэлсэнээс хойш Цамхагт гудамж дахь шорон дотор үйлдэгддэг гэмт хэрэг 50 хувиар буурсаныг шоронгийн ажилтнууд ажигласан байна. Тэд үүнийг хоригдлууд нэвтрүүлэг бэлтгэх явцдаа хөгжим бичих, эвлүүлэх, график дизайн, видео бичлэг, эвлүүлэг хийх зэрэг хэрэглээний программуудыг ашиглахад сургаж буй хүйн мультимедиа төвтэй холбоотой гэж үзэж байна. Бичиг үсэгт тайлагдаагүй нь хоригдлуудын өмнө тулгарч буй томоохон сорилуудын нэг байсан бөгөөд үүнээс үүдэн хөтөлбөрийг бичиг үсгийн боловсрол олгоход чиглүүлжээ.





ЯПОН УЛС: FMҮҮ радио хүн төрөлхтний янз бүрийн байдлыг онцлон тэмдэглэдэг

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

FMҮҮ радио нь Кобе хот дахь японы хоёр хүйн радио 1995 онд Ханшин Аважид болсон цуутай газар хөдлөлтийн дараа нэгдсэний үр дүнд байгуулагджээ. Тус радио нь хүй олныг нэгтгэх, мөн бүх насны, янз бүрийн чадвар, соёл бүхий хүмүүсийн дуу хоолойг хүргэснээр өрөөсгөл хандлагыг арилгахыг эрмэлздэг. Радиог Такаторигийн Хүй олны төв удирдан ард иргэдийн амьдралыг сайжруулах хүсэл зоригоороо нэгдсэн янз бүрийн бүлгүүдийг хамруулдаг.

1995 он хүртэл Японд хүйн радио нь хамрах хүрээний хувьд туйлын бага хүчин чадалтай бөгөөд хязгаарлагдмал байсан нь түүний хүй олныг хөгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг явцуурахад хүргэж байлаа. 1995 оны нэгдүгээр сарын 17-нд Ханшин Аважид болсон цуутай газар хөдлөлт 6400 гаруй хүний амийг авч одсон бөгөөд амь үрэгдэгсдийн дийлэнх нь газар хөдлөлтийн голомтод хамгийн ойр оршиж байсан Кобе хотын оршин суугчид байв. Нэрвэгдэгсдийн дийлэнх нь Солонгос, Филиппиний цагаач ажилчид, мөн Вьетнамын голдуу дүрвэгсэд байлаа. Санхүүгийн доройтолд орсон хэсэг бүлгийн хувьд, тэдэнд газар хөдлөлт онцгой эмзэг туссан юм. Тэдэнд өөрсдийнх нь хэл дээр нягт нямбай мэдээлэл, зөвлөгөө өгөх шаардлагатай нь тодорхой байв.

Газар хөдлөлтийн дараахь хоёр долоо хоногийн дотор Осакагийн солонгос иргэдэд зориулсан, бага хүчин чадал бүхий Saran



FM өргөн нэвтрүүлгийн тоног төхөөрөмжөө авчран, газар хөдлөлтийн голомтоос холгүй байрлуулж, Yoboseyo FM (солонгос хэл дээр "Сайн байна уу" гэсэн утгатай) нэртэйгээр солонгос, япон хэл дээр нэвтрүүлгээ цацаж эхэлжээ. Хэдэн долоо хоногийн дараа Saran

FM, Yoboseyo FM радиогийн тусламжтайгаар, вьетнам иргэдэд үйлчлэхийн тулд бага хүчин чадал бүхий хоёр дахь радио станц байгуулагдсан байна. Тэдний ихэнх нь орон гэрээ төдийгүй, газар хөдлөлт орон нутгийн гутлын үйлдвэрүүдийг сүйрүүлсэн тул, ажлаа ч алджээ. Yumen FM (вьетнам хэлээр найрамдал гэсэн утгатай) радио зөвхөн вьетнамаар бус, мөн филиппинчүүдэд зориулж тагаль, англи хэл дээр өргөн нэвтрүүлэг явуулдаг юм. Тэд газар хөдлөлтийн тухай мэдээлэл, төрөлх нутгийнх нь дуу хөгжим, зугаа цэнгээний нэвтрүүлэг дамжуулдаг байв.

Хоёр бичил радиогийн бодлого адил байсан тул газар хөдлөлтөөс хойш 6 сарын дараа хүчээ нэгтгэх шийдвэр гаргаж, олон янзын хүй олныг хооронд нь холбож, цөөнхийн дуу хоолойг хүргэх орон зай бий болгохын тулд FMYY радиог байгуулсан ажээ. Тус хоёр радио нь газар хөдлөлтийн хор уршгаас үүдсэн шаардлагаар бий болсон бөгөөд харин урт хугацаанд үйл ажиллагаа явуулахын тулд өргөн нэвтрүүлгийн зөвшөөрөл авч, байнгын студи байгуулах шаардлагатай байлаа. Газар хөдлөлтөөс хойш нэг жилийн дараа FMYY

ОНЦЛОГ ШИНЖ

- Олон соёл, олон хэлний хүйн радио
- Гамшгийн эсрэг хүмүүнлэгийн хариу арга хэмжээ болон хөгжсөн
- Цагаач, дүрвэгсэд, гадуурхагдсан бүлгүүдэд үйлчилдэг
- Олон талт зорилго бүхий хүй олны төв хариуцан ажиллуулдаг

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- Takatori Community Centre (Center)
<http://www.tcc117.org/en/>

ХОЛБОО БАРИХ

FMYY радио
Утас: +81 78 737-3196
Цахим хуудас: <http://www.tcc117.org/fmyy/en>

радио нь Такатори тэтгэмжийн баазад орших Такатори сүмийг түшиглэн албан ёсоор нээлтээ хийлээ. Энэ үед хятад хэл, хожим нь Өмнөд Америкийн цагаачдад зориулан португал хэл дээрх нэвтрүүлэг нэмэгджээ.

FMYY радио өдгөө япон, хятад, солонгос, вьетнам, тагаль, тай, индонези, испани, португал, айну, англи зэрэг 11 хэл дээр нэвтрүүлэг явуулдаг. Тус радиод сайн дурын 150 орчим, үндсэн гурван ажилтан ажилладаг. Ашгийн бус байгууллага болох Такаторигийн хүйн төв радиог өмчлөх эрхтэй. Тус төв нь Тэтгэмжийн баазаас салаалсан, олон талт үйл ажиллагаагаараа радиогийн нийгэмд үзүүлэх үр нөлөөг бэхжүүлж байна. Тус төв нь бүх нийтэд зориулсан сайн сайхан хамтын нийгэмлэг байгуулах нэгэн зорилгоор нэгдсэн 7 бүлэг хэсгээс бүрддэг. Бүлэг хэсэг бүр өөрийн анхаарал хандуулах чиглэлтэй. Үүнд, ахмад настан, эрхтний бэрхшээлтэй хүмүүс, цагаач ажилчид, дүрвэгсэд багтана. Радиогийн хөтөлбөрийнхөө бодлогоор ашгийн бус, хүй олонд тулгуурласан бусад байгууллагын оролцоог хөхиүлэн дэмждэг, тэдний зарим нь FMYY радиогийн Удирдах зөвлөлд төлөөлөлтэй.



TELECENTRO E RA COMUNITÁRIA

МОЗАМБИК УЛС: хүйн радио ба сонгуулийн сурвалжлага

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Мозамбик дахь хүйн радиогийн салбар нь 2003, 2004 оны сонгуулийн үеэр түүнийг мэдээлж, сурвалжлахдаа баримтлах Ёс зүйн код боловсруулан, улс төрийн сэргэлдөөний эсрэг хариу арга хэмжээ авсан юм. Ёс зүйн зарчим нь эзэмшлийг хүлээн зөвшөөрөх, зөвшилцөлд хүрэхийн тулд хүйн радиогийн салбарын дотроо өрнүүлсэн өргөн хэлэлцүүлгийн үр дүн байв. Үүгээр үр дүн бүхий өөрийн зохицуулалтын үлгэр жишээ бий болгож, сонгуулийн үеэр улс төрийн гол намуудын талаар шударга, тэнцвэртэй мэдээлж, сурвалжлахад хувь нэмэр оруулсан байна.

2003 оны орон нутгийн сонгуулийн өмнөх жилүүдэд Хэвлэл мэдээллийн хөгжлийн хөтөлбөр хэмээх өргөн санаачилгын хүрээнд Мозамбикт хүйн радиогийн салбар хурдацтай хөгжиж байв. Энэ нь ЮНЕСКО, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн (UNDP) санаачилсан хөгжлийн дэмжлэг, хөрөнгө оруулалтын идэвхтэй хөтөлбөрийн үр дүнгийн нэг хэсэг болсон юм. Сонгуулийн үед хүйн радиогийн хүлээх үүрэг, хариуцлагын талаар эрх зүй, зохицуулалтын зүйл заалт байхгүй байсан нь парламентад халуун мэтгэлцээний сэдэв болов. Шинээр байгуулагдсан радио станцууд нь маш хурдан хугацаанд хүчтэй дагалдагчидтай болж, хот, хөдөөгийн аль алинд нь хүмүүсийн хүчтэй дуу хоолой болж буйг улс төрчид хүлээн зөвшөөрч байлаа. Сонгууль сурвалжлах

асуудлыг үр дүнтэй авч хэлэлцэхгүй бол

2004 онд төлөвлөгдсөн Ерөнхийлөгчийн, бүх нийтийн сонгуультай зэрэгцэн улс төрийн хөндлөнгийн оролцоо нь хүйн радиогийн хөгжлийн ололтуудыг үгүй хийх эрсдэл дагуулж байв. Үүний эсрэг хариу арга хэмжээ болгон хүйн радиогийн салбарын “Зохицуулах бүлэг” хүйн радиогийн салбар дахь бүх тоглогчдыг хамруулан үндэсний хэмжээний цуврал зөвлөгөөнийг санаачлан зохион байгуулсан юм. Зохицуулах бүлэг хожим нь хүйн радиогийн салбарын зохицуулагч болсон “FORCOM”-ын анхны шанг татсан билээ. Үүнд хараат бус хоршоо, иргэдийн байгууллагад тулгуурласан, шашны шинж чанар бүхий



сүмийн эзэмшлийн, хүй олонд зориулагдсан Нийгмийн харилцааны хүрээлэн (ICS)-гийн хариуцсан төрийн эзэмшлийн радио станцууд хамрагджээ. Үр дүнд нь сонгуулийн үеэр хүйн радиогийн салбарын өөрийн зохицуулалтад зориулагдсан баримтлах зарчим буюу 10 дүрэм бүхий Сонгууль сурвалжлах ёс зүйн кодыг хүлээн зөвшөөрчээ. Эдгээр дүрмийг үндэсний хэмжээнд Засгийн газрын Хэвлэлийн албаны захирлын (GABINFO) оролцоотой, орон нутагт радионууд өөрсдөө дагаж мөрдөнө.

2003 оны орон нутгийн сонгуулийн кампанит ажлын үеэр, Хэвлэл мэдээллийн хөгжлийн төсөл нь Сонгууль сурвалжлах ёс зүйн кодыг хэрхэн баримталсанд болон Дондо, Чимойо, Гуамба зэрэг тусгай гурван мужид хүйн радиог тойрсон ерөнхий уур амьсгалд судалгаа хийжээ. Амьдрал дээр дийлэнх радио Ёс зүйн кодог тусгасан дүрмийг дагаж мөрдсөн байна. Харин төрийн мэдлийн радио станцууд эрх барьж буй FRELIMO намын талаар нэмэлт мэдээ, сурвалжлага ээлтгэх талаар үндэсний хэмжээний улс төрийн удирдагчдын шаардлагыг биелүүлэхэд хүрчээ. Судлаачдын дүгнэлтээр бол хүйн радио нь нийгмийн бүтээн байгуулалтын хэрэглүүр болохын хувьд түүний хүч чадлыг

ОНЦЛОГ ШИНЖ

- Сонгууль сурвалжлах өөрийн зохицуулалтын Ёс зүйн кодтой
- Хүйн радиогийн салбар доторх хэлэлцүүлгээр боловсруулагдсан
- Улс төрийн нөлөөллийг сөрж давахад нь хүйн радио станцуудад тусалсан
- Улс төрийн гол намуудын тухай шударга сурвалжлагыг бэхжүүлсэн

ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- The Media Project - Mozambique
<http://www.mediamoz.com>
- UNESCO/UNDP (2003) Participation by community radios in civic education and electoral coverage – the experience of the community radios in Mozambique's 2003 local elections <http://www.mediamoz.com/ME/doc/creeng.pdf>
- UNESCO (2004) National community radio network established in Mozambique
http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=15702&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html

ХОЛБОО БАРИХ

Бенильде Халевило, FORCOM-ын захирал
Benilde.Nhalevio@gmail.com
Биржит Жаллов
birgitte.jallov@mail.dk

харуулахын зэрэгцээ орон нутгийн сонгуульд өрсөлдөгч хүчнүүдийн анхаарлын төвд байсан. Сонгуульд өрсөлдөн бие биеэ сөрж буй намуудын шахалт шаардлагатай тулгарч байсан учир Ёс зүйн код боловсруулсан нь цагаа олсон, ашигтай санал санаачилга байсан ажээ.

Ёс зүйн кодын агуулгыг Африкийн бусад улс оронд тохируулан ашиглаж болох юм. Гэхдээ, хүйн радиогийн сонгуулийн үйл явц дахь оролцоог зохицуулж буй өнөөгийн дүрэм, бусад журам, зүйл заалтын талаар тунгаах, мэтгэлцэхийн чухлыг судалгаанд тэмдэглэсэн байна. Мозамбикт ёс зүйн кодыг өөрийн зохицуулалтын хэрэглүүрийнх нь хувьд батлан, хэрэгжүүлж буй нь салбарын эзэмшлийг хүлээн зөвшөөрөх, зөвшилцөлд хүрэх талаарх зөвлөлдөх үйл явц дахь үр дүнгийн нэгээхэн хэсэг билээ.





ТИМОР–ЛЕСТЕ УЛС: Ракамбиа радио (Radio Rakambia) – шинэ улсыг бүтээн босгож буй залуусын дуу хоолой

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ракамбиа (Rakambia) радио нь Тимор-Лесте улсын нийслэл Дили хотноо байрладаг, оюутан, залуучууд удирддаг хүйн радио юм. Ракамбиа радио нь энх тайван, боловсрол, хөгжилд анхаарлаа төвлөрүүлдэг. 1999 онд Тиморын тусгаар тогтнолыг авчирсан зөрчилдөөний дараах сэргээн босголтын үеэр залуучуудын дуу хоолойны баталгаа болсон гол газар юм. Тус радио нь бичиг үсэгт тайлагдах, олон соёлыг дэмжихэд онцгой анхаарал хандуулдаг. Ракамбиа радио нь хэвлэл мэдээллийн эрх зүй, зохицуулалтын асуудлаар салбарыг төлөөлдөг Тимор-Лестийн Хүйн радиогийн холбоо (ARKTL)-г байгуулахад чухал үүрэг гүйцэтгэжээ.

Тимор-Лестегийн хүйн радионууд үндэсний бүтээн байгуулалт, зөрчилдөөний дараах сэргээн босголтод маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Түүн дотор нийслэл Дили хот дахь, оюутан, залуучуудын дуу хоолой болсон Ракамбиа радио онцгой ялгардаг.

1999 онд Индонез улсаас салан тусгаарлахын төлөө явуулсан цуут санал хураалтын дараа Тимор-Лесте зөрчилдөөнт хүчирхийлэлд нэрвэгдсэн билээ. Индонезийн цэрэг хүчний дэмжлэгтэй тусгаар тогтнолын эсрэг хүчнүүд амьдрал, дэд бүтцийг сүйтгэж, хэдэн зуун мянган хүмүүсийг шахан зайлуулж, дэлхийг цочроосон үйл ажиллагаа явуулсан байна. Үүний дараа НҮБ-ын удирдлага дор өрнөсөн сэргээн босголтын үйл явцад, урьд өмнө нь хараат бус хэвлэл мэдээллийн уламжлалгүй

энэ улс оронд хүйн радиог хөгжүүлэх асуудал тэргүүн эгнээнд тавигджээ. Ракамбиа радио нь 2001 онд үйлдвэрчний эвлэлийн тусламжийн байгууллага болох “Австрали хүмүүс хилийн чанад дахь эрүүл мэндийн боловсрол, хөгжлийн төлөө” APHEDA байгууллагын дэмжлэгтэй байгуулагджээ.

Ракамбиа радио нь өөрчлөлтийн төлөө идэвхжүүлэгч болохуйц залуусын шийдвэрлэх үүргийг хүлээн зөвшөөрснөөс үүсэлтэй. Залуучууд, ялангуяа оюутнууд радиогийн удирдлагад голлох үүрэгтэй, түүний тогтвортой байдлыг хангахад жинтэй хувь нэмэр оруулж байна. Оюутнуудыг радиогийн сургалтанд хамрагдах, сайн дурын ажилтан болохыг дэмждэг ч Ракамбиа радиогийн залуус дотор сургууль, коллеж завсардсан

залуус байдаг ба радио нь тэдний хувьд дахин суралцах боломжийг олгож байгаа юм. Залуу идэвхтнүүд, оюутнууд Удирдах зөвлөлд ажиллаж, хөрөнгө босгох, радиодоо орлого оруулахын тулд киноны тусгай үзвэр гэх мэт арга хэмжээ зохион байгуулах, түүнчлэн энх тайван, зөрчилдөөн, дуу хөгжим болон спортын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх замаар залуу дэмжигчдийн баг бүрдүүлэхэд жинтэй үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн радио станцыг засгийн газар, хандивлагч байгууллагууд хэсэгчлэн дэмждэг бөгөөд зар сурталчилгаа, төлбөртэй зарлал, мөн студи, дуу чимээний систем, хөгжмийн тоног төхөөрөмжөө түрээслэн мөнгө олдог байна.

Хүн амын тэн хагасаас илүү хувь нь бичиг үсэгт тайлагдаагүй улс оронд Ракамба радио нь боловсролын асуудалд онцгойлон

анхаардаг. Тус радио мөн арьс өнгөний үзлийг намжаах, Лоро Муну болон Лоро Сае дүүргүүдийн соёл хоорондын ойлголцлыг дэмжихийг эрмэлздэг ажээ. Өдөр тутам өргөн нэвтрүүлгийнхээ 15-16 цагийг Дилид дамжуулахын хажуугаар улс орны алслагдсан бүсэд хүрэх, тэнд болж буй хүй олны үйл явдлыг сурвалжлахын тулд хөдөлгөөнт радиогийн төхөөрөмж ашигладаг. Ингэснээр, хөдөөгийн тосгодод нийтийн хэрэгцээ бий болгох боломжтой болж, боловсролын хүртээмжийг дэмжих, 2006 оны үймээний үеэр хийсэнчлэн нягт нямбай мэдээ, мэдээлэл хүргэх замаар зөрчлийг намжаах үйлсэд амжилт олжээ. Ракамба радио нь мөн хэвлэл мэдээллийн бодлогын асуудлаар салбарынхаа дуу хоолойг үндэсний хэмжээнд хүргэхийн тулд бусад 15 хүйн радиотой хамтарч сүлжээ байгуулсан байна.

ОНЦЛОГ ШИНЖ

- Оюутан, залуучууд хүйн радиог удирддаг
- Үндэсний бүтээн байгуулалт, хөгжилд нэмэрлэж буй залуусын дуу хоолой
- Бичиг үсэгт тайлагдах, боловсрол, энх тайван болон зөрчилдөөнийг арилгах чиглэлээр төвлөрч ажилладаг
- Засгийн газар, хандивлагч байгууллагын дэмжлэг, өөрийн санхүүжилт


ЛАВЛАГАА, ХОЛБООСУУД

- APHEDA (2007) Building community radio
http://www.apheda.org.au/projects/easttimor/pages/1068704698_15221.html

ХОЛБОО БАРИХ

Ракамба радио, Kampung Alor,
Дили хот, Зүүн Тимор
Утас: +670 7243674
Электрон шуудан: radiatorakambia@gmail.com





Нэгдсэн Үндэстний Байгууллагын
Боловсрол, шинжлэх ухаан,
соёлын байгууллага

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЛБАР



9 789230 011352